

# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ–2013



Олон Улсын  
Санхүүгийн Корпораци  
Дэлхийн Банкны Групп



**LUX  
DEV**  
Luxembourg Agency for  
Development Cooperation

# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОПЬ–2013

Улаанбаатар 2014 он



Олон Улсын  
Санхүүгийн Корпораци  
Дэлхийн Банкны Групп



LUX  
DEV  
Luxembourg Agency for  
Development Cooperation

Эмхтгэсэн: Ж.Үнэнбат

**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ-2013**

“Тус номыг Олон улсын санхүүгийн корпорацийн дэмжлэгтэйгээр хэвлэж, олны хүртээл болгов.”

© Ж.Үнэнбат, Улаанбаатар хот, 2014 он  
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: М.Мөнх-Эрдэнэ

“Интерпресс” ХХК-д хэвлэв. 2014 он

## ӨМНӨХ ҮГ

---

Миний бие Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан үнэт цаасны салбарт хэрэглэгддэг олон тооны чухал нэр томъёо, концепцийг агуулсан “Хөрөнгийн зах зээлийн нэр томъёоны тайлбар толь-2013” бэлэн болсныг та бүхэнд дуулгаж байгаадаа таатай байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх, дүрэм журам, шийдвэр гаргах, хяналт тавих, ажиглалт хийх, бодлогын уялдааг хангах, хууль тогтоомжийг мөрдүүлэх замаар тогтвортой хөгжил бүхий санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх зорилготой бөгөөд зохицуулалт хийх үндсэн үүрэг бүхий байгууллага юм. Санхүүгийн тогтвортой байдлыг хангахад оруулдаг хувь нэмэр нь зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд сайтар хяналт тавьж, санхүүгийн тогтвортой байдалд учирч болзошгүй аюул занал, эрсдэлийг олж илрүүлэн зохих арга хэмжээ авахад оршдог.

Хэдийгээр дунд түвшний орлоготой улсын тоонд ордог ч Монгол улсын эдийн засаг өндөр хурдацтайгаар өсч байна. Арвин баялаг, ашигт малтмалын нөөц гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж байгаа учир тун удахгүй Монгол улс урьд өмнө нь хэзээ ч тохиогоогүй их хэмжээний гадаадын шүүд хөрөнгө оруулалт бүхий орон болж болох юм. Энэхүү байгалийн их баялаг Монгол улсыг богино хугацаанд Азийн дараагийн бар улс болох боломжийг олгож байна.

Гэхдээ нийтэд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг баталгаажуулахад хатуу чанга зохицуулалт, үндэсний зохистой стратеги төлөвлөлт туйлын чухал. Үүний тулд хүний нөөц, чадавхийг бэхжүүлэх, удирдлагын үр чадварыг дээшлүүлэх, түүнчлэн ашиг сонирхлын зөрчилгүй итгэл үнэмшил зэрэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй болж ирж байна.

Санхүүгийн зохицуулах хороо, Хорооны Үнэт цаасны газрын ирэх жилүүдэд баримталбал зохих хамгийн тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлуудын тоонд үр ашиг бүхий бодлого, санхүүгийн салбарын зохицуулалт, хяналтыг сайжруулах, үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зэрэг асуудал орно. Ил тод, үр ашигтай байх зарчим баримтлан өсч хөгжиж буй үнэт цаасны салбар, түүгээр зогсохгүй нийт санхүүгийн салбарын хувьд хамгийн чухал асуудал бол нэгдсэн ойлголт, үнэт зүйлс байх болно.

Энэхүү нэр томъёоны тайлбар толь нь үнэт цаасны зах зээл дээр хэрэглэгдэж буй ойлгоход төвөгтэй нэр томъёо, ойлголтыг нэг мөр болгон цэгцлэх зорилго агуулсан бөгөөд ийм алхам хийгдээгүй нөхцөлд, зах зээлд оролцогч талуудын хооронд харилцан үл ойлголцол бий болох, улмаар зөрчилд ч хүргэх эрсдэлтэй. Монгол улс эдийн засгийн хөгжлийнхөө маш чухал үе шатанд тулж ирээд байна.


Ийм ч учраас хөрөнгийн зах зээлийн нэр томъёоны тайлбар толь нь Монгол улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах юм. Төгсгөлд нь бидэнтэй нягт хамтран ажилласан түншүүд, нэн ялангуяа Үнэт цаасны нэр томъёоны тайлбар толийг боловсруулсан ажлын хэсгийн нийт гишүүддээ Монгол улсын санхүүгийн салбарын хөгжилд оруулсан үнэлж баршгүй хувь нэмрийг нь өндрөөр үнэлж байгаагаар чин сэтгэлээсээ илэрхийлэхийг хүсч байна.

***Д.БАЯРСАЙХАН, СЗХ-НЫ ДАРГА***

## АГУУЛГА

---

1. Өмнөх үг
2. Хөрөнгийн зах зээлд түгээмэл хэрэглэгддэг нэр томъёоны товч тайлбар
4. Компанийн засаглалд түгээмэл хэрэглэгддэг нэр томъёоны товч тайлбар



# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ТҮГЭЭМЭЛ ХЭРЭГЛЭГДДЭГ НЭР ТОМЪЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР

## 1. ABC system – Эй-Би-Си систем

Хөрөнгө оруулсан үнийн дүнгээр 3 хэсэгт хувааж бараа материалын нөөцийг ач холбогдлоор нь удирдах арга техник.

## 2. Ability to service debts – Өр төлөх чадвар

Компаниас өрөө, төлбөрийн хуваарийн дагуу төлөх чадварыг харуулна.

## 3. Acceptance – Хүлээн авалт

Шилжүүлгийн системд, эх үүсвэр, үнэт цаасны төлбөрийг даалгавраар дамжуулан цаашдын боловсруулалтад оруулах үйл явц. Картын системд тухайн брэндийн картыг аливаа терминал, худалдааны газар, байгууллагаас хүлээж авч буй үйл явц.

## 4. Acceptor – Хүлээн авагч

Өөрт нь буюу бусад байгууллагад шилжүүлэх зорилгоор харилцагчийн өгсөн төлбөрийн хэрэгслийг хүлээж авч байгаа худалдааны болон бусад байгууллага.

## 5. Accept-reject approach – Хүлээж авах, татгалзах арга

Хөрөнгө зарцуулалтын саналыг компаниас тогтоосон босго шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлэх.

## 6. Accounting earnings – Бүртгэлийн ашиг

Орлогын тайланд тусгагдсан компанийн ашиг.

## 7. Accrual method – Аккреул суурьт арга

Борлуулалтыг хийх үед нь орлогод тооцож, зардалыг гарах үед зардалд тооцох арга.

A

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



A

**8. Accruals – Хуримтлагдсан өр**

Нэгэнт хүлээж авсан үйлчилгээндээ төлөх компанийн өр төлбөр.

**9. Acquirer (card acquirer) – Авагч (Карт авагч)**

Худалдааны цэгийн (POS) гүйлгээнд хүлээн авагчаас (гол төлөв худалдааны байгууллага) картын төлбөрийг гүйцэтгэх зорилгоор дамжуулсан шаардлагатай мэдээллийг авагч байгууллага (гол төлөв банкны байгууллага). Бэлэн мөнгөний машины (АТМ) гүйлгээнд өөрөө шууд буюу бусад байгууллагаар дамжуулан бэлэн мөнгө гарган өгөгч байгууллага (гол төлөв банкны байгууллага).

**10. Acquiring company – Худалдан авч буй компани**

Нэгтгэх гүйлгээний үед өөр компанийг өөртөө нэгтгэхийг оролдож буй компани.

**11. Active management – Идэвхитэй удирдлага**

Үнэт цаасны зах зээлийн ерөнхий хандлагыг таамаглах оролдлого. Үнэ нь буруу тогтоогдсон үнэт цаасыг хайх оролдлого

**12. Active portfolio – Идэвхитэй багц**

Трейнор-Блакийн загварын хүрээнд тэгээс дээш альфа бүхий шинжлэгдсэн хувьцаануудыг нийлүүлж бүрдүүлсэн багц. Энэхүү багцыг зах зээлийн индекс бүхий идэвхигүй багцтай эцэст нь нийлүүлдэг .

**13. Activity ratios – Үйл ажиллагааны харьцаа**

Төрөл бүрийн дансуудын борлуулалтанд хөрвөх буюу бэлэн мөнгөний орох гарах урсгалд хөрвөх хурдыг хэмжинэ.

**14. Adjustable-rate (or floating-rate) preferred stock (ARPS) – Зохицуулах (хөвөх) ногдол ашиг давуу эрхтэй хувьцаа**

Ногдол ашгийн хувь хэмжээ нь Засгийн газрын үнэт цаасны хүүтэй уягдсан давуу эрхтэй хувьцаа.

**15. After-tax proceeds from sale of old asset – Хуучин хөрөнгийг зарсны татварын дараах орлого**

Хуучин хөрөнгө зарсан үнийн дүнгээс татварыг хасч тооцно.

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

#### 16. Agency costs – Зуучлагчийн зардал

Эзэмшигчдийн өмчийг хамгийн их болгож, зуучлагчийн асуудлыг хамгийн бага түвшинд байлгах засаглалын бүтцийг хэрэгжүүлэхийн тулд хувьцаа эзэмшигчдээс гарах зардал.

#### 17. Agency problem – Зуучлагчийн асуудал

Компанийн удирдлагаас өөрийн хувийн зорилгоо компанийн зорилгоос дээгүүрт тавих магадлалыг хэлнэ.

#### 18. Aggressive financing strategy – Санхүүжилтийн түрэмгий стратеги

Компаниас хамгийн багадаа эргэлтийн активын улирлын хэрэгцээгээ бүрэн, байнгын хэрэгцээний зарим хэсгийг богино хугацаатай эх үүсвэрээр санхүүжүүлж, үлдэх бүх хэрэгцээгээ урт хугацаатай эх үүсвэрээр санхүүжүүлэх стратеги.

#### 19. Aging – Авлагын наслалт

Авлагын дансны үлдэгдлийн хэдэн хувь ямар хугацаагаар хэтрээд байгааг тодорхойлох замаар компанийн эзэлийн болон авлага цуглуулах бодлогыг үнэлэх арга техник.

#### 20. AGM/EGM-proxy voting – Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал – Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн санал

Хувьцаа нээлттэйгээр худалдаалагдсан бүх компаниуд хувьцаа эзэмшигчдийн ээлжит (жил бүр) хурал хийдэг бөгөөд хурал дээр удирдлагууд хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөл хэрэгтэй шийдвэрүүдийг танилцуулдаг. Шийдвэрийг зөвшөөрсөн эсвэл эсрэг гэсэн санал хураалт хийх замаар олгодог. Хувьцаа эзэмшигчид хуралд өөрийн биеэр эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөр дамжуулж оролцож болно.

#### 21. Alpha – Альфа

Хөрөнгө активын үнэлгээ ба арбитражийн үнэлгээний гэх мэт тэнцвэрийн загваруудаар урьдчилан тодорхойлноос илүү хэмжээтэйгээр гарсан үнэт цаасны хэвийн бус өгөөжийн хувь.

#### 22. Ancillary system – Туслах систем

Төлбөр болон үнэт цаас нь харилцан солилцож суутгагддаг систем.

A

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

А

**23. Annual cleanup – Үлдэгдлийн жилийн цэвэрлэгээ**

Зээлийн шугамыг жилийн хугацаанд тодорхой хоногоор үлдэгдэлгүй (компаниас банкинд өргүй) байлгах шаардлага.

**24. Annual percentage rate – Жилийн хүүгийн хувь**

Энгийн хүүгээр тооцсон жилийн хүүгийн хувь.

**25. Annual percentage rate (APR) – Жилээр тооцсон хүүгийн хувь**

Үеийн (сарын) нэрлэсэн хүүг 1 жилийн доторхи үеүдийн (сарын) тоогоор үржүүлэн жилд шилжүүлж “Шударга зээллэгийн хуулийн” дагуу мэдэгдэх ёстой хүүгийн хувь.

**26. Annual percentage yield (APY) – Жилээр тооцсон өгөөжийн хувь**

“Шударга хадгаламжийн хуулийн” дагуу банкнаас харилцагчиддаа мэдэгдэх ёстой, хадгаламжийн бүтээгдэхүүндээ тогтоож, жилд шилжүүлсэн, жинхэнэ хүүгийн хувь.

**27. Annualized net present value (ANPV) approach – Жилийн цэвэр өнөөгийн үнэлэмжийн (үнэ цэнийн) арга**

Өөр хоорондоо харилцан адилгүй хугацаанд хэрэгжих төслүүдийг харьцуулж үнэлэхийн тулд цэвэр өнөөгийн үнэлэмжийг жилд шилжүүлэн үнэлэх арга.

**28. Annuity – Үе тутмын төлбөр**

Үе тутам тэнцүү хэмжээтэй мөнгөн дүнгээр хийгдэх төлбөрийн орох, гарах урсгал.

**29. Annuity due – Үе тутмын төлбөрийн өглөг**

Үе тутмын эхэнд хийгдэх төлбөр.

**30. Arbitrage – Арбитраж**

Үнэ нь харьцангуй буруу тогтоогдсон үнэт цаасны арилжаагаар дамжуулан ашиг олох үйл явц, гол төлөв хоёр өөр зах дээр түргэн хугацаанд олон тооны арилжаа хийж ашиг олох үйл явц.

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**31. Arbitrage pricing theory – Арбитражийн үнэлгээний онол**

Хөрөнгийн зах зээл томрох тусам арбитражийн боломж үгүй болох нөхцөл дээр тулгуурласан эрсдэл-өгөөжийн хамаарлын онол.

**32. Articles of partnership – Хамтын ажиллагааны дүрэм**

Нөхөрлөлийн бизнесийн харилцааг зохицуулдаг албан ёсны гэрээ.

**33. Ask price – Зарах үнэ**

Үнэт цаасыг худалдахаар дилерээс санал болгож байгаа үнэ.

**34. Asset allocation – Хөрөнгийн хувиарлалт**

Хөрөнгө оруулалтын багцыг активын ерөнхий ангиллаар хуваарилах үйл явц.

**35. Asset allocation funds – Актив хуваарилалтын сан**

Багцын менежерийн таамаглалд үндэслэн активыг сонгож хөрөнгө оруулдаг хамтын сангийн хэлбэр.

**36. Asset servicing – Активын үйлчилгээ**

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас санхүүгийн хэрэгслийн кастодиан болон хадгаламжийн үйлчилгээ, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад үйлчилгээ.

**37. Asset turnover (ATO) – Активын эргэлт**

Активын төгрөг тутмаас бий болгох жилийн борлуулалтын хэмжээ. (Борлуулалт/Актив)

**38. Asset universe (Universe of securities) – Активын ертөнц (Үнэт цаасны ертөнц)**

Багцын менежерээс хөрөнгө оруулж болох батлагдсан активын (үнэт цаасны) жагсаалт.

**39. Assignment – Үүрэг гүйцэтгүүлэх**

Компанийн актив, эд хөрөнгийг зарж борлуулах ажлыг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх зээлдүүлэгчдийн шийдвэр.

A

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

A

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**40. Assimilation - Шингээлт**

Хуучин гаргасан хувьцаан дээрээ шинээр хувьцаа нэмж гаргах ба эхэн үедээ шинэ гаргасан хувьцаа нь хуучин хувьцаатайгаа нэг түвшинд байхгүй ба шингээлт хийсний дараа шинээр гаргасан хувьцаа нь хуучин хувьцаатайгаа яг ижил эрхтэй болсон байна.

**41. Asymmetric information - Мэдээллийн тэнцвэргүй байдал**

Компанийн үйл ажиллагаа ирээдүйн төлөвийн талаар удирдлага нь хөрөнгө оруулагчдаасаа илүү мэдээлэлтэй байх байдал.

**42. At the money - Мөнгөндөө тохирсон**

Хэрэгжүүлэх үнэ, активын үнэ хоёр нь тэнцүү опцион.

**43. Auction market - Үнэ хаялцуулах зах зээл**

Үнэт цаасны наймаачид нэг дор цугларч худалдах, худалдан авах арилжаа хийдэг газар.

**44. Authentication - Нотолгоо**

Хувь хүн болон байгууллагын:

- 1) Жинхэнэ нэр хаяг,
- 2) Эрх мэдлийг илрүүлж танидаг хамгаалалтын механизм.

**45. Authorisation - Зөвшөөрөл**

Эх үүсвэр болон үнэт цаас шилжүүлэхийг оролцогчоос (эсвэл оролцогчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах гуравдагч этгээдээс) өгсөн зөвшөөрөл.

**46. Authorized shares - Зөвшөөрөгдсөн хувьцаа**

Компанийн дүрмийн дагуу гаргахыг зөвшөөрсөн хувьцааны тоо.

**47. Auto-collateralisation - Автомат барьцаалалт**

Үнэт цаас худалдан авагчаас дараагийн тооцооны мөчлөгийн үед эх үүсвэр нь хүрэлцэхгүй нөхцөлд (авсан үнэт цаасыг нь барьцаалан) автоматаар олгогддог зээл.

**48. Automated clearing house (ACH) – Автомат клирингийн байгууллага**

Оролцогчдын хооронд төлбөрийн даалгавруудыг солилцож цахим хэлбэрээр харилцан суутгадаг систем.

**49. Automated teller machine (ATM) – Бэлэн мөнгөний машин**

Зөвшөөрөлтэй хэрэглэгчдийн уншуулсан картаар бэлэн мөнгө олгох болон бусад үйлчилгээ үзүүлдэг цахилгаан механик төхөөрөмж.

**50. Automatic linking – Автомат холболт**

Үнэт цаасны арилжаанд оролцогч гишүүдээс зохих тэмдэглэл хийх хэлбэрээр авах зарах үйл ажиллагааг автоматаар холбох үйл явц.

**51. Average age of inventory – Бараа материалын дундаж наслалт**

Бараа материалын борлогдох дундаж хоног.

**52. Average collection period – Авлага цуглуулах дундаж хугацаа**

Дансны авлагыг цуглуулахад шаардагдах дундаж хоног.

**53. Average payment period – Төлбөр гүйцэтгэх дундаж хугацаа**

Дансны өр төлөхөд шаардагдах дундаж хоног.

**54. Average tax rate – Татварын дундаж хувь**

Компанийн төлөх татварыг татвар ногдуулах орлогод харьцуулсан хувь.

**55. Backup system – Нөөцийн систем**

Анхдагч систем доголдох үед түүнийг орлон ажиллах зориулалттай систем.

**56. Balance sheet – Тэнцэл**

Хугацааны тодорхой нэг агшин дахь компанийн санхүүгийн үр дүн.

A

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**57. Balanced and income funds – Орлогын ба тэнцвэртэй хөрөнгө оруулалтын сан**

Өнөөгийн чөлөөт орлогыг нэмэгдүүлэх буюу урт хугацааны өсөлт, өнөөгийн орлогод хохирол учруулахгүйгээр эрсдэлийг багасгахад чиглэсэн хувь хүний багцаар хөрөнгө оруулдаг хамтын сангийн хэлбэр.

**58. Balloon payment – Үндсэн төлбөр**

Хэрэв хугацааны турш зөвхөн хүүгээ төлж ирсэн бол хугацааны эцэст нэг мөсөн төлөх зээлийн үндсэн нийт өрийг хэлнэ.

**59. Bank discount method – Банкны хямдруулалтын арга**

Хөрөнгө оруулалтын өгөөжийг тодорхойлохын тулд үнэт цаасны хямдруулалтыг жилийн 360 хоногт шилжүүлэн тооцож нэрлэсэн үнэд харьцуулдаг жилийн энгийн хүүгийн хувь.

**60. Bank Identifier Code (BIC) – Банк танигч код**

Олон Улсын Стандартын Байгууллагаас санхүүгийн байгууллагыг таниж тогтооход зориулсан техникийн код.

БТК нь найм эсвэл арван нэгэн тэмдэгтээс бүрдэх бөгөөд санхүүгийн байгууллагын код (дөрвөн тэмдэгт), улсын код (хоёр тэмдэгт), байршлын код (хоёр тэмдэгт) болон заавал шаардахгүйгээр, салбарын код (гурван тэмдэгт)-оос бүрддэг.

**61. Banker's acceptances – Банкны зөвшөөрөл**

Бизнесийн төлбөрийг банкнаас баталгаажуулсанд үндэслэсэн богино хугацаатай, бага эрсдэлтэй үнэт цаас.

**62. Bankruptcy – Дампуурал**

Компанийн өр төлбөр нь түүний актив хөрөнгийн зах зээлийн шударга үнэлэмжээс хэтэрснээс үүсэх бизнесийн уналт.

**63. Basis – Суурь**

Ирээдүйн хэлцлийн үнэ ба спот (одоогийн) үнийн зөрүү.

#### 64. Basis risk – Суурийн эрсдэл

Ирээдүйн хэлцлийн үнэ ба спот (одоогийн) үнийн зөрүүгийн тодорхойгүй хөдөлгөөнөөс үүсэх эрсдэл.

#### 65. Batch (bulk payments) – Үндсэн төлбөрөө бөөндөж төлөх

Хамтад нь хийх ёстой бүлэг төлбөрийн даалгавар буюу үнэт цаасны шилжүүлгүүд.

#### 66. Baumol model – Баумолын загвар

Зардлын хувьд үр ашигтай, гүйлгээний зориулалттай мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тодорхойлох загвар. Мөнгөн хөрөнгийн хэрэгцээг урьдчилан тооцож болно гэдэг санаанд үндэслэсэн эдийн засгийн хөрвүүлэлтийн тоог тодорхойлох загвар.

#### 67. Bearer bond – Мэдүүлгийн бонд

Үндсэн ба хүүгийн төлбөрийг эзэмшигчид нь төлдөг, гаргасан этгээд дээрээ бүртгэл хийгддэггүй бонд.

#### 68. Benchmarking – Жишигтэй харьцуулсан шинжилгээ

Салбарын харьцуулсан шинжилгээний нэг төрөл бөгөөд компанийн харьцааны үзүүлэлтийг түүний гол өрсөлдөгчийн буюу жишиг болохуйц бүлэг өрсөлдөгчдийнх нь үзүүлэлттэй харьцуулдаг.

#### 69. Beneficiary – Төлбөр хүлээн авагч (Бенифициар)

Эх үүсвэр буюу үнэт цаасны төлбөр хүлээн авагч. Тухайн нөхцлөөс шалтгаалж төлбөр хүлээн авагч нь төлбөрийн системийн шууд оролцогч эсвэл эцсийн хүлээн авагч байж болно.

#### 70. Best efforts basis – Сайн чармайлтын арилжаа

Хөрөнгө оруулалтын банкнаас андеррайтингийн эрсдэл хүлээхгүйгээр өөрийн нөөц бололцоог ашиглан үнэт цаасыг зарах үйл ажиллагаа. Энэ тохиолдолд ХОБ нь үнэт цаасаа зарж татан төвлөрүүлсэн хөрөнгөний хэмжээнээс хамаарч шимтгэл авна.

#### 71. Beta coefficient (b) – Бета коэффициент

Тархаах боломжгүй эрсдэлийн хэмжүүр. Тухайн активын өгөөжийн өөрчлөлт нь зах зээлийн багцын өгөөжийн өөрчлөлтөөс хэрхэн хамаарч хөдөлж буйг харуулдаг индекс.

a

B

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**72. Bid price – Авах үнэ**

Үнэт цаасыг худалдаж авахаар дилерээс санал болгож байгаа үнэ.

**73. Bid-ask spread – Авах зарахын зөрүү**

Тодорхой үнэт цаасыг худалдан авах ба худалдах дилерээс тогтоосон үнийн зөрүү.

**74. Bilateral net settlement system – Хоёр талын цэвэр тооцооны систем**

Тооцооны системд оролцогч хоёр тал бүхэн тус бүртээ тооцоогоо цэвэршүүлж байдаг систем.

**75. Bill of exchange – Вексель**

Нэг этгээдээс (төлбөрийг шаардагч) тодорхой мөнгөн дүнг тодорхой хугацаанд анхны шаардлагаар нөгөө этгээдэд (төлбөр гүйцэтгэгч) эсвэл төлбөр гүйцэтгэгчийн тодорхойлсон гуравдагч этгээдэд бичгээр өгсөн даалгавар.

**76. Binomial model – Биномын загвар**

Хувьцааны үнэ нь богино хугацаанд зөвхөн хоёр үнэлэмж рүү тэмүүлэхэд хийсвэрлэсэн опционы үнэлгээний загвар.

**77. Bird-in-the-hand argument – Маргашийн өөхөөс өнөөдрийн уушиг**

Хөрөнгө оруулагчид өнөөдрийн ногдол ашгийг ирээдүйн ногдол ашиг ба хөрөнгийн үнэлгээний өсөлтөөс бага эрсдэлтэй гэж үзэх ногдол ашгийн хамаарлын онолыг бататгасан үзэл.

**78. Black-Scholes option pricing formula – Блэк-Шолесийн опционы үнийн томъёо**

Хувьцааны үнэ, эрсдэлгүй хүү, опционы хугацаа, хувьцааны өгөөжийн стандарт хазайлтыг ашиглан опционы үнийг тогтоодог томъёо.

**79. Block transaction – Багцын гүйлгээ**

Их хэмжээний хувьцааг нэгэн зэрэг авах буюу зарах томоохон арилжаа, гүйлгээ.

#### **80. Blocking – Тусгаарлах**

Тодорхой дүнтэй эх үүсвэр болон үнэт цаасны шилжүүлгийг хийхэд хаалт тавих үйл явц.

#### **81. Blue sky laws – Хөх тэнгэрийн хууль**

Хөрөнгө оруулагчдыг хамгаалах зорилгоор үнэт цаасны арилжааг дотооддоо зохицуулдаг муж улсын хууль.

#### **82. Board of directors – Захирлуудын зөвлөл (төлөөлөн удирдах зөвлөл)**

Компанийн стратегийн зорилго, төлөвлөгөөг тодорхойлох, ерөнхий бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх, үндсэн зарцуулалтыг батлах, голлох удирдах ажилтнуудыг авах / халах, хөлсөлж ажиллуулах, хяналт тавих үүрэг бүхий хувьцаа эзэмшигчдээс сонгогддог бүлэг этгээд.

#### **83. Bogy – Жишиг өгөөж**

Хөрөнгө оруулалтын менежерээс амжилтаа үнэлэхийн тулд жишиг болгон ашигладаг өгөөж.

#### **84. Bond – Бонд (өрийн бичиг)**

Янз бүрийн хөрөнгө оруулагчдаас (зээлдүүлэгчдээс) мөнгөн хөрөнгө татахын тулд бизнесийн байгууллага болон засгийн газраас гаргадаг урт хугацаат өрийн хэрэгсэл.

#### **85. Bond equivalent yield – Бондтой адилтгасан жилийн хүү**

Бондтой адилтгасан жилийн энгийн хүүгийн (өгөөжийн) хувь.

#### **86. Bond indenture – Бондын гаргалтын нөхцөл**

Бондыг гаргасан нөхцөлийг заасан эрх зүйн баримт бичиг.

#### **87. Bond-refunding decision – Бондыг эргэн санхүүжүүлэх шийдвэр**

Бондын хүү зах зээл дээр буурмагц урьд нь гаргасан бондоо эргэн дуудаж бага хүүтэй шинэ бондоор солин санхүүжүүлэх эсэх шийдвэр.

#### **88. Bonus Issue – Урамшууллын үнэт цаас**

Компани нэмэлт үнэт цаас гарган одоо байгаа хувьцаа эзэмшигчдэд үнэгүй олгох.

a

**B**

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**89. Bonus Rights – Нэмэлт эрх**

Одоо байгаа хувьцаа эзэмшигчиддээ шинээр гарах хувьцааг хөнгөлттэй нөхцлөөр авах эрхийг олгох.

**90. Book value – Бүртгэлийн өртөг**

Хөрөнгийн суурилуулалтын зардлаас хуримтлагдсан элэгдэлийг хасаж гаргадаг хөрөнгийн бүртгэлийн хатуу өртөг.

**91. Book value per share – Нэгж хувьцааны бүртгэлийн үнэлгээний арга**

Компанийн бүх активыг бүртгэлийн үнээр нь зарж бүх өр төлбөрөө (давуу эрхтэй хувьцааны өглөгийг оруулаад) төлөөд үлдэх мөнгийг энгийн хувьцааны тоонд хуваасан дүн буюу нэгж энгийн хувьцааны бүртгэлийн үнэлгээ.

**92. Book value weights – Бүртгэлийн үнэлгээний жин**

Компанийн эд хөрөнгөөс (активаас) өр төлбөрийг хассан үнэлгээн дээр тулгуурласан жин.

**93. Book-entry transaction – Бүртгэлийн гүйлгээ**

- 1) Үнэт цаасны хувьд гэрчилгээг биетээр шилжүүлэхгүйгээр дебет, кредит гүйлгээ хийх үйл явц;
- 2) Төлбөрийн хувьд харилцагчийн даалгавраар банкны байгууллагаас хийдэг дебет, кредит гүйлгээ.

**94. Break-even analysis (cost-volume-profit analysis) – Хугарлын цэгийн шинжилгээ (зардал-тоо хэмжээ-ашгийн хамаарлын шинжилгээ) Шинжилгээг ашиглан:**

- 1) Үйл ажиллагааны зардлыг нөхөхүйц борлуулалтын түвшинг тодорхойлно;
- 2) Борлуулалтын янз бүрийн түвшин дэх ашигт ажиллагааг тодорхойлно.

**95. Breakeven cash inflow – Хугарлын цэгийн мөнгөн урсгал**

Төслийг хүлээн зөвшөөрөхөд шаардагдах мөнгөн орлогын хамгийн бага хэмжээ  $NPV > \$0$ .

#### 96. **Breaking point** – Хугарах цэг

Шинээр авах санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн аль нэгний нь зардал өсөх санхүүжилтийн түвшин. Энэ нь капиталын жигнэсэн ахиуц өртөг дээшээ шилжих шалтгаан болно.

#### 97. **Breakup value** – Салгалтын үнэлэмж

Үйл ажиллагааны нэгж тус бүрийг тусад үнэлсэн нийлбэрээр тодорхойлогдох компанийн үнэлэмж.

#### 98. **Breath of a market** – Зах зээлийн цар хүрээ

Оролцогчдын тооноос хамаарсан зах зээл.

#### 99. **Budget deficit** – Төсвийн дутуудал (алдагдал)

Засгийн газрын төсвийн зарлага орлогоосоо илүүдэх хэсэг.

#### 100. **Bundling, unbundling** – Нэгтгэх, задлах

Энгийн ба уламжлагдсан үнэт цаасыг нэгтгэх замаар шинэ эрлийз (гибрид) үнэт цаасыг бий болгох буюу активын ангилал тус бүрээр өгөөжийг задлах.

#### 101. **Business continuity** – Бизнесийн тасралтгүй байдал

Бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй явагдах байдал.

Энэхүү тодорхойлолт нь дараах зорилтыг хангахад чиглэсэн техник зохион байгуулалт, хүний нөөцийн арга хэмжээ:

- 1) Хямралын дараа бизнесийн үндсэн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх;
- 2) Хурц хямралын дараа бизнесийн бүхий л үйл ажиллагаа аажмаар сэргэж үргэлжлэх үйл явц.

#### 102. **Business cycle** – Бизнес мөчлөг, эргэлт

Эдийн засгийн уналт сэргэлтийн дахин давтагдах мөчлөг.

#### 103. **Business risk** – Бизнесийн эрсдэл

Эдийн засгийн таагүй орчноос шалтгаалан үйл ажиллагааны зардлаа нөхөж чадахгүйд хүрэх эрсдэл.

a

**B**

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**104. Buy-back program (BIDS) / Repurchase Offer - Буцааж худалдаж авах програм / Дахин худалдаж авах санал**

Компаниас хувьцаа эзэмшигчдэд компанийн мэдлийн хувьцааг дахин худалдаж авах эсвэл бусад үнэт цаасыг хувьцаа руу хөрвүүлж авахыг санал болгодог. Ингэснээр эргэлтэд байгаа хувьцааны хэмжээ буурдаг.

**105. Call feature - Эргэн дуудагдах нөхцөл**

Бонд гаргагчаас бондын хугацаа дуусахаас өмнө тогтоосон үнээр буцаан худалдаж авах эрхийг заасан компанийн бондын түгээмэл нөхцөл.

**106. Call option - Худалдаж авах опцион**

Тодорхой эд хөрөнгийг (активыг) тогтоосон үнээр тогтоосон хугацааны өмнө эсвэл эцэст худалдан авах эрх.

**107. Call premium - Эргэн дуудалтын урамшуулал**

Бондын эргэн дуудагдах үнэ нь нэрлэсэн үнээс хэтэрсэн зөрүү.

**108. Call price - Эргэн дуудагдах үнэ**

Бондыг буцааж худалдаж авч болзошгүй тогтоосон үнэ.

**109. Callable bond - Эргэн дуудагдах бонд**

Эргэн дуудагдах хугацааны хооронд бондыг гаргагчаас буцааж худалдаж авах нөхцөлтэй бонд.

**110. Cap (limit) - Хязгаарлалт**

Системд оролцогчдын эх үүсвэр үнэт цаасны гүйлгээнд тавьдаг тоон хязгаарлалт.

**111. Capital - Капитал (Хөрөнгө)**

Компанийн урт хугацаатай эх үүсвэр. Тэнцлийн баруун талын үзүүлэлтийн дүнгээс урсгал өрийг хассан дүн.

**112. Capital allocation line - Хөрөнгө хуваарилалтын шугам**

Багцыг эрсдэлгүй актив ба эрсдэлтэй багцаар хосолсон олон төрлийн хувилбаруудад хуваарилан харуулсан, эрсдэл-өгөөжийн өгөгдлийг холбосон зураас.

### **113. Capital asset pricing model (CAPM) – Хөрөнгө активын үнэлгээний загвар (CAPM)**

Шаардагдах өгөөж буюу энгийн хувьцааны өртөг болон компанийн тархаагдахгүй эрсдэлийн (бэга итгэлцүүрээр хэмжигдэх) хоорондын харилцааг илэрхийлнэ.

### **114. Capital budgeting – Капиталын төсөвлөлт**

Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг хамгийн их болгох компанийн зорилготой нийцсэн урт хугацааны хөрөнгө оруулалтуудыг сонгох ба үнэлэх үйл явц.

### **115. Capital budgeting process – Капиталын төсөвлөлтийн үе шатууд**

Санал боловсруулах, шалгах ба шинжлэх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, явцын хяналт гэсэн хоорондоо ялгаатай боловч харилцан холбоотой урт хугацааны хөрөнгө оруулалтуудыг сонгож үнэлэхэд ашигладаг 5 үе шат.

### **116. Capital expenditure – Хөрөнгийн зардал**

Нэгээс дээш жилийн хугацаанд үр ашгаа өгөхөөр хүлээгдэж буй хөрөнгийн зарцуулалт.

### **117. Capital gain – Хөрөнгийн олз**

Эд хөрөнгийг (активыг) зарсан үнэ ба эхлэн худалдаж авсан үеийн үнийн зөрүү.

### **118. Capital market – Хөрөнгийн зах зээл**

Урт хугацаат үнэт цаасны эзэмшигчид болон хэрэглэгчдийг холбодог зах зээл.

### **119. Capital market line – Хөрөнгийн зах зээлийн шугам**

Эрсдэлтэй багцыг зах зээлийн индекс багцаар орлуулсан хөрөнгө хуваарилалтын шугам.

### **120. Capital rationing – Хөрөнгийн хязгаарлалт**

Компанийн санхүүжилтийн эх үүсвэр нь тогтмол учраас хөрөнгө зарцуулалтын өрсөлдөх төслүүдээс сонгож хуваарилах нөхцөл байдал.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**121. Capital structure – Капиталын бүтэц**

Өр төлбөр, өөрийн хөрөнгө гэх мэт компаниас баримталдаг эх үүсвэрийн хольц.

**122. Capitalized lease – Хөрөнгөжүүлсэн түрээс**

Олон улсын бүртгэлийн стандартын дагуу санхүүгийн түрээсийн нийт төлбөрийн өнөөгийн үнэлэмжээр нь тэнцлийн актив болон пассивт нэгэн зэрэг тусгадаг арга.

**123. Card (payment card) – Төлбөрийн карт**

Эзэмшигчиддээ бараа үйлчилгээний төлбөр хийх, бэлэн мөнгө авах боломж олгодог хэрэгсэл.

**124. Card issuer – Карт гаргагч**

Карт эзэмшигчдэд картыг олгож худалдааны цэгийн терминал болон бэлэн мөнгөний машин дээр гүйлгээг зөвшөөрөн хүлээн авагчийн төлбөрийг баталгаажуулдаг санхүүгийн байгууллага.

**125. Card scheme – Картын схем**

Нэг буюу түүнээс дээш брендийн картаар үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техникийн болон арилжааны зохион байгуулалтын систем.

**126. Cardholder – Карт эзэмшигч**

Төлбөрийн карт олгогдож ашиглах эрх авсан этгээд.

**127. Carrying costs – Хадгалалтын зардал**

Нэгж бараа материалыг тодорхой хугацаагаар хадгалахад гардаг хувьсах зардал.

**128. Cash – Мөнгөн хөрөнгө**

Дансны болон бэлэн мөнгө.

**129. Cash bonuses – Бэлэн мөнгөнийн шагнал**

Тодорхой зорилгодоо хүрсэний нь төлөө удирдлагад төлж буй мөнгөн шагнал.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**130. Cash budget (cash forecast) – Мөнгөн хөрөнгийн төсөв (таамаглал)**

Компанийн мөнгөн хөрөнгийн богино хугацааны хэрэгцээг тодорхойлохын тулд хийсэн бэлэн мөнгөний орлого зарлагын тооцоо.

**131. Cash conversion cycle – Мөнгөн хөрөнгийн эргэлтийн мөчлөг**

Компанийн мөнгөн хөрөнгө үйлдвэрлэлийн орцын төлбөрт зарцуулагдсанаас хойш борлогдсон бэлэн бүтээгдэхүүнийн төлбөр орж ирэх хүртэл хугацаа.

**132. Cash conversion models – Мөнгөний эргэлтийн загвар**

Мөнгөн хөрөнгө эзэмших, эсвэл түүнийгээ арилжаалагдах үнэт цаасанд байршуулахын зардал, үр ашгийг харьцуулах замаар эдийн засгийн хувьд оновчтой мөнгөн хөрөнгийн бүтцийг тодорхойлох загвар.

**133. Cash disbursement – Мөнгөн хөрөнгийн зарлага**

Санхүүгийн өгөгдсөн хугацааны дотор шилжүүлсэн компанийн бэлэн мөнгөний зарлага.

**134. Cash discount – Бэлэн мөнгөний хөнгөлөлт**

Зээлийн хугацаанаас өмнө, тогтоосон хугацаанд худалдан авагчаас төлбөрөө хийсэн тохиолдолд үзүүлэх хөнгөлөлт.

**135. Cash discount period – Бэлэн мөнгөний хөнгөлөлтийн хугацаа**

Зээлийн хугацаа эхэлснээс хойш бэлэн мөнгөний хөнгөлөлтийн хугацаа дуусах хүртэл хугацаа.

**136. Cash Dividend – Бэлэн мөнгөөрх ногдол ашиг**

Жилийн эцэст компанийн гүйцэтгэлээс хамааран олсон орлогоос ногдох хувийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон мөнгө хуваарилах.

**137. Cash flow matching – Бэлэн мөнгөний урсгалыг тэнцэтгэх**

Тогтмол орлоготой үнэт цаасны багцаас олох бэлэн мөнгөний орлогоо өр төлбөрийн зарлагатай тэнцэтгэх.

**138. Cash method – Мөнгөн суурьт арга**

Бэлэн мөнгийг бодитойгоор орох болон гарах үед нь орлого зарлагад тооцох арга.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**139. Cash receipts – Мөнгөн хөрөнгийн орлого**

Санхүүгийн өгөгдсөн хугацааны дотор авсан компанийн бэлэн мөнгөний орлого.

**140. Cash settlement agent – Бэлэн мөнгөний тооцооны зуучлагч**

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн хүрээнд үнэт цаасыг шилжүүлэхэд түүнчлэн эх үүсвэрийг шилжүүлгийн системд өөрийн актив болон пассиваа төлбөрийн үүрэг гүйцэтгэхэд ашигладаг байгууллага. Арилжааны болон Төв банк бол бэлэн мөнгөний тооцооны түгээмэл зуучлагчид.

**141. Cash Stock Option – Хувьцааны бэлэн мөнгөний сонголт**

Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаа бэлэн мөнгөөр эсвэл нэмэгдэл шинэ хувьцаа хэлбэрээр авах сонголт.

**142. Cash/bond selection – Бэлэн мөнгө ба бондын сонголт**

Урт хугацаатай үнэт цаас ба мөнгөний зах зээлийн хэрэгсэл хоорондын сонголт.

**143. Central counterparty (CCP) – Төв харилцагч**

Бүх худалдагчийн хувьд худалдан авагч, бүх худалдан авагчийн хувьд худалдагч болж нээлттэй гэрээг баталгаажуулан харилцагч талуудын хооронд өөрийгөө оролцуулдаг байгууллага.

**144. Central securities depository (CSD) – Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага**

- 1) Үнэт цаасны гүйлгээ хийж бүртгэлийг хөтөлдөг,
- 2) Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа явуулдаг,
- 3) Үнэт цаасны гаргалтын бүрэн бүтэн байдалд идэвхитэй үүрэг гүйцэтгэдэг байгууллага.

**145. Certainty equivalents – Баталгаат эквивалент**

Жил тутам авах боломжтой мөнгөн орлогоос илүүтэйгээр, тооцоолсон мөнгөн орлогын тодорхой хувийг баталгаатай авахыг хөрөнгө оруулагчаас давууд үзэх эрсдэлийн зохицуулалтын хүчин зүйл.

**146. Certificate of deposit – Хадгаламжийн сертификат**

Банкны хугацаатай хадгаламжаар баталгаажсан үнэт цаас.

**147. Chaining – Гинжлэх**

Төлбөрийн даалгаврыг гүйцэтгэхэд баримталдаг шилжүүлгийн системийн арга. Үлдэгдлийн хэмжээнд багтаан шилжүүлгийн тоо болон үнийн дүнг хамгийн их байлгахаар төлбөрийн даалгаврыг дараалах арга.

**148. Change in net working capital – Цэвэр эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт**

Эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ба эргэлтийн эх үүсвэрийн өөрчлөлтийн зөрүү.

**149. Cheque – Чек**

Нэг этгээдээс (төлбөр төлөхийг шаардагч) нөгөө этгээдэд (төлбөр хийгч буюу гол төлөв банкны байгууллага) тодорхой дүнг анхны шаардлагаар төлөхийг шаардаж бичгээр өгсөн даалгавар.

**150. Churning – Холих**

Шимтгэлээ есгөх зорилгоор харилцагчийн дансыг ашиглан хэт олон гүйлгээ хийх. Зохицуулагчаас ийм ажиллагааг ёс зүйгүй хууль бус үйлдэл гэж үздэг

**151. Circuit breaker – Холбоог таслах**

Үнэт цаасны үнэ ханш огцом өөрчлөлттэй үед арилжааг удаашруулах буюу зогсоох үйл явц.

**152. Class Action – Шүүхэд хамтран гомдол гаргах**

Хувьцаа эзэмшигчдийн томоохон бүлэг болон эсвэл түүний төлөөлөл болсон албан байгууллага компанийн эсрэг хувьцаа эзэмшигчдэд мөнгө нэхэмжилж шүүхээр заргалдах.

**153. Clearing – Клиринг**

Төлбөрийг харилцан суутгаж эцсийн үлдэгдлийг гаргахын тулд төлбөрийн даалгаврыг дамжуулах, тооцоо нийлэх, зарим тохиолдолд тооцоо хийхээс өмнө төлбөрийн даалгаврыг баталгаажуулах үйл явц.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**154. Clearing float – Замд яваа клирингийн мөнгө**

Төлбөр хүлээн авагч мөнгийг өөрийн дансандаа оруулснаас хойш бодитойгоор ашиглах боломж бүрдэх хүртэлх хугацаа.

**155. Clearing system – Клирингийн систем**

Нэг санхүүгийн байгууллагаас эх үүсвэр буюу үнэт цаасны шилжүүлэгтэй холбогдох мэдээлэл эсвэл баримт бичгийг төвлөрсөн байранд нөгөө санхүүгийн байгууллагад өгч солилцох дүрэм журам.

**156. Clearinghouse – Клирингийн байгууллага**

Үнэт цаасны арилжаанд оролцогч талуудын төлбөр тооцоонд зуучлах зорилгоор биржээс нээсэн байгууллага.

**157. Clientele effect – Түншийн нөлөөлөл**

Компаниас ногдол ашгийн төлбөрийн хуваарьтайгаа зохицуулж хувьцаа эзэмшигчдэдээ сонгодог гэсэн аргумент.

**158. Closely owned (stock) – Хаалттай өмчлөлийн (хувьцаа)**

Компанийн нийт хувьцааг нэгдмэл сонирхолтой этгээдүүд өмчлөх тохиолдол.

**159. Close-out netting – Хаалтын харилцан суутгал**

Өнөөгийн өглөг нь шууд төлөгдөх нөхцөлтэй болж хууль болон гэрээний дагуу хурдасдаг (тухайлбал, дампуурлын хэрэг үүсмэгц) харилцан суутгалын тусгай хэлбэр.

**160. Coefficient of variation (CV) – Хазайлтын коэффициент (итгэлцүүр)**

Янз бүрийн хүлээгдэж буй өгөөжтэй активуудын эрсдэлийн түвшинг харьцуулахад ашигладаг харьцангуй тархалтын хэмжүүр.

**161. Collateral – Барьцаа**

Зээлийг баталгаажуулахын тулд зээлдэгчээс тавьсан эд зүйл. Зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлдүүлэгчээс хууль ёсны авлагаа барагдуулахаар заасан эд хөрөнгө.

**162. Collateral management – Барьцааны удирдлага**

Тухайн барьцааны зах зээлийн үнэлгээ болон барьцаагаар шаардаж буй үнэлэмж хоорондын харилцаанд хяналт тавих үйл явц.

**163. Collateral pool – Барьцааны нөөц**

Тодорхой гүйлгээнд хуваарилахгүйгээр эсрэг талтай хийх төлбөр тооцоог барьцаагаар хангаж чаддаг арга техник.

**164. Collateral trust bonds – Үнэт цаасны бонд**

Бонд эзэмшигчийн бусад хувьцаа, бондын барьцаагаар баталгаажсан бонд. Барьцааны үнэлгээ нь бондын үнэлгээнээс гол төлөв зохих хувиар илүү байна.

**165. Collateralized mortgage obligations – Барьцаатай моргэйжийн өр**

Моргэйжийн багцын мөнгөн урсгалыг тусгай журмын дагуу хуваах замаар зохиосон үнэт цаас.

**166. Collection float – Замд яваа авлага**

Төлбөр хариуцагчийн мөнгө түүний чекийн дансны дэвтрээс хасагдсанаас (шилжүүлсэн) хойш төлбөр хүлээн авагчийн дансанд орох хүртэлх хугацаа.

**167. Collection policy – Авлага цуглуулах бодлого**

Компанийн төлөгдөх хугацаа нь болсон дансны авлагыг цуглуулах бодлого.

**168. Commercial finance companies – Санхүүгийн компани**

Зөвхөн барьцаанд үндэслэж зээл олгодог санхүүгийн байгууллага.

**169. Commercial paper – Арилжааны вексель**

Төлбөрийн чадварын хувьд өндөр зэрэглэлтэй компаниас гаргадаг богино хугацаатай, барьцаагүй үнэт цаас.

**170. Commission broker – Шимтгэлийн брокер**

Үнэт цаасны арилжааны захиалгыг гүйцэтгэгч, хөрөнгийн бирж дээр ажилладаг брокерийн пүүсийн төлөөлөгч.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**171. Commitment fee – Амлалтын шимтгэл**

Эргэлтийн зээлийн шугамын үед зээлдэгчийн ашиглаагүй зээлийн эрхийн дундаж үлдэгдэлд ногдуулан тооцож авдаг шимтгэл.

**172. Committed facility – Амласан зээл**

Тодорхой нөхцөлд эх үүсвэрийн зээл олгохоор гэрээний дагуу тохирсон зээлийн хэрэгсэл (зээлийн шугам, репо гэх мэт).

**173. Common stock – Энгийн хувьцаа**

Компанийн эзэмшлийн хамгийн цэвэр бөгөөд үндсэн хэлбэр.

**174. Common stock equivalents (CSEs) – Энгийн хувьцааны эквивалент**

Үнэлгээ нь хөрвөлт ба энгийн хувьцааны шинж чанараас хамаардаг тэнцлийн гадуурх бүх төрлийн үнэт цаасыг хөрвүүлэн, хэлцлийг хэрэгжүүлсний эцэст нийтэд нь энгийн хувьцаанд шилжүүлж тооцсон илэрхийлэл.

**175. Common-size income statement – Борлуулалтын хувиар илэрхийлсэн орлогын тайлан**

Үзүүлэлт бүрийг нь борлуулалтанд эзлэх хувиар илэрхийлсэн орлогын тайлан.

**176. Comparison universe – Харьцуулах ертөнц**

Хөрөнгө оруулалтын адил төстэй арга барил бүхий багцын менежерүүдийн амжилтыг үнэлэхийн тулд ашигладаг стандарт багц.

**177. Compensating balance – Дансны үлдэгдлийн шаардлага**

Компанийн авсан богино хугацаатай зээлийн дүнгийн тодорхой хувийг дансандаа заавал байлгаж байх шаардлага.

**178. Competitive bidding – Өрсөлдөж авах санал**

Гаргасан үнэт цаасыг хамгийн өндөр үнээр авах санал гаргасан банк буюу банкны бүлгийн захиалгыг урамшуулах замаар ХОБ-ыг сонгодог арга.

**179. Complete portfolio - Бүтэн багц**

Эрсдэлгүй ба эрсдэлтэй активыг (үнэт цаасыг) багтаасан нийт багц.

**180. Composition - Авлагын бүтэц**

Зээлдүүлэгчдийн авлагын дүнд хувь тэнцүүлэн тооцож олгох мөнгөн төлбөр.

**181. Compound interest - Нийлмэл хүү**

Санхүүгийн хэрэгсэлд төлсөн хүү нь тодорхой хугацааны эцэст үндсэн төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болох үйл явц.

**182. Confidence index - Итгэлийн индекс**

Дээгүүр зэрэглэлтэй компаниудын бондын жилийн хүүг дундуур зэрэглэлтэй компаниудын бондын жилийн хүүд харьцуулсан харьцаа.

**183. Confirmation (trade confirmation) - Батламж**

Худалдааны нөхцөлийг зах зээлд оролцогчдоос шууд буюу эсвэл төвлөрсөн байгууллагаар дамжуулан давхар шалгах ажиллагаа.

**184. Conflicting rankings - Зөрчилтэй эрэмбэлэлт**

Мөнгөн урсгалын цаг хугацаа, хэмжээний зөрүүгээс шалтгаалан өгөгдсөн төслийн цэвэр өнөөгийн үнэлэмжээр (NPV ) ба өгөөжийн дотоод хувиар (IRR) тооцсон үзүүлэлтүүдийн эрэмбэ зөрчилдөх явдал.

**185. Congeneric merger - Нэг салбарын компанийн нэгдэлт**

Нэг салбарын боловч, нэг төрлийн бизнес эрхэлдэггүй, нийлүүлэгч худалдан авагчийн харьцаагүй компаниудын нэгдэлт.

**186. Conglomerate merger - Өөр салбарын компанийн нэгдэлт**

Бизнесийн ямар ч уялдаа холбоогүй компаниудын нэгдэлт.

**187. Conservative financing strategy - Санхүүжилтийн консерватив стратеги**

Компаниас төлөвлөсөн бүх хэрэгцээгээ урт хугацаатай эх үүсвэрээр санхүүжүүлж, богино хугацаатай эх үүсвэрийг зөвхөн төлөвлөгдөөгүй буюу болзошгүй хэрэгцээнд ашигладаг стратеги.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**188. Consolidation – Нэгдэлт**

Хоёр ба түүнээс дээш тооны компани нэгдэж шинээр компани үүсгэх.

**189. Constant growth valuation (Gordon) model – Тогтмол өсөлттэй үнэлгээний (Гордоны) загвар**

Хувьцааны үнэлгээ нь ирээдүйн нийт ногдол ашгийн өнөөгийн үнэлэмжтэй тэнцүү (ирээдүйн ногдол ашгийн өсөлт нь тогтмол, хугацаа нь хязгааргүй) гэж үзсэн ногдол ашгийн хямдруулалтын загвар.

**190. Constant-payout-ratio dividend policy – Тогтмол харьцаагаар ногдол ашиг хуваарилах бодлого**

Ногдол ашгийг компанийн ашгийн тодорхой тогтмол хувиар тооцон хуваарилах бодлого.

**191. Contingent immunization – Тэнцлийн гадуурх дархлаажуулалт**

Шаардлагатай гэж үзвэл хүлээн зөвшөөрөгдөх хамгийн бага өгөөжийг баталгаажуулан идэвхитэй удирдлагад оруулдаг багцын дархлаажуулалтын стратеги.

**192. Contingent securities – Тэнцлийн гадуурх үнэт цаас**

Хөрвөх үнэт цаас, баталгаат эрх (воррант), хувьцааны сонгох эрх (сток опционз) зэрэг компанийн нэгж хувьцааны ашгийн тайланд нөлөөлдөг хэрэгслүүд.

**193. Continuous compounding – Нийлмэл хүүг тасралтгүй тооцох**

Нэг жилийн дотор хязгааргүй тоотой үеүдийн (хамгийн бага хугацаа буюу микросекунд тутам) хүүг нийлүүлж тооцох.

**194. Continuous probability distribution – Магадлалын тасралтгүй тархалт**

Өгөгдлийн хувьд гарах боломжит бүхий л үр дүнгүүдийн магадлалын тархалт.

**195. Contractual settlement date accounting – Тооцооны өдрийн бүртгэл**

Тооцоо бодитой хийгдсэн эсэхээс үл хамаарч харилцагчийн эсрэг талтайгаа хийсэн гэрээт тооцоо хийх өдрөөр (гэрээт тооцооны өдөр) кастодианаас харилцагчийн бэлэн мөнгө үнэт цаасны дансанд дебет кредит гүйлгээ хийх гэрээгээр хүлээсэн үүрэг.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**196. Controller – Ерөнхий нягтлан бодогч**

Татварын удирдлага, санхүүгийн ба зардлын бүртгэл зэрэг компанийн бүртгэлийн асуудлыг хариуцсан компанийн ерөнхий нягтлан бодогч.

**197. Conventional cash flow pattern – Мөнгөн урсгалын хэвшсэн загвар**

Хугацааны эхэнд мөнгөн зарлага нэгмөсөн гараад дараа нь орох мөнгөн орлогын цуваа.

**198. Convergence property – Үнэ нийлэх чанар**

Ирээдүйн хэлцлийн хугацааны эцэст ирээдүйн үнэ ба спот (одоогийн) үнэ нийлэх чанар.

**199. Conversion (or stock) value – Хөрвөлтийн үнэлэмж**

Хөрвүүлж болох энгийн хувьцааны зах зээлийн үнээр тооцсон хөрвөх үнэт цаасны үнэлэмж.

**200. Conversion feature – Хөрвөх нөхцөл**

Бондыг эзэмшигчээс бонд нэг бүрээ тодорхой тооны хувьцаагаар солих боломжийг тусгасан хөрвөх бондын нөхцөл.

**201. Conversion feature – Хөрвөх чанар (давуу эрхтэй хувьцааны хувьд)**

Давуу эрхтэй хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа тогтоосон тооны энгийн хувьцаанд хөрвүүлэх чанар.

**202. Conversion feature – Хөрвөх чанар (бондын хувьд)**

Бонд болон давуу эрхтэй хувьцааг эзэмшигч нь үнэт цаасаа тогтоосон тооны энгийн хувьцаагаар солих эрх.

**203. Conversion of convertible bonds – Хөрвөх бондын хөрвүүлэлт**

Хөрвөх бондыг суурь үнэт цаасаар солих.

**204. Conversion price – Хөрвөх үнэ**

Хөрвөх үнэт цаасыг энгийн хувьцаанд хөрвүүлсний эцэст бодитойгоор энгийн нэгж хувьцаанд төлсөн үнэ.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**205. Conversion ratio – Хөрвөх харьцаа**

Хөрвөх үнэт цаас энгийн хувьцаанд хөрвөх харьцаа.

**206. Convertible bond – Хөрвөх бонд**

Тогтоосон тооны энгийн хувьцаанд хөрвөдөг бонд.

**207. Convertible preferred stock – Хөрвөх давуу эрхтэй хувьцаа**

Тогтоосон тооны энгийн хувьцаанд хөрвөдөг давуу эрхтэй хувьцаа.

**208. Convexity – Конвексити**

Бондын үнэ, жилийн хүүгийн харьцааг харуулсан муруйн чиглэлийн өөрчлөлт.

**209. Corporate action (corporate event) – Компанийн үйл явдал**

Үнэт цаас эзэмшигчдэд нөлөөлнө гэж тухайн үнэт цаас гаргагчаас үзсэн аливаа үйл ажиллагаа, үйл явдал. Энэ нь нэг бол эзэмшигчдийн хувьд сайн дурын, сонголттой (тухайлбал, үнэт цаас гаргагчийн нөхцөлийг зөвшөөрч байвал илүү хувьцаа авах эрхийг бий болгосон) эсвэл заавал дагах, сонголтгүй (тухайлбал, ногдол ашгийн хуваарилалт, хувьцаа салгалт) байна.э

**210. Corporate bond – Компанийн бонд**

Компани нь тодорхой хэмжээний мөнгийг санхүүгийн байгууллагаас буюу хувь хүнээс зээлсэн, түүнийгээ ирээдүйд тодорхой нөхцөлийн дагуу төлөхийг амласан өрийн бичиг.

**211. Corporate governance – Компанийн засаглал**

Энэ нь компанийн удирдлага, хяналтын систем бөгөөд компанийн үйл ажиллагаанд оролцогч гол этгээдийн эрх үүрэг, шийдвэр гаргалтын зарчим, зорилт тавих, түүндээ хүрэх болон хянах арга замыг тодорхойлдог.

**212. Corporate restructuring – Компанийн бүтцийн өөрчлөлт**

Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, багасгах, хөрөнгө, өмчлөлтийн бүтцийг өөрчлөх үйл ажиллагаа.

**213. Corporation – Корпораци**

Хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан этгээд.

**214. Correlation – Корреляци, холбоо хамаарал**

Янз бүрийн хувьсагчуудын хоорондын хамаарлыг илэрхийлдэг статистикийн хэмжүүр.

**215. Correlation coefficient – Корреляцын коэффициент (итгэлцүүр)**

2 төрлийн хувьсагч хоорондын урвуу шууд хамаарлын (корреляцын) зэрэг.

**216. Correspondent banking – Харилцагч банк**

Нэг банк (тооцоо хийж үйлчилгээ үзүүлэх банк) нөгөө банкны (харилцагчийн банк) нэрийн өмнөөс төлбөр хийх төлбөр хүлээн авах үйл ажиллагаа (нэмэлт банкны үйлчилгээ үзүүлж байна гэсэн үг).

**217. Cost of a new issue of common stock – Шинээр гаргах хувьцааны өртөг**

Доогуур үнэлэгдэх ба гаргалтын зардлыг тусгасан хувьцааны өртөг.

**218. Cost of capital – Капиталын (хөрөнгийн) өртөг**

Компаниас өөрийн зах зээлийн үнэлэмжээ хадгалах, эх үүсвэр татахын тулд төслийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй олох шаардлагатай өгөөж.

**219. Cost of common stock equity – Энгийн хувьцааны өртөг**

Компанийн хувьцааны үнэлгээг тодорхойлохын тулд хөрөнгө оруулагчаас хүлээж байгаа ногдол ашгуудыг хямдруулж буй хувь.

**220. Cost of giving up a cash discount – Бэлэн мөнгөний хөнгөлөлтөөс татгалзсаны зардал**

Өглөгийг нэмэлт өдрөөр хойшлуулсны төлөө төлөх хүү.

**221. Cost of long-term debt – Урт хугацаатай санхүүжилтийн өртөг**

Зээллэгийн замаар урт хугацаатай санхүүжилт олж авах татварын дараах өнөөгийн өртөг.

**222. Cost of new asset – Шинэ хөрөнгийн зардал**

Хөрөнгийг шинээр худалдан авахад шаардлагатай мөнгөний цэвэр урсгал.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**223. Cost of preferred stock – Давуу эрхтэй хувьцааны өртөг**

Давуу эрхтэй хувьцааны жилийн ногдол ашиг ба мөн хувьцааг борлуулснаас олсон цэвэр мөнгөн орлогын харьцаа.

**224. Cost of retained earnings – Хуримтлагдсан ашгийн өртөг**

Шинээр бий болсон нэмэлт эх үүсвэр нь хувьцаа эзэмшигчдийн хүсч буй өгөөжөөр тодорхойлогдох тул хуримтлагдсан ашгийн өртөг нь энгийн хувьцааны өртөгтэй тэнцүү байна.

**225. Counterparty risk – Харилцагчийн эрсдэл**

Гүйлгээг хийхээр тохиролцсон хугацаа болон гүйлгээ бодитойгоор хийгдсэн хугацаа хооронд харилцагчаас гүйлгээ хийх үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл.

**226. Country selection – Улсын сонголт**

Аль нэг улсад хийх хөрөнгө оруулалтыг сонгох активын хуваарилалт.

**227. Coupon Payment/Interest payment – Хүүгийн төлбөр**

Бонд гаргагч гэрээний нөхцлийн дагуу төлөх хүү.

**228. Coupon rate – Бондын хүү**

Бондын нэрлэсэн дүнд тооцогдох жилийн хүү.

**229. Coverage ratios – Зардал нөхөх чадварын харьцаанууд**

Компанийн тогтмол зардлаа төлөх чадварыг харуулдаг харьцаанууд.

**230. Covered call – Хаалттай**

Активыг худалдан авахтай нэгэн зэрэг тухайн активын авах опционыг зарах үйлдэл.

**231. Credit analysis – Зээлийн шинжилгээ**

Зээлдэгчийн зээлийн өргөдөлд хийх үнэлгээ.

**232. Credit card (card with a credit function) – Зээлийн карт**

Эзэмшигчиддээ тодорхой хязгаарт багтаан худалдан авалт хийх бэлэн мөнгө авах эрх олгодог карт.

### 233. Credit institution - Банкны байгууллага

Банкны үйл ажиллагаа (харилцагчдаас мөнгө татаж зээлийн үйл ажиллагаа явуулах, төлбөр тооцоо хийх гэх мэт) тогтмол явуулах зөвшөөрөлтэй байгууллага.

### 234. Credit period - Зээлийн хугацаа

Өглөгийг (дансны өр) барагдуулах хугацаа.

### 235. Credit policy - Зээлийн бодлого

Зээлийн сонголт, стандарт, нөхцөлийг тодорхойлж шийдвэр гаргах үйл ажиллагаа.

### 236. Credit risk - Зээлийн эрсдэл

Харилцагч талаас авсан мөнгөө бүрэн хэмжээгээр хугацаанд нь эсвэл хугацаа өнгөрснөөс хойш ч төлөхгүй байх эрсдэл. Зээлийн эрсдэлд үндсэн өрийн эрсдэл болон борлуулалтын зардлын эрсдэл орно.

### 237. Credit scoring - Зээлийн оноо тогтоох

Зээлдэгчийн зээл төлөх ерөнхий чадварыг үнэлэхийн тулд зээлийн түүх, санхүүгийн гол үзүүлэлтүүдэд оноо өгөн жигнэсэн дундаж аргаар тооцох үйл ажиллагаа.

### 238. Credit selection - Зээлийн сонголт

Харилцагчид зээл олгох эсэх, хэрэв олговол хэдий хэмжээтэй олгохыг тодорхойлох шийдвэр.

### 239. Credit standards - Зээлийн стандарт

Харилцагчид зээл олгохын тулд тавих наад захын шаардлага.

### 240. Credit terms - Зээлийн нөхцөл

Зээлийг буцааж төлөх нөхцөл.

### 241. Creditor control - Зээлдүүлэгчдийн хяналт

Авлагаа бүрэн барагдуулах хүртэл компанийн удирдлагыг зээлдүүлэгчдийн хороогоор сольдог зохицуулалт.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**242. Cross-border payment – Хил дамжсан төлбөр**

Төлбөр төлөгчийн болон төлбөр хүлээн авагчийн санхүүгийн байгууллагууд өөр өөр улсад байгаа нөхцөлд хийгдэх төлбөр.

**243. Cross-border settlement – Хил дамжсан тооцоо**

Тооцоо нэг улсад (эсвэл мөнгөний бүсэд) хийгдэх үед гүйлгээнд оролцогч нэг тал эсвэл хоёулаа тухайн улсад оршоогүй байхад хийгдсэн тооцоо.

**244. Cross-sectional analysis – Салбарын харьцуулсан шинжилгээ**

Компаниудын цаг хугацааны нэг агшин дахь санхүүгийн харьцааг харьцуулан шинжилдэг арга, тухайн нэг компанийн харьцааг салбарын дундаж үзүүлэлттэй эсвэл салбарын бусад компаниудын үзүүлэлттэй харьцуулах явдал хамаарна.

**245. Cumulative preferred stock – Ногдол ашиг нь хуримтлагдах давуу эрхтэй хувьцаа**

Энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаас өмнө тайлант үеийн ногдол ашиг дээрээ өмнөх үеийн төлөгдөөгүй ногдол ашгийн авлагыг барагдуулан нэмж авах давуу эрхтэй хувьцаа.

**246. Cumulative voting system – Саналыг хуримтлуулан тооцох систем**

Нэгж хувьцаа бүрт саналын тодорхой эрхийг хуваарилаад нийт саналын тоог сонгогдох захирлуудын зөвлөлийн нийт гишүүдийн тоотой хувь тэнцүүлэн тогтоох систем. Саналыг захирлуудын зөвлөлийн аль ч гишүүнд өгч болдог.

**247. Currency selection – Валютын сонголт**

Аль нэг улсын валютаар илэрхийлэгдэх хөрөнгө оруулалтыг сонгох активын хуваарилалт.

**248. Current asset – Эргэлтийн актив (хөрөнгө)**

Нэг жилийн дотор бэлэн мөнгөнд хөрвөдөг богино хугацаат активууд.

**249. Current expenditure – Урсгал зардал**

Нэг жилийн дотор үр ашгаа өгөх хөрөнгийн зарцуулалт.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**250. Current liabilities – Эргэлтийн эх үүсвэр**

Нэг жилийн дотор төлөгддөг богино хугацаат өр төлбөрүүд.

**251. Current rate (translation) method – Тухайн үеийн ханшаар хөрвүүлэх арга**

АНУ-ын компаниуд, гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрүүдээ толгой компанийнхаа санхүүгийн тайланд нэгтгэхийн тулд жилийн эцэс дэх валютын ханшийг ашиглан хөрвүүлдэг арга.

**252. Current ratio – Эргэлтийн харьцаа**

Компанийн эргэлтийн хөрөнгийг эргэлтийн эх үүсвэрт нь харьцуулж тооцсон хөрвөх чадварын хэмжүүр.

**253. Custodian – Кастодиан**

Үнэт цаасны хадгалалтын үйл ажиллагаа эрхлэх этгээд, гол төлөв өөрийн харилцагчиддаа үнэт цаасыг хадгалах үйлчилгээ үзүүлдэг банкны байгууллага үүнд ордог.

**254. Custody – Кастоди (үнэт цаасны хадгалалт)**

Зөвшөөрөлтэй байгууллагаас гуравдагч этгээдийн эзэмшиж буй үнэт цаас болон санхүүгийн хэрэгслийг хадгалах, удирдах үйл ажиллагаа.

**255. Custody risk – Кастодийн эрсдэл (үнэт цаасны хадгалалтын эрсдэл)**

Кастодианы төлбөрийн чадваргүй байдал, хайхрамжгүй байдал, активыг буруугаар ашиглах, луйвар, муу удирдлага, бүртгэлийг хангалтгүй хөтлөх зэргээс болж хадгалалтад байгаа үнэт цааст алдагдал хүлээх эрсдэл.

**256. Cut-off time – Таслах хугацаа**

Тооцооны тухайн мөчлөгт системээс (эсвэл зуучлагч банкнаас) тогтоосон төлбөрийн даалгаврыг хүлээж авах эцсийн хугацаа.

**257. Cyclical industries – Мөчлөгийн салбар**

Эдийн засгийн байдлаас хамаарч өөрчлөгдөх мэдрэмжийн түвшин нь дунджаас дээш салбар.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**258. Daily processing – Өдөр тутмын боловсруулалт**

Өдрийн эхнээс өдрийн эцэс хүртэл бүтэн мөчлөгт хийгдэх боловсруулалт. Заримдаа энэ нь мэдээллийг нөөцлөх үйл ажиллагааг хамруулдаг.

**259. Date of invoice – Нэхэмжлэлийн огноо**

Зээлийн хугацааны эхлэл нь худалдан авалтын нэхэмжлэлийн огноо болно.

**260. Date of record (dividends) – Ногдол ашгийн бүртгэлийн огноо**

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг авах эрхийг баталгаажуулж тогтоосон огноо.

**261. Date of record (rights) – Бүртгэлийн (эрхийн) огноо**

Компанийн хууль ёсны өмчлөгч болохыг тодорхойлж хувьцааны бүртгэлд орсон сүүлчийн огноо.

**262. Dealer markets – Дилерийн зах**

Тодорхой нэр төрлийн үнэт цаасаар мэргэжсэн дилерүүд өөрийн нэрийн өмнөөс арилжаа хийдэг зах зээл.

**263. Debentures – Дээд ангиллын бонд**

Төлбөрийн чадвар сайтай компаниудаас гаргадаг баталгаагүй бонд.

**264. Debit card (card with a debit function) – Дебит карт**

Өөрийн харилцах дансны (данс нь карт гаргагч дээр байдаг эсэхээс үл хамаарч) үлдэгдлийн хэмжээнд багтаан худалдан авалт хийх бэлэн мөнгө авах эрхийг эзэмшигчиддээ олгодог карт.

**265. Debt capital – Урт хугацаатай зээлийн хөрөнгө**

Урт хугацаагаар зээлсэн мөнгөн хөрөнгө.

**266. Debt ratio – Өрийн харьцаа**

Компанийн зээлдүүлэгчийн хөрөнгөөр санхүүжигдсэн нийт хөрөнгийг хэсгийг харуулдаг хэмжүүр.

**267. Debt-equity ratio – Өр хувьцаат хөрөнгийн харьцаа**

Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө ба урт хугацаатай өрийн харьцааны хэмжүүр.

**268. Dedication strategy – Үнэнч стратеги**

Олон үеийн бэлэн мөнгөний урсгалыг тэнцэтгэх стратеги.

**269. Default – Өр төлөх чадваргүй байдал**

Гэрээний дагуу өр төлөх чадваргүй байдал гэж тооцогдоход хүрсэн тохиолдол. Өрөө хугацаанд нь төлөөгүй байх, гэрээ зөрчигдөх, дампуурлын хэрэг үүсэх зэрэг үйл явдлууд энэ тохиолдолд хамаарна.

**270. Default premium – Төлбөрийн чадварын урамшуулал**

Төлбөрийн чадварын эрсдэлийг нөхсөн хөрөнгө оруулалтын өгөөжийн урамшуулал.

**271. Degree of financial leverage (DFL) – Санхүүгийн хөшүүргийн зэрэг**

Санхүүгийн хөшүүргийн тоон хэмжүүр.

**272. Degree of indebtedness – Өрийн түвшин**

Энэ нь өрийг тэнцлийн бусад чухал үзүүлэлтүүдтэй харьцуулж хэмждэг.

**273. Degree of operating leverage (DOL) – Үйл ажиллагааны хөшүүргийн зэрэг**

Үйл ажиллагааны хөшүүргийн тоон хэмжүүр.

**274. Degree of total leverage (DTL) – Нийт хөшүүргийн зэрэг**

Нийт хөшүүргийн тоон хэмжүүр.

**275. Delisting – Бүртгэлээс хасах**

Компанийн хувьцааг хөрөнгийн бирж болон Монгол улсын үнэт цаасны бүртгэлээс хасах.

**276. Delivery – Хүргэлт**

Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх эсвэл биетээр солилцох хэлбэрээр санхүүгийн хэрэгсэл, барааг шилжүүлэх.

a

b

c

D

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**277. Delivery versus delivery (DvD) – Хүргэлтийн эсрэг хүргэлт**

Зөвхөн нөгөө талын үнэт цаасны хүргэлт хийгдсэн тохиолдолд нэг талын үнэт цаасны хүргэлт хийгддэг үнэт цаасны шилжүүлгийг холбосон тооцооны механизм.

**278. Delivery versus payment (DvP) – Төлбөрийн эсрэг хүргэлт**

Зөвхөн нөгөө талын үнэт цаасны төлбөр хийгдсэн тохиолдолд нэг талын үнэт цаасны хүргэлт хийгддэг үнэт цаасны шилжүүлэг төлбөрийг холбосон тооцооны механизм.

**279. Demand shock – Эрэлтийн цочрол**

Эдийн засаг дахь бараа үйлчилгээний эрэлтэд нөлөөлөх үйл явдал.

**280. Dematerialisation – Биет бус болголт**

Биетээр олгогддог гэрчилгээ болон санхүүгийн активын өмчлөлийг илэрхийлэх аливаа баримт бичгийг үгүй хийж санхүүгийн активыг зөвхөн бүртгэлээр илэрхийлэх үйл явц.

**281. De-merger – Компанийг хуваах**

Компани 2 ба түүнээс дээш тооны компани болон хуваагдахыг хэлэх ба хуучин компанийн хувьцааг бүртгэлээс хасч шинэ компаниудын хувьцааг тогтоосон харьцаагаар бүртгэж авна.

**282. Depository – Хадгаламжийн байгууллага**

Үнэт цаасны нягтлан бодох бүртгэлийг (шууд буюу шууд бусаар) хөтлөх үндсэн үүрэгтэй байгууллага. Хадгаламжийн байгууллага нь мөн үнэт цаасны бүртгэгч байж болдог.

**283. Depository receipt – Хадгаламжийн бичиг**

Өөр улсын бирж дээр арилждаг үнэт цаасыг төлөөлж банкнаас зохицуулалттай зах зээл дээр гаргаж арилжаалах санхүүгийн хэрэгсэл.

**284. Depreciation – Элэгдэл**

Үндсэн хөрөнгийн анхны өртгийг ашиглагдах хугацааны туршид жил тутмын орлогоос тараан хасах замаар системтэйгээр багасгах.

**285. Depth of a market – Зах зээлийн гүнзгийрэлт**

Арилжаалагдаж байгаа үнэт цаасны үнийн дүнгээс хамаарсан зах зээл.

**286. Derivative security – Үүсмэл үнэт цаас**

Бусад актив, үнэт цаасны үнэлгээнээс уламжлан хамаарсан үнэт цаас

**287. Dilution of ownership – Эзэмшлийн замхралт**

Шинээр хувьцаа нэмж гаргахад энгийн хувьцаа эзэмшигчдийн компанийн өмчлөлд эзлэх хувь буурч өөрчлөгддөг систем.

**288. Direct holding system – Шууд эзэмшлийн систем**

Үнэт цаасны жинхэнэ өмчлөгч бүр өөрийн үнэт цаасны эзэмшлээ (эсвэл адил төстэй өмчлөлөө) нэг байгууллагад (тухайлбал, үнэт цаас гаргагч дээр, үнэт цаасны хадгаламжийн байгууллагад, эсвэл бүртгэгч дээр) бүртгүүлж байх зохицуулалт. Зарим оронд шууд эзэмшлийн систем ашиглахыг хуулиар шаарддаг.

**289. Direct lease – Шууд түрээс**

Үндсэн хөрөнгийг өмчлөгчөөс түрээслэгчид шууд түрээслүүлэх үйл ажиллагаа.

**290. Direct participant – Шууд оролцогч**

Зуучлагчийг оролцуулахгүйгээр шилжүүлгийн системээс зөвшөөрсөн бүх үйл ажиллагаа явуулдаг оролцогч.

**291. Disbursement float – Замд яваа өглөг**

Төлбөр хариуцагчийн мөнгө түүний чекийн дансны дэвтрээс хасагдсанаас хойш банкин дахь данснаас хасагдах хүртэл хугацаа.

**292. Discount – Хямдруулалт**

Үнэт цаасны зарагдсан үнийн нэрлэсэн үнээс дутагдсан зөрүү.

**293. Discount loans – Хямдруулсан зээл**

Хүүг нь урьдчилан суутгаж олгодог зээл.

**294. Discounting cash flows – Мөнгөний урсгалыг хорогдуулах**

Өнөөгийн үнэ цэнийг олох үйл явц, нийлмэл хүү тооцохын эсрэг үйл явц.

a

b

c

D

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**295. Discretionary closed-end fund – Интервалгүй хаалттай сан**

Хоёр жилээс дээш хугацааны давтамжтайгаар нэг хэсэг буюу нийт хувьцааг худалдаж авах боломж бүхий хаалттай сан.

**296. Diversifiable risk – Тархаах боломжтой эрсдэл**

Активын эрсдэлийн тухайн компанийн өөрийн онцлог, санамсаргүй шалтгаанд хамаатай хэсэг.

**297. Divestiture – Хэсэгчилсэн худалдаа**

Компанийн зарим эд хөрөнгийг стратегийн зорилгоор худалдах.

**298. Dividend – Ногдол ашиг**

Компанийн хувьцаа эзэмшигчдэд ашгаас хуваарилсан хэмжээ.

**299. Dividend discount model – Ногдол ашгийн хямдруулалтын загвар**

Компанийн бодит үнэ цэнэ нь ирээдүйд хүлээгдэж буй ногдол ашгуудын өнөөгийн үнэ цэнэтэй тэнцэх томъёо.

**300. Dividend irrelevance theory – Ногдол ашгийн үл хамаарлын онол**

Хийсвэр орчинд компанийн үнэлэмж нь орлого олох боломж ба активын (хөрөнгө оруулалтын) эрсдэлээр л тодорхойлогдоно, түүнээс биш ногдол ашиг буюу хуримтлагдсан ашиг дангаар тодорхойлохгүй гэж үзэх Миллер, Модилияны онол.

**301. Dividend payout ratio – Ногдол ашгийн хуваарилалтын харьцаа**

Компанийн ашгийн нэг төгрөг тутмаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилах бэлэн мөнгөний хувь. Үүнийг тооцохдоо нэгж хувьцааны ногдол ашгийг нэгж хувьцааны ашигт хуваадаг.

**302. Dividend policy – Ногдол ашгийн бодлого**

Ногдол ашгийн талаар шийдвэр гаргах компанийн төлөвлөгөө.

**303. Dividend Reinvestment Plan (DRIP) – Ногдол ашгийн дахин хөрөнгө оруулалтын төлөвлөгөө**

Хувьцаа эзэмшигчид нь ногдол ашгаасаа гүйлгээний зардалгүйгээр нэмэлт хувьцаа авах эрхийг олгосон төлөвлөгөө.

a

b

c

D

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**304. Dividend reinvestment plans (DRPs) – Ногдол ашгийн дахин хөрөнгө оруулалтын төлөвлөгөө**

Хувьцаа эзэмшигчид нь ногдол ашгаасаа гүйлгээний зардалгүйгээр нэмэлт хувьцаа авах эрхийг олгосон төлөвлөгөө.

**305. Dividend relevance theory – Ногдол ашгийн хамаарлын онол**

Компанийн үнэлэмж нь ногдол ашгийн бодлогоос шууд хамаарна гэж үзэх Гордон, Линтнер нарын онол.

**306. Dividends per share – Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг**

Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг.

**307. Double taxation – Давхар татвар**

Компани татварын дараах ашгаа хувьцаа эзэмшигчдэд бэлэн мөнгөөр ногдол ашиг болгон хуваарилсны дараа хувьцаа эзэмшигчид нь ногдол ашгаасаа 15 хувь хүртэлх орлогын татвар төлөх тохиолдол.

**308. Double-entry bookkeeping – Нягтлан бодох бүртгэлийн давхар бичилт**

Нэг дансанд кредит буюу дебет бичилт хийгдэж байхад түүнтэй харьцсан нөгөө дансанд бас зэрэгцэн бичилт хийдэг бүртгэлийн зарчим.

**309. Dow theory – Довын онол**

Хувьцааны зах зээлийн үнийн богино ба урт хугацааны хандлагыг танин мэдэхийг оролдох техник.

**310. DuPont formula – ДюПонтын томъёо**

Компанийн нийт активын өгөөж нь цэвэр ахуйц ашиг ба нийт активын эргэлтийн үржвэртэй тэнцдэг.

**311. DuPont system of analysis – Шинжилгээний ДюПонт систем**

Компанийн удирдлагаас санхүүгийн байдлаа үнэлэхэд ашигладаг санхүүгийн тайлангийн задлан шинжилгээний систем.

**312. Duration – Үргэлжлэх хугацаа**

Бондын төлбөрүүдийн өнөөгийн үнэлэмжээр (үнэ цэнээр) жигнэсэн бондын жинхэнэ хугацаа.

a

b

c

D

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**313. Dutch Auction - Голланд дуудлага худалдаа**

Голланд дуудлага худалдааны саналд тодорхой тооны хувьцаа эцсийн дүнд худалдаалагдах үнийн хэлбэлзэл нь заагдсан байдаг. Хувьцаа эзэмшигчдээр ямар үнээр зарах тухай заалт гаргуулдаг. Бүх заалтууд тоологдсоны дараа, хамгийн бага үнэ санал болгосон хувьцаа эзэмшигчийн хувьцаа тодорхойлогдсон тооноос хэтрэх хүртэл эсвэл үнийн хэлбэлзэлийн дээд хязгаар хүртэл борлуулагддаг.

**314. Dynamic hedging - Динамик хамгаалалт**

Зах зээлийн нөхцөл өөрчлөгдмөгц хамгаалалтын байршлыг байнга шинэчлэх үйл явц.

**315. Early Redemption - Өр хаах**

Бонд гаргагч сонгосон эзэмшлийн өрийг хүүг нэмэгдүүлсэн дүнгээр хугацаанаас нь өмнө барагдуулах.

**316. Earnings per share (EPS) - Нэгж хувьцаанд ногдох ашиг**

Тодорхой хугацааны туршид бий болсон нийт энгийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах боломжтой ашгийг нийт эргэлтэнд байгаа энгийн хувьцааны тоонд харьцуулж тооцдог эргэлтэнд байгаа нэгж энгийн хувьцаанд хуваарилагдах боломжтой ашиг буюу энгийн нэгж хувьцаа бүрээс олж байгаа ашгийн хэмжээ.

**317. Earnings yield - Ашиг үнийн харьцаа**

Ашиг ба хувьцааны зах зээлийн үнийн харьцаа.

**318. EBIT-EPS approach - EBIT-EPS-ын хамаарлын шинжилгээ**

Татвар ба хүүгийн зардлын өмнөх орлого (EBIT)-ын хүлээгдэж буй төрөл бүрийн хувилбаруудын хувьд нэгж хувьцааны ашгийг (EPS) хамгийн их байлгах капиталын бүтцийг сонгох арга .

**319. Economic conversion quantity (ECQ) - Эдийн засгийн хөрвүүлэлтийн тоо**

Арилжаалагдах үнэт цааснаас мөнгөн хөрөнгөд, мөнгөн хөрөнгөөс арилжаалагдах үнэт цаасанд хөрвүүлэх хамгийн бага зардал бүхий хөрвүүлэлтийн тоо.

**320. Economic earnings – Эдийн засгийн ашиг**

Компанийн үйлдвэрлэлийн чадварт өөрчлөлт гараагүй байхад төлбөр хийх боломжтой бодит мөнгөн урсгал.

**321. Economic order quantity (EOQ) model – Захиалгын оновчтой тоо хэмжээний загвар**

Хадгалалтын болон захиалгын нийт зардлыг хамгийн бага түвшинд байлгах захиалгын оновчтой тоо хэмжээг тодорхойлдог бараа материалын нөөцийн удирдлагын загвар.

**322. Economic value added – Эдийн засгийн нэмэгдсэн үнэлэмж**

Татварын дараах ашгаас хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зардлыг хасах замаар хөрөнгө оруулалт нь эзэмшигчдийн баялагт эерэгээр нөлөөлсөн эсэхийг тооцдог түгээмэл арга.

**323. Effective (true) interest rate – Жинхэнэ хүүгийн хувь**

Зээлдүүлэгчээс жинхэнээр авсан буюу зээлдэгчээс жинхэнэ төлсөн хүүгийн хувь.

**324. Effective annual rate – Жилийн жинхэнэ хүүгийн хувь**

Нийлмэл хүүгийн аргыг ашиглаж тооцсон үнэт цаасны жилийн хүүгийн хувь.

**325. Effective duration for MBS – Моргэйжоор баталгаажсан үнэт цаасны үргэлжлэх бодит хугацаа**

Хүүгийн түвшин өөрчлөгдөх нь моргэйжийн урьдчилан барагдуулалтад хэрхэн нөлөөлөхийг харуулдаг үргэлжлэх хугацааны хэмжүүр.

**326. Efficient frontier – Үр ашигтай хязгаар**

Багцын эрсдэлийн түвшин бүрт хүлээгдэж байгаа өгөөжийн хамгийн их утгыг илэрхийлсэн график.

**327. Efficient market – Үр ашигтай зах зээл**

Бүх хөрөнгө оруулагчид нь ижил мэдээлэлтэй, үнэт цаасны талаар адил хүлээлттэй, хөрөнгө оруулалтын хязгаарлалт, татвар, гүйлгээний зардал байхгүй, бүгд үнэт цаасыг адил төстэйгээр авч үзэн оновчтой сонголт хийдэг, өндөр өгөөж, бага эрсдэлийг сонгодог эрсдэлээс зайлсхийгчид гэж хийсвэрлэх төгс зах зээл.

a

b

c

d

E

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**328. Efficient market hypothesis – Үр ашигтай зах зээлийн таамаглал**

Үнэт цаасны үнэ нь нийтэд дэлгэгдсэн бүх мэдээллийг бүрэн тусгадаг, шинэ мэдээллийг шуурхай хүлээж авдаг, бүх хувьцаа нь зах зээлийн шударга үнэтэй учраас хөрөнгө оруулагчид буруу үнэлэгдсэн үнэт цаасыг хайх гэж цаг гарздах шаардлагагүй, тэнцвэртэй төгс зах зээл.

**329. Efficient portfolio – Үр ашигтай багц**

Эрсдэлийн өгөгдсөн хэмжээнд өгөөжийг хамгийн дээд түвшинд хүргэх, эсвэл өгөөжийн өгөгдсөн түвшинд эрсдэлийг хамгийн доод хэмжээнд барих багц.

**330. Electronic data interchange (EDI) – Цахим мэдээллийн харилцан солилцоо**

Арилжааны байгууллага хооронд (улсын байгууллага хооронд ч байж болно) захиалга, нэхэмжлэх, гаалийн мэдүүлэг, баримт бичиг, төлбөр, шилжүүлгийн мэдээллийг стандарт цахим хэлбэрт оруулан харилцан солилцохыг хэлнэ. Цахим мэдээллийн харилцан солилцоо нь олон нийтийн сүлжээ болон банкны системийн холбогдох сувгуудаар дамждаг.

**331. Electronic money – Цахим мөнгө**

Гүйлгээнд гаргагчаас авах авлагыг дараах байдлаар харуулах мөнгө:

- 1) Цахим төхөөрөмж дээр хадгалагдсан (карт буюу компьютер);
- 2) Гаргасан дүн нь хүлээж авсан мөнгөний дүнгээс багагүй;
- 3) Гаргагчаас өөр байгууллага төлбөрийн хэрэгсэл болгон хүлээн авдаг.

**332. Electronic signature (digital signature) – Цахим гарын үсэг**

Гарын үсэг зурагчийн жинхэнэ байдлыг баталгаажуулан таниж контентыг гарын үсэг зурагчтай холбосон криптограф аргаар үүссэн тоон мэдээллийн цуваа.

**333. EMV – EMV**

Дэлхий нийтийн цахим санхүүгийн гүйлгээний стандартыг, ялангуяа, чип картыг харилцан зохицолдоог хөгжүүлэгч байгууллагуудын товчлол. EMV гэдэг нь Европэй, Мастеркарт, Виза гэсэн нэрүүдийн товчлол.

**334. End of month (EOM) – Сарын эцэс**

Тайлант сарын бүх худалдан авалтын зээлийн хугацаа нь түүний дараа сарын эхний өдрөөс эхэлнэ.

**335. Ending cash – Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл**

Бэлэн мөнгөний эхний үлдэгдэл ба цэвэр мөнгөн урсгалын нийлбэр.

**336. Endowment funds – Хандивын сан**

Ашгийн бус байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг багцын хөрөнгө оруулалтын сан.

**337. Equally weighted index – Тэнцүү жигнэсэн индекс**

Үнэт цаасны өгөөжүүдийн энгийн дунджаар тооцсон индекс.

**338. Equipment trust certificates – Тоног төхөөрөмжийн сертификат**

Сертификатыг борлуулж онгоц, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, вагон зэргийн худалдан авалтыг санхүүжүүлнэ. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь уг тоног төхөөрөмжөө компаниудад түрээслэнэ. Түрээсийн төлбөр нь төлөгдөж дуусмагц тоног төхөөрөмж нь компанийн өмчлөлд шилжинэ.

**339. Equity capital – Хувьцаат капитал (Өөрийн хөрөнгө)**

Компанид оруулсан хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө.

**340. Equity funds – Хувьцааны сан**

Хувьцаанд төвлөрч хөрөнгө оруулдаг хамтын сангийн хэлбэр.

**341. Ethics – Ёс зүй**

Бизнесийн үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах ёс зүйн стандарт.

**342. Eurobond – Евробонд**

Олон улсын зээлдэгч компаниас гаргаж бусад орны хөрөнгө оруулагчдад анх гаргасан мөнгөний нэгжээс өөр мөнгөний нэгжээр зарагддаг бонд. Гол төлөв ам.доллараар илэрхийлэгдсэн бондыг хэлнэ.

**343. Eurobond market – Евро бондын зах зээл**

Компани болон засгийн газраас гаргадаг америк доллараар илэрхийлэгдсэн бонд бөгөөд эдгээрийг АНУ-аас бусад оронд байрладаг хөрөнгө оруулагчдад борлуулдаг зах зээл.

a

b

c

d

E

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**344. Eurocurrency loan market - Евро зээлийн зах**

Олон улсын банкуудаас зээлийн шугамын хэлбэрээр олон улсын корпораци, засгийн газруудад олгодог урт хугацаатай хөвөгч хүүтэй зээллэг.

**345. Eurocurrency market - Евро валютын зах зээл**

Бүс нутгийн мөнгөний зах зээлийн олон улсын эквивалент. Энэ нь ам.доллар, евро болон бусад хөрвөх чадвар сайтай мөнгөн тэмдэгтүүдээр илэрхийлэгдсэн банкны богино хугацаат хадгаламжуудын зах зээл юм.

**346. Eurodollar deposits - Евродолларын хадгаламж**

АНУ-аас бусад улсын банкинд байршсан ам.долларын хадгаламж.

**347. European option - Европ опцион**

Зөвхөн хугацааны эцэст хэрэгжүүлэх боломжтой опцион.

**348. EX dividend - Ногдол ашгийн өмнөх үеийн арилжаа**

Ногдол ашгийн бүртгэлийн огнооноос ажлын 2 өдрийн өмнө эхэлж тооцсон ногдол ашиг авах эрхгүйгээр зарагддаг хувьцааны арилжаа.

**349. EX rights - Эрхийн өмнөх үе**

Хувьцааны бүртгэлээс ажлын 4 өдрийн өмнө эхэлж үргэлжлэх үе. Тэр хугацаанд хувьцаа нь зарлагдсан эрхгүйгээр зарагддаг.

**350. Excess cash balance - Мөнгөн хөрөнгийн илүүдэл**

Бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл нь компанид зайлшгүй шаардлагатай нөөц үлдэгдлээс илүүдэж хөрөнгө оруулалт хийх боломжтой эх үүсвэр.

**351. Excess return - Илүүдэл өгөөж**

Эрсдэлгүй активын өгөөжөөс давсан өгөөжийн хувь.

**352. Exchange rate - Валютын ханш**

Дотоодын мөнгөн тэмдэгтийг гадаадын мөнгөн тэмдэгтээр солилцох ханш.

### 353. Exchange rate risk – Валютын ханшны эрсдэл

Валютын ханшны гэнэтийн өөрчлөлтөөс шалтгаалж төслийн мөнгөн урсгалын үнэлэмж (үнэ цэнэ) буурах эрсдэл.

### 354. Exercise (or option) price – Хэрэгжүүлэх (буюу опцион) үнэ

Хувьцаа авах баталгаат эрхийг эзэмшигчээс энгийн хувьцааг худалдаж авах боломжтой үнэ.

### 355. Exit criteria – Гарах шалгуур

Өнөөгийн оролцогч системээс гарах эсэхээ шийдвэрлэх шалгуур үзүүлэлт. Оролцогчийн системээс гарах эсэх нь сайн дурын эсвэл албадлагын (жишээ нь дампуурлын хэрэг үүсмэгц) шинж чанартай байж болно.

### 356. Expectations hypothesis – Хүлээлтийн таамаглал

Жилийн хүүгийн муруй нь хөрөнгө оруулагчаас тооцох ирээдүйн хүүгийн талаархи хүлээлтийн таамаглалыг тусгадаг гэж үзэх онол. Инфляцийн хүлээлт өсвөл жилийн хүүгийн муруй дээшээ хазайна, буурвал доошоо хазайна.

### 357. Expected return – Хүлээгдэж буй өгөөж

Хязгааргүй хугацаанд өгөгдсөн активаас үе тутам олохоор хүлээж буй өгөөж.

### 358. Expected return-beta relationship – Хүлээгдэж буй өгөөж-бетагийн хамаарал

Үнэт цаасны урамшуулал (хүлээгдэж буй илүүдэл өгөөж) нь бетатай пропорциональ хамааралтай гэж үзэх хөрөнгө активын үнэлгээний загвар.

### 359. Expected value of a return (ER) – Хүлээгдэж буй өгөөж

Өгөгдсөн активын хувьд авах хамгийн боломжит өгөөж.

### 360. Exposure – Өртөлт

Зарим эрсдэл бодитой хэрэгжиж алдагдал хүлээх явдал.

a

b

c

d

E

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**361. Extendible notes – Сунгах бонд**

Анхнаасаа 1-5 жилийн богино хугацаатай гаргасан, бонд эзэмшигчийн сонголтоор төсөөтэй хугацаагаар сунгах боломжтой бонд. Хүү нь хугацааны эцэст өөрчлөгдөх тул хөвөгч хүүтэй бондтой төстэй.

**362. Extension – Сунгалт**

Шууд биш боловч авлагаа дараа бүрэн авахаар тохиролцсон компанийн зээлдүүлэгчдийн хэлцэл.

**363. External financing required (“plug” figure) – Гадны санхүүжилтийн хэрэгцээ (“бөглөө” үзүүлэлт)**

Таамаглан тооцох аргын үед гадны санхүүжилтийн хэрэгцээ нь тэнцлийг тэнцүүлэгч бөглөө үзүүлэлт болдог.

**364. External forecast – Гадаад таамаглал**

Эдийн засгийн зарим гадаад үзүүлэлтүүд ба компанийн борлуулалт хоорондын хамааралд үндэслэсэн борлуулалтын таамаглал.

**365. Extra dividend – Илүү ногдол ашиг**

Хувьцааны ашиг нь ердийнхөөс илүү гарсан тохиолдолд нэмж хуваарилдаг ногдол ашиг.

**366. Face value – Нэрлэсэн үнэ**

Хугацааны эцэст төлөгдөх бондын нэрлэсэн үнийн төлбөр.

**367. Factor – Фактор**

Дансны авлагыг худалдан авах чиглэлээр мэргэшсэн санхүүгийн байгууллага.

**368. Factor model – Хүчин зүйлсийн загвар**

Хувьцааны өгөөжийн хувь дахь компанийн онцлогтой эрсдэл ба системийн эрсдэлийг харьцуулан хэмждэг статистикийн загвар.

**369. Factor portfolio – Хүчин зүйлийн багц**

Нэг хүчин зүйлийн хувьд бета нь 1-тэй тэнцүү, бусад хүчин зүйлсийн хувьд бета нь 0-тэй тэнцүү байгуулагдсан сайн тархагдсан багц.

**370. Factoring accounts receivable – Факторинг-Дансны авлагаа худалдах**

Дансны авлагаа факторын болон санхүүгийн байгууллагуудад хямдралтай худалдаж эх үүсвэр олж авах.

**371. Failed transaction (fail) – Буцаагдсан гүйлгээ**

Гэрээт хугацаандаа тооцоо хийгдээгүй гүйлгээ. Ийм гүйлгээг буцаах буюу дараа нь хийх боломжтой.

**372. Federal agency issues – Холбооны агентлагийн үнэт цаас**

АНУ-ын сангийн яамны баталгаагүйгээр Холбооны агентлагуудаас гаргадаг бага эрсдэлтэй үнэт цаас.

**373. Federal funds – Холбооны нөөц**

Холбооны нөөцийн банкууд оролцдог арилжааны банкуудын хоорондын зээлийн гүйлгээ.

**374. FIFO – Файфо**

Эхэлж орлогодсон нь эхэлж зарлагдах бараа материалын нөөцийн үнэлгээний бүртгэлийн арга.

**375. Filter rule – Шүүлтүүрийн дүрэм**

Саяхан болж өнгөрсөн үнийн өөрчлөлтийн хандлагад үндэслэн хувьцааг авах буюу зарах дүрэм.

**376. Final investor – Эцсийн хөрөнгө оруулагч**

Үнэт цаасны данс дээр байгаа үнэт цаасны эрхийг хэрэгжүүлэгч эцсийн хүлээн авагч (жишээ нь өмчийн эрх, ногдол ашиг авах эрх гэх мэт).

**377. Final Redemption – Эцсийн төлбөр**

Бонд гаргагч бондын нэрлэсэн үнэ дээр хүүг нэмэгдүүлсэн дүнг эргэн төлөх.

**378. Final settlement (final transfer) – Эцсийн тооцоо**

Оролцогчийн эсрэг дампуурлын хэрэг үүссэн ч (шүүхээс луйврын гэмт хэрэг гэж тогтоосноос бусад тохиолдолд) аливаа болзол нөхцөлгүй буцаагдахгүй хэрэгжих шилжүүлэг тооцоо.

a

b

c

d

e

F

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**379. Finance – Санхүү**

Мөнгийг удирдах урлаг, ухаан.

**380. Financial (capital) lease – Санхүүгийн түрээс**

Урт (5 аас дээш жилийн) хугацаатай, түрээсийн нийт төлбөр нь түрээсэлсэн хөрөнгийн өртгөөс илүү, цуцлагдах боломжгүй түрээсийн гэрээ.

**381. Financial Accounting Standards Board (FASB) – Санхүүгийн бүртгэлийн стандартын зөвлөл**

Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг тунхагладаг нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллага.

**382. Financial assets – Санхүүгийн актив**

Бодит активаас авах авлага буюу бодит активын бий болгодог орлого.

**383. Financial break-even point – Санхүүгийн хугарлын цэг**

Татвар ба хүүгийн зардлын өмнөх орлого (EBIT) нь нийт санхүүгийн тогтмол зардлаа дөнгөж хаах түвшин буюу нэгж хувьцааны орлого (EPS) нь тэгтэй тэнцүү байх (EBIT)-ын түвшин.

**384. Financial engineering – Санхүүгийн зохион бүтээл**

Сонирхогч этгээдийн захиалгад нийцүүлэн үнэт цаасыг бий болгох, зохион бүтээх үйл явц.

**385. Financial institution – Санхүүгийн байгууллага**

Засгийн газар, бизнесийн байгууллага, хувь хүмүүсийн хадгаламжийг зээл ба хөрөнгө оруулалт болгон дамжуулдаг зуучлагчид.

**386. Financial intermediaries – Санхүүгийн зуучлагчид**

Зээлдүүлэгчээс эх үүсвэр авч зээлдэгчид зээл олгох хэлбэрээр зээлдэгч зээлдүүлэгчийг холбодог байгууллага.

**387. Financial leverage – Санхүүгийн хөшүүрэг**

Зээлийг буюу санхүүжилтийн тогтмол зардлыг ашиглаж компанийн татвар ба хүүгийн зардлын өмнөх орлого (EBIT)-ын нэгж хувьцааны орлогод (EPS) үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх үйл явц.

**388. Financial management – Санхүүгийн удирдлага**

Бизнесийн байгууллага дахь санхүүгийн менежерийн хариуцсан үүрэг.

**389. Financial manager – Санхүүгийн менежер**

Санхүүгийн, санхүүгийн бус, хувийн, олон нийтийн, том, жижиг, ашгийн, ашгийн бус бүхий л төрлийн компани байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг удирддаг ажилтан.

**390. Financial markets – Санхүүгийн зах зээл**

Мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсэг болон хомсдолтой байгаа хэсгүүдийн хооронд шууд арилжаа хийгддэг зах зээл.

**391. Financial merger – Санхүүгийн нэгдэлт**

Зорилтот компанийн бүтцийг өөрчилж мөнгөн урсгалыг нь сайжруулан далд үнэлэмжийг нь ил болгох зорилгоор нэгдэх гүйлгээ.

**392. Financial planning process – Санхүүгийн төлөвлөлтийн үйл явц**

Урт хугацааны (стратегийн) санхүүгийн төлөвлөгөө, түүнийг удирдлага болгон богино хугацааны (үйл ажиллагааны) төлөвлөгөө боловсруулах, төсөвлөх үйл явц.

**393. Financial risk – Санхүүгийн эрсдэл**

Санхүүгийн үүргээ биелүүлж чадахгүйд хүрэх эрсдэл.

**394. Financial services – Санхүүгийн үйлчилгээ**

Санхүүгийн бүтээгдэхүүнийг бий болгож, тэдгээрийг хувь хүн, бизнесийн байгууллага, засгийн газарт хүргэх үйл явц.

**395. Financing flows – Санхүүжилтийн мөнгөн урсгал**

Өр ба хувьцааны санхүүжилтийн үйл ажиллагааны үр дүнд бий болох бэлэн мөнгөний урсгал, зээл авах ба төлөх, хувьцаагаа зарах ба буцааж худалдаж авах, бэлнээр ногдол ашиг төлөхөөс үүсэх мөнгөний урсгал.

**396. Finished goods inventory – Бэлэн бүтээгдэхүүний нөөц**

Үйлдвэрлэгдэж дууссан боловч зарагдаж амжаагүй байгаа зүйлс.

a

b

c

d

e

F

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**397. Fiscal policy – Сангийн бодлого**

Эдийн засгийг тогтворжуулах зорилгоор засгийн газрын зардал болон татварыг өөрчлөх бодлого.

**398. Fit and proper person – Тохиромжтой этгээд**

Зохицуулагч байгууллагын шаардлагыг үнэнч шударга байдал, ур чадвар туршлага, үйл ажиллагаа, төлбөрийн чадварын хувьд хангасан этгээд.

**399. Five C’s credit – Зээл олгоход баримтлах Таван “Си”-гийн зарчим**

Зээлдэгчийн зээл төлөх чадварыг тодорхойлох зорилгоор компанийн зээлийн шинжээчдээс хэрэглэдэг 5 гол хэмжүүр Character (зээлдэгчийн түүх), Capacity (төлбөрийн чадвар), Capital (санхүүгийн чадвар), Collateral (барьцаа хөрөнгө), Conditions (гадаад нөхцөл).

**400. Fixed income funds – Тогтмол орлоготой үнэт цаасны сан**

Тогтмол орлоготой үнэт цаасанд төвлөрч хөрөнгө оруулдаг хамтын сангийн хэлбэр.

**401. Fixed income securities – Тогтмол орлоготой үнэт цаас**

Тодорхой хугацаанд тодорхой мөнгөн урсгалаар төлбөр хийдэг үнэт цаас (бонд гэх мэт).

**402. Fixed rate loan – Зээлийн тогтмол хүү**

Зээл олгох үеийн суурь хүүн дээр нэмэгдэл хүүг нэмж тогтоогоод зээлийн хугацаа дуусах хүртэл мөрддөг тогтмол хүү.

**403. Fixed rate mortgage – Тогтмол хүүтэй мөргэйж**

Тогтмол хүүтэй, мөргэйжийн хугацаанд сар бүр тэнцүү хэмжээний төлбөр төлөгддөг үл хөдлөх хөрөнгөөр барьцаалагдсан зээл.

**404. Flat yield curve – Жилийн хүүгийн параллель муруй**

Богино ба урт хугацаатай зээлийн хүү харьцангуй адилхан болохыг харуулах жилийн хүүгийн муруй

**405. Float - Замд яваа мөнгө**

Төлбөр хариуцагчаас шилжүүлсэн мөнгө, төлбөр хүлээн авагчийн дансанд ороогүй байх нөхцөл.

**406. Floating inventory lien - Бараа материалын барьцаанаас авах авлага**

Зээлдэгчийн барьцаалуулсан бараа материалын үлдэгдлээс авах зээлдүүлэгчийн авлага.

**407. Floating-rate bonds - Хөвөгч хүүтэй бонд**

Зах зээлийн нөхцөлийг харгалзан хүү нь тодорхой хязгаарын дотор үе үе хэлбэлзэх боломжтой бонд.

**408. Floating-rate loan - Зээлийн хөвөгч хүү**

Зээл олгох үеийн суурь хүүн дээр нэмэгдэл хүүг нэмж тогтоогоод зээлийн хугацаа дуусах хүртэл суурь хүүгийн өөрчлөлтийн даган хөвөгч хүү.

**409. Floor broker - Давхрын брокер**

Хөрөнгийн биржийн суудал эзэмшигч, бие даасан гишүүн брокер.

**410. Flotation costs - Гаргалтын зардал**

Үнэт цаасыг гаргаж борлуулахтай холбогдсон нийт зардал.

**411. Foreign bond - Гадаадын бонд**

Хөрөнгө оруулагчийн орны мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн, хөрөнгө оруулагчийн орны зах зээл дээр зарагддаг, гадаадын компани, засгийн газраас гаргаж буй бонд.

**412. Foreign direct investment - Гадаадын шууд хөрөнгө оруулалт**

Гадаад улс руу хийх хөрөнгө, менежмент, техникийн шилжүүлэг.

**413. Foreign exchange manager - Гадаад валютын менежер**

Гадаад валютын ханшны өөрчлөлтөөс учрах эрсдэлийг удирдаж байдаг менежер.

a

b

c

d

e

F

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**414. Foreign exchange settlement risk (cross-currency settlement risk)****- Гадаад валютын тооцооны эрсдэл**

Гадаад валютын гүйлгээнд оролцогч тал зарсан валютаа шилжүүлчихээд худалдан авсан валютаа хүлээн авахгүй байх эрсдэл. Энэ бол үндсэн төлбөрийн эрсдэлийн нэг хэлбэр.

**415. Forward contract - Форвард хэлцэл**

Урьдчилан тохирсон тодорхой үнээр, тодорхой хугацаанд активыг хүргэж өгөх үүрэг.

**416. Forward rate - Форвард хүү**

Урт хугацаатай бондын хүлээгдэж буй өгөөжийг богино хугацаатай бондын хугацааг сунгах замаар өгөөжтэй нь тэнцүүлдэг богино хугацаат ирээдүйн хүү.

**417. Fourth market - Дөрөвдөгч зах зээл**

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцааг хөрөнгө оруулагчид брокерийн зуучлалыг алгасан өөр хоорондоо шууд арилжих үйл явц.

**418. Free-of-payment (FOP) delivery - Төлбөргүй хүргэлт**

Эх үүсвэрийн шилжүүлэгтэй холбогдохгүй хийгддэг үнэт цаасны хүргэлт.

**419. Friendly merger - Нөхөрсөг нэгдэлт**

Зорилтот компанийн удирдлага нь дэмжиж, хувьцаа эзэмшигчид нь баталсан нэгдэх гүйлгээ.

**420. Fully diluted EPS - Нэгж хувьцаанд бүрэн уусгасан ашиг**

Тэнцлийн гадуурх бүх төрлийн үнэт цаасыг хөрвүүлэн, хэлцлийг хэрэгжүүлсний эцэст нийтэд нь энгийн хувьцаанд шилжүүлж тооцсон нэгж хувьцааны ашиг.

**421. Fully modified mortgage pool - Бүрэн шинэчлэгдсэн моргэйжийн багц**

Үнэт цаас эзэмшигчдийн үндсэн авлага, хүүгийн авлагыг баталгаажуулсан моргэйжийн багц.

**422. Fundamental analysis – Суурь шинжилгээ**

Компанийн ашиг, ногдол ашиг, ирээдүйн төлөв, эрсдэл, хүүгийн хүлээгдэж буй хувь зэрэг хувьцааны үнийг тодорхойлогч хүчин зүйлсийн судалгаа.

**423. Funds transfer system (FTS) – Эх үүсвэр шилжүүлгийн систем**

Гишүүдийн хооронд үүсэх мөнгөн төлбөрийн үүргүүдийг дамжуулах, харилцан суутгах, цэвэршүүлэх, тооцоо хийхэд зориулсан хувийн гэрээ, хууль тогтоомж, олон этгээдийн гишүүнчлэл, нэгдсэн журам, стандартад тулгуурлах албан ёсны тогтолцоо.

**424. Fungibility – Орлуулах чанар**

Адил төстэй үнэт цааснуудын харилцан орлуулах чанар.

**425. Future value – Ирээдүйн үнэлэмж (үнэ цэнэ)**

Тодорхой хугацааны хооронд нийлмэл хүүг ашиглан тооцдог мөнгөний өнөөгийн дүнгийн ирээдүйн үнэлэмж (үнэ цэнэ).

**426. Future value interest factor (FVIF) – Ирээдүйн үнэлэмжийн (үнэ цэнийн) хүүгийн хүчин зүйл**

Хүүгийн хувь тодорхой нөхцөлд, өнөөгийн мөнгөний ирээдүйн үнэлэмжийг (үнэ цэнийг) тооцоход ашигладаг үржүүлэгч.

**427. Future value interest factor for an annuity (FVIFA) – Үе тутмын төлбөр дэх ирээдүйн үнэлэмжийн (үнэ цэнийн) хүүгийн хүчин зүйл**

Хүүгийн хувь тодорхой нөхцөлд, энгийн үе тутмын төлбөрийн ирээдүйн үнэлэмжийг (үнэ цэнийг) өгөгдсөн хугацааны дараа тооцоход ашигладаг үржүүлэгч.

**428. Futures contract – Ирээдүйн хэлцэл**

Активыг урьдчилан тохирсон үнээр, тодорхой хугацааны дараа худалдах буюу худалдан авах үүрэг.

**429. Futures price – Ирээдүйн хэлцлийн үнэ**

Ирээдүйн хэлцлийн хугацааны эцэст төлөхөөр урьдчилан тохиролцсон үнэ.

a

b

c

d

e

F

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**430. General Announcement – Ерөнхий мэдэгдэл**

Компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдэд тодорхой үйл явдлыг мэдэгдэх зорилгоор ашиглах ба уг мэдэгдлийг хэд хэдэн хэлбэрээр хүргэж болно.

**431. General clearing member – Клирингийн ерөнхий гишүүн**

Өөрийн нэрийн өмнөөс болон харилцагчдын нэрийн өмнөөс, зах зээлийн бусад оролцогчдын нэрийн өмнөөс харилцан суутгал хийдэг клирингийн байгууллагын гишүүн.

**432. Generally accepted accounting principles (GAAP) – Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд**

Санхүүгийн бүртгэлийн стандартын зөвлөлөөс баталсан санхүүгийн бүртгэл, тайланг бэлтгэх, хөтлөх тэргүүн туршлага, журмын үндсэн чиглэл.

**433. Global certificate – Ерөнхий гэрчилгээ**

Гаргасан үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хамардаг ганц тооны биет гэрчилгээ.

**434. Global custodian – Олон улсын хадгаламжийн байгууллага**

Дэлхийн хэд хэдэн улсад төлбөр тооцоо нь хийгдэн арилжаалагдаж буй үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээг харилцагчиддаа үзүүлдэг байгууллага.

**435. Golden parachutes – Алтан шүхэр стратеги**

Зорилтот компани нь бусад компанийн эзэмшилд очсон нөхцөлд зорилтот компанийн гол удирдлагуудад томоохон хэмжээний урамшуулал өгөхөөр тусгасан хөдөлмөрийн гэрээ. Эзэмшигч компанийн хувьд энэ нь ихээхэн зардалтай байдаг учир хамгаалалт болдог.

**436. Governance – Засаглал**

Байгууллагын зорилгыг тодорхойлж, түүнд хүрэх арга замыг таниж, үйл ажиллагааг үнэлдэг тогтолцоо.

**437. Greenmail – Ногоон шуудан стратеги**

Зорилтот компани нь өөрийн нэг буюу хэд хэдэн хувьцаа эзэмшигчээс ихээхэн хэмжээний хувьцааг хувийн хэлцлээр зах зээлийн үнээс дээгүүр үнээр буцаан худалдаж авч дээрэнгүй эзэмшлээс хамгаалдаг стратеги.

**438. Gridlock – Бөглөрөл**

Эх үүсвэр болон үнэт цаасны шилжүүлгийн системд зарим шилжүүлгийн даалгаврыг гүйцэтгээгүйгээс болоод бусад оролцогчдын даалгаврыг биелүүлж чадахгүйд хүрэх байдал.

**439. Gross domestic product – Дотоодын нийт бүтээгдэхүүн**

Тодорхой хугацааны дотор үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний зах зээлийн үнэлэмж (үнэ цэнэ).

**440. Gross margin – Нийт мааржин**

Оролцогч өөрийн харилцагчиддаа зориулсан мааржинаа төв харилцагч дээр өндөрлөсөн нь харилцагч бүрийн мааржин шаардлагуудын нийлбэртэй тэнцүү байх механизм.

**441. Gross profit margin – Нийт ахуйц ашиг**

Борлуулсан барааны өртгөө төлсний дараа үлдэж байгаа борлуулалтын төгрөг тутмын ашгийн хувь. Борлуулалтаас борлуулсан барааны өртгийг хасч (нийт ашиг гарна) борлуулалтын дүнд хувааж тооцно.

**442. Gross settlement – Нийт тооцоо**

Шилжүүлгийн даалгаврыг нэг нэгээр нь хийх тооцоо.

**443. Guarantee fund – Баталгааны сан**

Оролцогчдын зарим нь төлбөр хийгээгүй нөхцөлд бусад оролцогч алдагдлыг нь хүлээж байдаг сан.

**444. Haircut – Үс тайралт**

Суурилсан активын зах зээлийн үнэлэмж тодорхой хувиар буурахад тэрхүү актив хөрөнгийн үнэлгээг тайрдаг эрсдэлийн хяналтын арга хэмжээ (“үс тайралт”).

**445. Hedge ratio or delta – Хамгаалалтын харьцаа буюу дельта**

Нэг опционыг эзэмшсэнээс үүсэх үнийн эрсдэлээс хамгаалахын тулд шаардагдах хувьцааны тоо.

**446. Hedging – Хамгаалах**

Үнийн тааламжгүй өөрчлөлтийн эрсдэлээс хамгаалах, зайлсхийх.

a

b

c

d

e

f

G

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**447. Historic weights – Урт хугацааны үнэлгээний жин**

Капиталын жинхэнэ бүтцэд тулгуурласан бүртгэлийн буюу зах зээлийн үнэлгээний жин.

**448. Holders of record – Бүртгэлээр эзэмшигчид**

Хувьцааны бүртгэлийн өдрөөр компанийн хувьцаа эзэмшигчид.

**449. Holding company – Толгой компани**

Нэг буюу түүнээс дээш тооны компанийн хяналтын багцыг эзэмшдэг компани.

**450. Holding period return – Эзэмших хугацааны өгөөж**

Хөрөнгө оруулалтын хугацааны өгөөж буюу үнэт цаасны үнийн өөрчлөлт ба орлогыг багтаасан нийт өгөөж.

**451. Horizon analysis – Хэвтээ шинжилгээ**

Хөрөнгө оруулалтын хугацааны эцэс дэх жилийн хүүгийн муруйг таамаглах замаар бондын өгөөжийг урьдчилан таамаглах үйл явц.

**452. Horizontal merger – Хэвтээ нэгдэлт**

Нэг төрлийн бизнес эрхэлдэг компаниудын нэгдэлт.

**453. Hostile merger – Дээрэнгүй нэгдэлт**

Зорилтот компанийн удирдлагын дэмжлэгийг авалгүйгээр зах зээл дээрээс хувьцааг нь худалдан авч хяналтыг тогтоох нэгдэх гүйлгээ.

**454. Hostile takeover – Дээрэнгүй эзэмшил**

Компанийн удирдлагын дэмжлэггүйгээр гадны бүлэг компанийн хувьцааг зах дээрээс худалдан авч хяналт тогтоох оролдлого.

**455. Hybrid system – Эрлийз систем**

БЦНТ-ны систем (төлбөрийн даалгаврыг үргэлжлүүлэн боловсруулах) болон харилцан суутгах систем (өдөрт хэд хэдэн тооцооны мөчлөгтэй, төлбөрийн даалгаврыг цэвэршүүлэх журамтай)-ийн шинж чанарыг агуулсан холимог систем

**456. Immobilisation - Хөдөлгөөн хязгаарлалт**

Үнэт цаасны болон санхүүгийн хэрэгслийн биет гэрчилгээг ерөнхий хадгаламжид эсвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид байршуулж шилжүүлгийг зөвхөн бүртгэлээр хийх үйл ажиллагаа (хадгаламжийн дансанд дебит буюу кредит гүйлгээ хийн).

**457. Immunization - Дархлаажуулалт**

Цэвэр өөрийн хөрөнгөө хүүгийн өөрчлөлтөөс хамгаалах стратеги.

**458. Implied price of a warrant - Баталгаат эрхийг илэрхийлсэн үнэ**

Бондод хавсрагдсан баталгаат эрх бүрт бодитой төлөх үнэ.

**459. Implied volatility - Шууд бус хэлбэлзэл**

Опционы зах зээлийн үнэлэмжтэй (үнэ цэнэтэй) нийцсэн хувьцааны өгөөжийн стандарт хазайлт.

**460. In the money - Мөнгөн доторхи**

Хэрэгжүүлэхэд ашигтай опцион.

**461. Incentive plans - Урамшууллын төлөвлөгөө**

Удирдлагын урамшууллын төлөвлөгөө нь нэмэгдэл хөлсийг хувьцааны үнэтэй холбох байдлаар хэрэгждэг ба хамгийн нийтлэг урамшууллын төлөвлөгөө нь хувьцаа худалдан авахыг сонгох эрх (хувьцааны сонголт) юм.

**462. Income bonds - Орлогын бонд**

Орлого нь бүрдсэн нөхцөлд л хүүгийн төлбөрийг хийхийг шаардах бонд. Гол төлөв доголдсон компанийн бүтцийн өөрчлөлтөд зориулж гаргадаг.

**463. Income statement - Орлогын тайлан**

Тодорхой хугацааны турш компаниас явуулсан үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг харуулдаг тайлан.

**464. Incremental cash flows - Нэмэлт мөнгөн урсгал**

Санал болгосон хөрөнгийн зарцуулалтын үр дүнд бий болох хүлээгдэж буй нэмэлт мөнгөн урсгал (орох буюу гарах мөнгөн урсгал).

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**465. Indenture – Бондын гэрээ**

Бондыг гаргагч ба эзэмшигчийн эрх үүргийг тодорхойлсон гэрээ.

**466. Index arbitrage – Индексийн арбитраж**

Ирээдүйн хэлцлийн бодит үнэ ба түүний онолын тэнцвэрт үнэлэмжийн зөрүүг ашиглаж эрсдэлгүйгээр ашиг олох стратеги.

**467. Index funds – Индексийн сан**

Зах зээлийн нийтлэг индексүүдийг дуурайж хөрөнгө оруулдаг хамтын сангийн хэлбэр.

**468. Index model – Индексийн загвар**

Системийн эрсдэлийн хүчин зүйлсийг S&P500 гэх зах зээлийн индексээр төлөөлүүлж тооцдог хувьцааны өгөөжийн загвар.

**469. Indirect holding system – Шууд бус эзэмшлийн систем**

Хөрөнгө оруулагчид зөвхөн үнэт цаас хадгалагчийнхаа түвшинд танигддаг үнэт цаасны хадгаламж ба өмчлөл шилжүүлгийн олон шатлалт систем.

**470. Indirect participant – Шууд бус оролцогч**

Үнэт цаасны төлбөр тооцооны олон шатлалт системийн үед шууд оролцогч системээс зөвшөөрөх хэмжээний зарим үйл ажиллагаанд зуучлагчийн үүрэг (ялангуяа тооцоонд) гүйцэтгэх тохиолдол.

**471. Individual investors – Хувь хөрөнгө оруулагчид**

Хувийн хөрөнгө оруулалтын зорилгоор харьцангуй цөөн тооны хувьцаа худалдаж авсан хөрөнгө оруулагчид.

**472. Industry life cycle – Салбарын амьдралын мөчлөг**

Нас нь тогтворжих хүртлээ туулж өнгөрүүлдэг мөчлөгийн үе шатууд.

**473. Inflation – Инфляци**

Бараа үйлчилгээний ерөнхий үнийн түвшний өсөлтийн хувь.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**474. Informational content – Ногдол ашгийн мэдээлэл**

Компанийн ногдол ашгаар дамжиж ирээдүйн орлогын талаар өгөгддөг мэдээлэл. Хувьцаа эзэмшигчид энэ мэдээлэлд үндэслэн хувьцааны үнийг дээгүүр буюу доогуур тогтоох эсэхээ шийддэг.

**475. Initial investment – Анхны хөрөнгө оруулалт**

Санал болгосон төсөлд хамаарах хугацааны эхний мөнгөн зарлага.

**476. Initial margin – Анхны мааржин**

Төв харилцагчаас (ТХ) харилцан суутгал хийдэг хэрэгслүүдийн хувьд оролцогч бүрээс боломжит алдагдлаа хаах зорилгоор ТХ-д (эсвэл клирингийн гишүүнд) байршуулах барьцааны дүн. Анхны мааржинг ТХ-аас тогтоосон томъёогоор тооцож гаргадаг.

**477. Initial public offering (IPO) – Үнэт цаасыг нийтэд анх удаа санал болгох**

Хувийн компаниас анх удаа хувьцаа гаргах арилжаа.

**478. Insider information – Дотоод мэдээлэл**

Компанийн захирал, зөвлөлийн гишүүд, бусад эрх бүхий этгээдийн олж авдаг нийтэд дэлгэгдээгүй мэдээлэл.

**479. Installation costs – Суурилуулалтын зардал**

Хөрөнгийг үйл ажиллагаанд ашиглахад бэлэн байдалд оруулахад шаардагдах бүх нэмэлт зардал.

**480. Installed cost of new asset – Шинэ хөрөнгийн суурилуулалтын зардал**

Шинэ хөрөнгийн зардал ба суурилуулалтын зардлын нийлбэр буюу хөрөнгийн элэгдэл тооцох өртөг.

**481. Institutional investors – Байгууллагын хөрөнгө оруулагчид**

Хамтын сан, тэтгэврийн сан, даатгалын компани зэрэг бусад хүмүүсийн мөнгийг хөлсөөр удирддаг, хөрөнгө оруулалтын мэргэшсэн, их хэмжээний үнэт цаасыг арилжаалдаг хөрөнгө оруулагчид.

a

b

c

d

e

f

g

h

**l**

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**482. Integrity of a securities issue - Үнэт цаас гаргалтын бүрэн бүтэн байдал**

Гаргасан үнэт цаасны тоо нь гүйлгээнд байгаа үнэт цаасны тоотой (хөрөнгө оруулагчийн дансанд хүчинтэй бүртгэгдсэн) байнга таарч байх үнэт цаасны бүртгэлийн журмын хууль ёсны шаардлагын үр дүн.

**483. Interbank funds transfer system (IFTS) - Банк хоорондын эх үүсвэр шилжүүлгийн систем**

Бүх (эсвэл бараг бүх) оролцогчид нь банкны байгууллага байдаг эх үүсвэр шилжүүлгийн систем.

**484. Intercorporate dividends - Компанийн эзэмшиж буй хувьцааны ногдол ашиг**

Нэг компаниас өөрийн энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцаа эзэмшдэг өөр компанид төлж буй ногдол ашиг.

**485. Interest only strips - Хүүгийн стрипс**

Хөрөнгө оруулагчдад зөвхөн хүүгийн төлбөрийн мөнгөн орлогоос төлбөр хийдэг үнэт цаас.

**486. Interest rate - Хүү**

Зээлдэгчээс авсан мөнгөн хөрөнгийнхөө хөлсөнд зээлдүүлэгчид төлж байгаа төлбөр. Зээлдэгчийн хувьд мөнгө зээлсний зардал.

**487. Interest rate parity relationship or covered interest arbitrage relationship - Хүүгийн тэнцвэрт харилцаа буюу хүүгийн хаагдах арбитраж**

Арбитражийн боломжийг арилгадаг валютын спот (одоогийн) ба ирээдүйн ханшны хоорондын харилцаа.

**488. Interest rate swap - Хүүгийн своп**

Хоёр үнэт цаасыг шууд биетээр нь солилгүйгээр хүүгийн мөнгөн урсгалыг солилцохоор хоёр этгээдийн хооронд хийсэн арилжааны гэрээ.

**489. Intermarket spread swap - Зах хоорондын зөрүүний своп**

Бондын зах зээлийн нэг сегментээс нөгөө сегмент руу шилжих үйл явц.

**490. Intermediate cash inflows – Завсрын мөнгөн урсгал**

Төслийг хэрэгжүүлж дуусахаас өмнө хүлээн авсан мөнгөн орлого.

**491. Internal forecast – Дотоод таамаглал**

Компанийн борлуулалтын сувгуудын дотоод зөвшилцөлд үндэслэсэн таамаглал.

**492. Internal rate of return (IRR) – Өгөөжийн дотоод хувь**

Орох мөнгөн урсгалуудын өнөөгийн үнэлэмжийг (үнэ цэнийг) анхны хөрөнгө оруулалттай тэнцүүлж буй хямдруулалтын хувь.

**493. Internal rate of return approach – Өгөөжийн дотоод хувийн арга**

Өөр хоорондоо өрсөлдөх төслүүдээс өгөөжийн дотоод хувь хамгийн өндөртэйг сонгох арга.

**494. Internal settlement – Дотоод тооцоо**

Банк болон хөрөнгө оруулалтын компани дээр байршуулсан үнэт цаас эх үүсвэрийн дансан дээр хийгддэг гүйлгээ.

**495. International Bank Account Number (IBAN) – Олон улсын банкны дансны дугаар**

Олон улсын стандартын байгууллагаас (ОУСБ) гаргасан техникийн кодчилал буюу банкны үндсэн дансны дугаарыг өргөтгөсөн хувилбар. ОУБДД нь тухайн улсын тодорхой санхүүгийн байгууллага дээр байрших хувийн дансыг таньж илрүүлдэг. ОУБДД нь мөн тэрхүү дансанд үйлчилгээ үзүүлж буй санхүүгийн байгууллагыг таньж илрүүлдэг.

**496. International central securities depository (ICSD) – Олон улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага**

Евробондын арилжааны тооцоог хийх зорилгоор байгуулагдсан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага бөгөөд өнөөдрийн байдлаар одоо дотоодын зах зээлээс гаралтай, ялангуяа, мөнгөний бүсийг дамжсан олон улсын хэмжээнд арилжаалагдах үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болсон. Жишээ нь ийм байгууллага Люксембург ба Белгид байна.

a

b

c

d

e

f

g

h

**l**

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**497. International equity market – Олон улсын хөрөнгийн зах зээл**

Компаниас хувьцааныхаа багцуудыг олон орны хөрөнгө оруулагчдад нэгэн зэрэг арилжаалах боломжийг олгодог зах зээл.

**498. Interoperability – Зохицолдоо**

Өөрийн системийн хүрээнд үйл ажиллагаа явуулах хэдий ч үнэт цаасны төлбөр, гүйлгээг систем дамжуулан хийх боломжийг янз бүрийн системийн оролцогчиддоо олгодог зохицуулалт.

**499. Interval closed-end fund – Интервалтай хаалттай сан**

3, 6, 12 сарын интервалтайгаар нийт хувьцааны 5-25 хүртэлх хувийг хөрөнгө оруулагчаас худалдаж авах боломж бүхий хаалттай сан.

**500. Intraday finality – Өдрийн өндөрлөлт**

Тооцооны өдрийн турш буюу өдрийн тодорхой цагт хийгддэг эцсийн тооцоо.

**501. Intraday liquidity – Өдрийн хөрвөх чадвар**

Санхүүгийн байгууллагаас төлбөр тооцоогоо хийхийн тулд ажлын өдөрт багтаан зээлэх боломжтой эх үүсвэр.

**502. Intrinsic value – Жам ёсны үнэлэмж (үнэ цэнэ)**

Өгөөжийн шаардагдах хувиар хямдруулсан компанийн ирээдүйн цэвэр мөнгөн орлогын өнөөгийн үнэлэмж (үнэ цэнэ).

**503. Intrinsic value of option – Опционы жам ёсны үнэлэмж (үнэ цэнэ)**

Активын зах зээлийн үнэ, хэрэгжүүлэх үнэ хоёрын зөрүү буюу мөнгөн доторхи авах опционыг шууд хэрэгжүүлснээр олж болох ашиг.

**504. Inventory turnover – Бараа материалын эргэлт**

Бараа материалын хөрвөх чадварын хэмжүүр.

**505. Inverted yield curve – Жилийн хүүгийн урвуу муруй**

Урт хугацаатай зээлийн хүү богино хугацаатай зээлийн хүүгээс хямд болохыг харуулах жилийн хүүгийн доошоо хазайсан муруй.

**506. Investment – Хөрөнгө оруулалт**

Ирээдүйд илүү нөөц бий болгох хүлээлтэйгээр өнөөгийн нөөцийг хуваарилан ашиглах.

**507. Investment banker – Хөрөнгө оруулалтын банк (ХОБ)**

Компаниас ба засгийн газраас гаргасан үнэт цаасыг нийтэд арилжаалдаг санхүүгийн зуучлагч.

**508. Investment bankers – Хөрөнгө оруулалтын банк**

Нэгдэлтийн үед тохиромжтой зорилтот компанийг хайж олох, хэлэлцээрийн явцад туслалцаа авах зорилгоор эзэмших компаниас хөлслөн ажиллуулдаг санхүүгийн зуучлагч.

**509. Investment companies – Хөрөнгө оруулалтын компани**

Хөрөнгө оруулагчийн нэрийн өмнөөс сангуудыг удирдлага компани. Хөрөнгө оруулалтын компани хэд хэдэн хамтын сангуудыг зэрэг удирдах нь бий.

**510. Investment companies – Хөрөнгө оруулалтын компани**

Хувийн хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийг үнэт цаас болон бусад активт оруулдаг санхүүгийн зуучлагч.

**511. Investment flows – Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал**

Хөрөнгө оруулалтын шинж чанартай болон үндсэн хөрөнгийн худалдан авалт, борлуулалтаас үүсэх бэлэн мөнгөний урсгал.

**512. Investment fund – Хөрөнгө оруулалтын сан**

Жижиг хөрөнгө оруулагчдаас татан хуримтлуулсан хөрөнгөөр багц үүсгэж шимтгэлийн төлбөртэйгөөр хөрөнгө оруулалт хийдэг компани.

**513. Investment fund assets – Хөрөнгө оруулалтын сангийн актив**

Хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглагдах актив хөрөнгө.

**514. Investment fund cost – Хөрөнгө оруулалтын сангийн зардал**

Хөрөнгө оруулалт хийхтэй холбогдон хөрөнгө оруулалтын сангаас гардаг зуучлагчдын үйлчилгээний төлбөр шимтгэл.

a

b

c

d

e

f

g

h

**l**

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**515. Investment fund registrar – Хөрөнгө оруулалтын сангийн бүртгэгч**

Хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийсэн этгээдийн хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэлийг хөтлөх, уг хөрөнгийг гэрчлэх нэгж эрхийн өмчлөх эрхийг бүртгэдэг этгээд.

**516. Investment grade bond – Хөрөнгө оруулалтын зэрэглэлтэй бонд**

Стандарт энд Пүүрз BBB, Мүүдийз Ваа ба түүнээс дээгүүр зэрэглэлтэй бонд.

**517. Investment horizon – Хөрөнгө оруулалтын хүрээ**

Хөрөнгө оруулалтыг бэлэн мөнгөнд хөрвүүлэхээр төлөвлөсөн хугацаа.

**518. Investment opportunities schedule (IOS) – Хөрөнгө оруулалтын боломжийн хуваарь**

Төслүүдийг өгөөжийн дотоод хувь хамгийн өндрөөс буурах дарааллаар жагсааж харгалзах хөрөнгө оруулалтын төсөвтэй холбосон график.

**519. Investment opportunity set – Хөрөнгө оруулалтын боломжит тавил**

Эрсдэл өгөөжийн хослол бүхий багцын хувилбарууд.

**520. Investment policy – Хөрөнгө оруулалтын бодлого**

Хөрөнгө оруулалт хийх үндсэн нөхцлийг тусгасан баримт бичиг.

**521. Investment risk management – Хөрөнгө оруулалтын эрсдэлийн удирдлага**

Богино хугацаанд алдагдал хүлээх боломжид хамаарах эрсдэлийн удирдлага.

**522. Involuntary reorganization – Албадан дахин зохион байгуулалт**

Дампуурсан компанийн зээлдүүлэгчдийн нэрийн өмнөөс гаргадаг компанийн бүтцийг дахин өөрчилж өглөгөө төлөхийг илэрхийлсэн өргөдөл.

**523. IOSCO – Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага**

Олон улсын үнэт цаасны зах зээлийг зохицуулах зорилготой байгууллага.

**524. ISIN code - Олон улсын үнэт цаасны дугаар**

12 тэмдэгт бүхий олон улсын хэмжээнд үнэт цаасыг таних дугаар. Эхний хоёр үсэг нь улсын код, дараагийн 9 тэмдэгт нь тухайн үнэт цаасны үндэсний таних код, сүүлийн нэг тоо нь хяналтын цифр

**525. Issued shares - Зарласан хувьцаа**

Компанийн нийт зарласан хувьцаа. Энэ нь нийтийн эзэмшлийн хувьцаа ба компанийн мэдлийн хувьцааны нийлбэрээр тодорхойлогддог.

**526. Jensen measure - Женсений хэмжүүр**

Хөрөнгө оруулалтын альфа хэмжүүр. Хөрөнгө активын үнэлгээний загвараар тогтоосноос илүү гарсан дундаж өгөөж.

**527. Judgmental approach - Таамаглан тооцох арга**

Тэнцлийн зарим үзүүлэлтийг таамаглаж бусдыг нь тооцоолон гаргаж, гадны санхүүжилтийг тэнцлийн зөрүүг бөглөх үзүүлэлт болгон ашигладаг тэнцлийн төсөл боловсруулдаг арга.

**528. Junk bonds - Өндөр эрсдэлтэй бонд**

Мүүдийгийн Ва, Стандарт Пүүрсийн ВВ-гээс доогуур ангиллын бонд.

**529. Just-in-time (JIT) system - Яг цагт нь систем**

Бүтээгдэхүүний орц материал түүхий эдийг үйлдвэрлэлд яг хэрэгтэй цагт нь ирүүлэх замаар бараа материалын нөөцийг хамгийн бага байлгадаг удирдлагын систем.

**530. Lamfalussy standards - Ламфэллюсийн стандарт**

Хил дамжсан олон валютын гүйлгээний үйл ажиллагааг зохицуулдаг зургаан стандарт.

**531. Large-value funds transfer system (wholesale funds transfer system) - Том дүнтэй эх үүсвэр шилжүүлгийн систем**

Том дүнтэй, эн тэргүүнд хийх ёстой шилжүүлгийг системийн оролцогчид өөр хоорондоо өөрийн нэрийн өмнөөс буюу харилцагчийн нэрийн өмнөөс хийдэг эх үүсвэр шилжүүлгийн систем.

**532. Leading economic indicators - Эдийн засгийн тэргүүлэх үзүүлэлт**

Эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөхөөс түрүүлж өсөж буурч байдаг үзүүлэлт.

a

b

c

d

e

f

g

h

i

J

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**533. Lease-versus-purchase (or lease-versus-buy) decision - Түрээслэх-зээлээр авах (түрээслэх- авах) шийдвэр**

Шинээр үл хөдлөх хөрөнгө авах гэж байгаа компанийн хувьд тулгардаг түрээслэх, зээлээр худалдан авах, эсвэл өөрт байгаа бэлэн мөнгөөрөө худалдан авах эсэхийг тодорхойлсон шийдвэр.

**534. Leasing - Түрээс**

Татвараас чөлөөлөгдөх тодорхой цуврал төлбөрийг гэрээний дагуу төлж үндсэн хөрөнгийг эзэмших үйл ажиллагаа.

**535. Legal risk - Хуулийн эрсдэл**

Хууль тогтоомжийн урьдчилан тооцоолж байгаагүй хэрэгжүүлэлт болон гэрээний үүрэг биелээгүйгээс алдагдал үүсэх эрсдэл.

**536. Lessee - Түрээслэгч**

Түрээсийн гэрээний дагуу үндсэн хөрөнгийн үйлчилгээг авагч.

**537. Lessor - Түрээслүүлэгч**

Түрээслүүлж байгаа үндсэн хөрөнгийн өмчлөгч.

**538. Letter of credit - Аккредитив**

Компанийн харилцагч банкнаас гадаадын нийлүүлэгчид гаргаж өгдөг, гэрээний бүх нөхцөл биелсэн тохиолдолд нэхэмжлэлийн дагуу төлбөрийг хийхийг заасан банкны баталгаа.

**539. Letter to Stockholders - Хувьцаа эзэмшигчдэд илгээх захидал**

Хувьцаа эзэмшигчдийн жилийн тайлангийн эхний хэсэг бөгөөд удирдлагаас тайлагнадаг анхны мэдээлэл юм.

**540. Leverage - Хөшүүрэг**

Зээллэгээр санхүүжих үйл явц буюу тогтмол зардалтай хөрөнгө, эх үүсвэрийг ашиглах замаар компанийг өмчлөгчдийн өгөөжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа.

**541. Leverage ratio - Хөшүүргийн харьцаа**

Компанийн өр төлбөр ба нийт өөрийн хөрөнгийн харьцаа.

#### **542. Leveraged buyout (LBO) – Зээлээр худалдах авах**

Ихээхэн хэмжээний зээлийн эх үүсвэрийг ашиглан компанийг худалдан авах арга техник.

#### **543. Leveraged lease – Хөшүүргийн түрээс**

Үндсэн хөрөнгийн өртгийн 20 орчим хувийг түрээслүүлэгчээс хувь оролцоо болгон гаргаж үлдэх хэсгийг зээлдүүлэгч гаргах түрээс.

#### **544. Leveraged recapitalization – Зээлээр хөрөнгөжүүлэлтийн стратеги**

Зээл авч ихээхэн хэмжээний ногдол ашиг хуваарилснаар санхүүгийн хөшүүргээ ихэсгэж эзэмшигдэхээс зайлсхийдэг зорилтот компанийн стратеги.

#### **545. Lien – Барьцаанаас авах авлага**

Барьцаанаас авах нийтэд зарлагдсан хууль ёсны авлага.

#### **546. LIFO – Лайфо**

Сүүлд орлогодсон нь эхэлж зарлагадна гэсэн бараа материалын нөөцийн үнэлгээний бүртгэлийн арга.

#### **547. Limit order – Хязгаарлалттай захиалга**

Үнэт цаасны зах зээлийн үнэ тодорхой түвшинд хүрсэн тохиолдолд худалдаж авах буюу худалдах захиалга.

#### **548. Limited liability corporation (LLC) – Хязгаарлагдмал хариуцлагатай компани**

Үүсгэн байгуулагчдын тоо нь 50-аас дээшгүй, хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаагаа гаргадаг компани.

#### **549. Limited Partnership (LP) – Хязгаарлагдмал нөхөрлөл**

Хамгийн багадаа зах нь нөхөрлөлийн нэг гишүүн (ерөнхий гишүүн) бүрэн хариуцлагатай бусад гишүүд нь хязгаарлагдмал хариуцлагатай байдаг нөхөрлөл. Хязгаарлагдмал хариуцлагатай гишүүд нь компанийн удирдлагын үйл ажиллагаанд оролцдоггүй идэвхигүй хөрөнгө оруулагчид болно.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

L

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**550. Line of credit – Зээлийн шугам**

Тодорхой хугацааны турш, тодорхой дүнгээр богино хугацаатай барьцаагүй зээл авахаар компани ба арилжааны банк хоёрын хооронд байгуулсан гэрээ.

**551. Line of credit – Зээлийн шугам**

Харилцагчаас борлуулагч компанид төлөх өрийн дээд хэмжээ.

**552. Linked trade – Холбогдсон арилжаа**

Өөр арилжаанаас суларсан үнэт цаасаар хүргэлт хийгдэх нөхцөлтэй үнэт цаасны арилжаа.

**553. Liquidation value per share – Нэгж хувьцааны үлдэгдэл өртгийн арга**

Компанийн бүх активыг зах зээлийн үнээр нь зарж бүх өр төлбөрөө (давуу эрхтэй хувьцааны өглөгийг оруулаад) төлөөд үлдэх мөнгийг энгийн хувьцааны тоонд хуваасан дүн буюу нэгж энгийн хувьцааны жинхэнэ үнэлгээ.

**554. Liquidity – Хөрвөх чадвар**

Компанийн богино хугацаат өр төлбөрүүдээ төлөх чадвар.

**555. Liquidity preference theory – Хөрвөх чадварыг давууд үзэх онол**

Урт хугацаатай үнэт цаасны хөрвөх чадвар нь сул, хүүгийн ерөнхий түвшнээс хамаарах нь хүчтэй байх тул дурын үнэт цаас гаргагчийн хувьд урт хугацаатай үнэт цаасны хүү нь богино хугацаатай үнэт цаасны хүүгээс өндөр байна, тийм учраас жилийн хүүгийн муруй дээшээ хазайна гэж үзэх онол.

**556. Liquidity preferences – Хөрвөх чадварыг давууд үзэх хандлага**

Богино хугацаатай үнэт цаасыг давуутайд үзэх хөрөнгө оруулагчдын ерөнхий хандлага.

**557. Liquidity premium – Хөрвөх чадварын урамшуулал**

Урт хугацаатай бондын эрсдэлийг нөхөх зориулалтаар хөрөнгө оруулагчдаас шаарддаг нэмэгдэл өгөөж.

**558. Liquidity risk – Хөрвөх чадварын эрсдэл**

Харилцагч тал төлбөрийн үүргээ хугацаанд нь бүрэн хэмжээгээр гүйцэтгэж чадахгүй байх эрсдэл.

**559. Load – Шимтгэлийн төлбөр**

Хамтын сангийн арилжааны шимтгэлийн төлбөр.

**560. Loan amortization – Зээлийн барагдуулалт**

Тодорхой хүүтэй зээлийг тодорхой хугацааны эцэст үндсэн өр, хүүгийн хамт бүрэн төлж барагдуулахын тулд жил тутам тэнцүү хэмжээтэй төлөх мөнгөн төлбөрийн тогтоолт.

**561. Loan amortization schedule – Зээлийн барагдуулалтын хуваарь**

Зээлийг тэнцүү хэмжээний төлбөрүүдээр барагдуулах хуваарь. Энэ нь тухайн төлбөр бүрт орсон үндсэн өр ба хүүгийн хэмжээг харуулдаг.

**562. London Interbank Offered Rate (LIBOR) – ЛАЙБОР**

Лондонгийн мөнгөний төв болсон банк хоорондын зээлийн хүү. Мөн Евро валютын зээлд тогтоогдсон суурь хүү.

**564. Long position – Урт байршил**

Активыг худалдаж авах үүрэгтэй ирээдүйн хэлцэлд оролцогч тал.

**565. Long-term (strategic) financial plans – Урт хугацааны (стратегийн) санхүүгийн төлөвлөгөө**

Урт хугацаанд төлөвлөгдсөн санхүүгийн үйл ажиллагаа ба тэрхүү үйл ажиллагааны санхүүгийн үр дагавар.

**566. Long-term debt – Урт хугацаат өр**

Нэгээс дээш жилийн хугацаанд төлөгдөх өр төлбөрүүд.

**567. Long-Term financing – Урт хугацаатай санхүүжилт**

1 жилээс дээш хугацаатай санхүүжилт.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

L

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**568. Loss-sharing agreement – Алдагдал хуваалцах гэрээ**

Клирингийн тооцооны системд оролцогчдоос төлбөрөө гүйцэтгэж чадахгүй болсноос үүсэх алдагдлыг болон системийн алдагдлыг харилцан хуваалцахаар системийн оролцогчдын хооронд хийгдсэн гэрээ.

**569. Lottery (also known as a drawing) – Өр хаах**

Бонд гаргагч сонгосон эзэмшлийн өрийг хугацаанаас нь өмнө барагдуулах.

**570. Low-regular-and-extra dividend policy – Тогтмол ногдол ашгийг багаар, дээр нь илүүг нэмж олгох бодлого**

Ногдол ашгийг зориудаар бага хувиар тооцож тогтмол хуваарилаад хувьцааны ашиг нь ердийнхөөс илүү гарсан тохиолдолд нэмж ногдол ашиг хуваарилах бодлого.

**571. Macaulay duration – Макаулайн үргэлжлэх хугацаа**

Тогтмол орлоготой үнэт цаасны хүүгийн эрсдэлийн хэмжүүр.

**572. Mail float – Шуудангаар яваа мөнгө**

Төлбөр хариуцагчаас төлбөрийг шуудангаар явуулснаас хойш төлбөр хүлээн авагч түүнийг авах хүртэл хугацаа.

**573. Maintenance clauses – Хадгалалтын нөхцөл**

Үйл ажиллагааны түрээсийн хувьд түрээслүүлэгчээс хариуцдаг үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, даатгал, татварын зардал.

**574. Majority voting system – Саналыг энгийн давуугаар тооцох систем**

Захирлуудын зөвлөлийг сонгоход хувьцаа эзэмшигч бүр өөрийн нэгж хувьцаа тутам нэг саналын эрхтэй оролцож, өөрийн бүх хувьцаагаараа санал өгөх эрхтэй сонгуулийн систем.

**575. Mandate for direct debits – Шууд хасалт хийх эрх олгох**

Төлбөр төлөгчийн данснаас шууд хасалт хийхийг төлбөр хүлээн авагчид (эсвэл төлбөр төлөгчийн данс байршиж байгаа байгууллагад) зөвшөөрөх.

**576. Margin – Барьцааны илүүдэл**

Үнэт цаасыг өөрөөр нь барьцаа болгон брокероос зээлсэн мөнгөөр худалдаж авах.

**577. Marginal cost-benefit analysis – Ахиуц зардал-үр ашгийн шинжилгээ**

Ахиуц үр ашиг нь нэмэгдсэн зардлаас илүү байсан нөхцөлд л санхүүгийн шийдвэрийг гаргаж хэрэгжүүлдэг эдийн засгийн зарчим.

**578. Marginal tax rate – Татварын ахиуц хувь**

Орлогын тодорхой түвшнээс илүү гарсан хэсэгт ногдуулдаг татвар.

**579. Market capitalization rate – Зах зээлийн хөрөнгөжүүлэлтийн хувь**

Компанийн мөнгөн урсгалыг хямдруулахад ашиглах зах зээл дээр хүлээн зөвшөөрөгдсөн хямдруулалтын хувь.

**580. Market infrastructure – Зах зээлийн дэд бүтэц**

Үнэт цаас, үүсмэл хэрэгслийн арилжаа, клиринг, төлбөр тооцоонд ашиглагддаг систем.

**581. Market manipulation – Зах зээлийг урвуулан ашиглах**

Үнэт цаасны зах зээл болон түүний үнийн байдалд зохиомол, хуурамч, төөрөгдүүлэх дүр зураг үүсгэх зорилгоор зах зээлийн чөлөөтэй, шударга үйл ажиллагаанд хөндлөнгөөс санаатай нөлөөлөх оролдлого.

**582. Market order – Зах зээлийн захиалга**

Үнэт цаасыг зах зээл дээр одоо байгаа үнээр шууд худалдаж авах буюу худалдах захиалга.

**583. Market portfolio – Зах зээлийн багц**

Багцын бүрэлдэхүүн дэх үнэт цаас бүр нь өөрийн зах зээлийн үнэлэмжтэй (үнэ цэнтэй) пропорциональ хамааралтайгаар орсон багц.

**584. Market premium – Зах зээлийн урамшуулал (хөрвөх үнэт цаасны хувьд)**

Хөрвөх үнэт цаасны зах зээлийн үнэлэмж нь түүний шулуун болон хөрвөлтийн үнэлгээнээс давсан хэсэг.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

M

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**585. Market return – Зах зээлийн өгөөж**

Арилжаалагдаж буй бүх үнэт цаасны зах зээлийн багцын өгөөж.

**586. Market risk, systematic risk, nondiversifiable risk – Зах зээлийн эрсдэл, системийн эрсдэл, тархаагдашгүй эрсдэл**

Нийт эдийн засагтай холбоо бүхий эрсдэлийн хүчин зүйлс.

**587. Market segmentation theory – Зах зээлийн хэсэгчлэлийн онол**

Мөнгөний зах зээл нь хугацааныхаа хувьд хэсэгчлэгддэг, тиймээс зээлийн эрэлт нийлүүлэлтээс шалтгаалан хэсэг тус бүр дээр өөрийн хүү тогтоогддог, жилийн хүүгийн муруйн хазайлт нь хэсэг бүр дээр тогтоогдсон хүүгийн хоорондын ерөнхий хамаарлаар тодорхойлогдоно гэх үзэх онол.

**588. Market stabilization – Зах зээлийн тогтворжилт**

Андеррайтингийн синдикатаас үнэт цаасны эрэлтийг (үнийн түвшинг) хадгалахын зорилгоор хийдэг үнэт цаас худалдаж авах захиалга.

**589. Market timing – Зах зээлийн цагийг олох**

Зах зээл нь сангийн үнэт цааснаас илүү өгөөжтэй байна гэж таамагласан нөхцөлд зах зээлд оруулах хөрөнгөө нэмэгдүүлдэг активын хуваарилалт.

**590. Market value weights – Зах зээлийн нийт үнэлэмжийн жин**

Компанийн гаргасан хувьцааны тоо, нэгж хувьцааны зах зээлийн үнийн үржвэрээр тооцсон жин.

**591. Market value-weighted index – Зах зээлийн нийт үнэлэмжээр жигнэсэн дундаж**

Үнэт цаас бүрийн зах зээлийн нийт үнэлэмжээр жигнэсэн дундаж өгөөжүүдийн индекс. Стандарт энд Пүүрз 500-ын индекс.

**592. Marketable securities – Арилжаалагдах үнэт цаас**

Сул чөлөөтэй хөрөнгөндөө орлого олох зорилгоор компанийн эзэмшдэг богино хугацаатай, хүүтэй мөнгөний зах зээлийн хэрэгсэл.

**593. Marketable securities - Түргэн борлогдох үнэт цаас**

Засгийн газрын богино хугацаат өрийн бичиг, арилжааны бичиг, Засгийн газар, бизнес, санхүүгийн байгууллагын гаргасан шилжих хадгаламжийн сертификат зэрэг богино хугацаат өрийн хэрэгслүүд.

**594. Market-to-book value ratio - Зах зээлийн ба бүртгэлийн үнэлгээний харьцаа**

Хувьцааны зах зээлийн үнийг нэгж хувьцааны бүртгэлийн үнэд харьцуулсан харьцаа.

**595. Marking to markets - Зах зээлээр жиших**

Үнэт цаас болон санхүүгийн хэрэгслүүд ирээдүйн хэлцлээр тогтоогдсон үүргүүдийг зах зээлийн өнөөгийн үнээр дахин тооцох үйл явц.

**596. Matching - Тохируулалт**

Гүйлгээний нөхцөлийг тохиролцох зорилгоор арилжаа тооцооны нөхцөлийг оролцогч талуудаас харьцуулах үйл явц.

**597. Materials requirement planning (MRP) system - Материалын хэрэгцээний төлөвлөлтийн систем**

Захиалгын оновчтой тоо хэмжээний загвар (EOQ)-т үндэслэн үйлдвэрлэлийн хэрэгцээг бараа материалын нөөцийн үлдэгдэлтэй харьцуулах замаар үйлдвэрлэлийн түүхий эд нэг бүрийн захиалга өгөх хугацааг тодорхойлдог бараа материалын удирдлагын систем.

**598. Means of payment - Төлбөрийн хэрэглүүр**

Төлбөр төлөгч болон төлбөр хүлээн авагчийн хооронд хийгдэх гүйлгээнд төлбөр хүлээн авагчаас зөвшөөрсөн актив болон активын авлага.

**599. Merger - Нэгдэлт**

Хоёр ба түүнээс дээш тооны компани нэгдэж аль нэг компанийнхаа нэрийг авах.

**600. Merger with Elections - Нэгдэлт (санал хураалттай)**

Хоёр ба түүнээс дээш тооны компани нэгдэж нэг шинэ компани болно. Үр дүнд нь тогтоосон харьцааны дагуу хуучин компаниудын хувьцааг шинэ компанийн хувьцаагаар солино.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

M

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**601. Miller-Orr model - Миллер-Оррын загвар**

Зардлын хувьд үр ашигтай, гүйлгээний зориулалттай мөнгө хөрөнгийн үлдэгдлийг тодорхойлох загвар. Мөнгөн хөрөнгийн урсгал тодорхойгүй гэсэн санаанд үндэслэсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн дээд хязгаар, оновчтой үлдэгдэл (буцах цэг)-ийг тодорхойлох загвар.

**602. Mixed stream - Холимог мөнгөн урсгал**

Тэнцүү биш хэмжээтэйгээр хийгддэг мөнгөн урсгал буюу тодорхой хэв загваргүй мөнгөн урсгал.

**603. Mobile payment (m-payment) - Мобайл төлбөр**

Мобайл төхөөрөмжөөр (гар утас гэх мэт) эхлүүлж шилжүүлэг хийгддэг төлбөр.

**604. Modified Accelerated Cost Recovery System (MACRS) - Хурдавчилсан өртөг нөхөлтийн тохируулсан систем**

Татварын зорилгоор ашиглагддаг түргэвчилсэн элэгдлийн систем.

**605. Modified DuPont formula - Дю Понтын хувиргасан томъёо**

Компанийн өөрийн хөрөнгийн өгөөж нь нийт активын өгөөж ба санхүүгийн хөшүүргийн үржүүлэгчийн (компанийн нийт актив ба өөрийн хөрөнгийн харьцаа) үржвэртэй тэнцдэг.

**606. Monetary policy - Мөнгөний бодлого**

Төв банкнаас явуулдаг мөнгөний нийлүүлэлт болон хүүгийн түвшинд нөлөөлөх бодлого.

**607. Money market - Мөнгөний зах зээл**

Богино хугацаатай мөнгөний нийлүүлэгч болон хэрэглэгчийн хооронд бий болсон санхүүгийн харилцаа.

**608. Money market funds - Мөнгөний зах зээлийн сан**

Мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулдаг хамтын сангийн хэлбэр.

**609. Money market mutual funds - Мөнгөний зах зээлийн хамтын сан**

Зах зээл дээр түгээмэл арилжаалагддаг мэргэжлийн удирдлагаар хангагдсан үнэт цаасны багц.

**610. Money order - Мөнгөний ордер**

Төлбөр төлөгч болон хүлээн авагч нь санхүүгийн байгууллагад харилцах дансгүй тохиолдолд мөнгийг зайнаас шилжүүлэхэд ашигладаг хэрэгсэл.

**611. Money remitter - Мөнгө гуйвуулагч**

Төлбөр төлөгч болон хүлээн авагчийн дансыг байршуулахгүйгээр төлбөр төлөгчийн эх үүсвэрийг хүлээн авч төлбөр хүлээн авагчид шилжүүлэг хийдэг төлбөрийн үйлчилгээ эрхлэгч.

**612. Mortgage amortization - Моргэйжийн өрийн барагдуулалт**

Моргэйжийн хугацаанд түүний үндсэн өрийг төлж барагдуулах үйл явц.

**613. Mortgage bonds - Моргэйж бонд**

Үл хөдлөх хөрөнгө буюу барилгын зээлээр баталгаажсан бонд.

**614. Mortgage prepayment - Моргэйжийн өрийн урьдчилсан барагдуулалт**

Моргэйжийн хугацаа дуусахаас өмнө түүний үндсэн өрийг бүгдийг нь буюу эсвэл хэсэгчлэн барагдуулах үйл явц.

**615. Mortgage principal - Моргэйжийн үндсэн өр**

Моргэйжийг төлж дуусахад шаардлагатай үндсэн өрийн үлдэгдэл.

**616. Mortgage securitization - Моргэйжийн үнэт цаасжуулалт**

Моргэйжийн зээлийн багцуудаар баталгаажсан үнэт цаас бий болгох үйл явц.

**617. Municipal bonds - Орон нутгийн бонд**

Орон нутгийн засаг захиргаа буюу хотоос гаргадаг татвараас чөлөөлөгдсөн бонд.

**618. Mutual fund - Хамтын сан**

Шинээр хувьцаа гаргаж зарах, хувьцаагаа буцааж худалдаж авах бүрт өөрийн хөрөнгийн хэмжээ нь өөрчлөгдөж байдаг нээлттэй сантай хөрөнгө оруулалтын компани.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

M

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**619. Mutual fund theorem – Хамтын сангийн теорем**

Бүх хөрөнгө оруулагчид эрсдэлтэй активаас бүрдсэн адил багцыг сонирхох бөгөөд түүнийг нь тийм багцаас бүрдсэн хамтын сангаар хангаж болно гэж үзэх теорем.

**620. Mutually exclusive projects – Харилцан үгүйсгэх төслүүд**

Нэг төслийг хэрэгжүүлэх болсон нь нөгөө төслийг авч үзэх шаардлагагүй болгодог өөр хоорондоо өрсөлдсөн төслүүд.

**621. Name Change – Нэр өөрчлөх**

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэр солих тухай саналыг гаргаж шийдвэрлэх энэ шийдвэр нь компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд нөлөөлөөгүй байна.

**622. NASDAQ – Насдак**

Лангууны арилжааны зах зээлийн компьютерт холбогдсон үнийн мэдээллийн систем.

**623. Near cash – Бараг мөнгө**

Түргэн борлогдох чадвартай учраас арилжаалагдах үнэт цаас нь мөнгөн хөрөнгөтэй төстэй.

**624. Negatively correlated – Сөрөг хамаарал (корреляци)**

2 төрлийн хувьсагчуудын утгууд эсрэг чигт өөрчлөгдөх хамаарал.

**625. Neglected-firm effect – Тоогоогүй компанийн нөлөө**

Нэрд гараагүй компанийн хувьцаа нь хэвийн бус өгөөжтэй байх хандлага.

**626. Negotiable certificates of deposit (CDs) – Хадгаламжийн сертификат**

Арилжааны банкин дах хадгаламжийг төлөөлөн мөнгөний зах зээл дээр арилжигддаг үнэт цаас.

**627. Negotiated offering – Хэлэлцээрээр зарах санал**

Үнэт цаасны гаргалтанд ХОБ-ыг өрсөлдүүлэхгүйгээр сонгож ажиллуулах үйл явц.

**628. Net asset value (NAV) – Цэвэр активын үнэлэмж (үнэ цэнэ)**

Нийт активын зах зээлийн үнэлэмжээс нийт өр төлбөрийг хасаад хувьцааны тоонд хуваасан илэрхийлэл.

**629. Net cash flow – Цэвэр мөнгөн урсгал**

Өгөгдсөн хугацааны дотор компанийн авсан бэлэн мөнгөний орлого ба шилжүүлсэн зарлагын зөрүү.

**630. Net margining – Цэвэр мааржин**

Оролцогч өөрийн харилцагчиддаа зориулсан мааржинаа төв харилцагч дээр өндөрлөсөн нь харилцагч бүрийн мааржин шаардлагуудын цэвэр дүнтэй тэнцүү байх механизм.

**631. Net present value (NPV) – Цэвэр өнөөгийн үнэлэмж (үнэ цэнэ)**

Компанийн хөрөнгийн өртгийн хувиар хямдруулан тооцсон төслийн ирээдүйд орох мөнгөн урсгалуудын өнөөгийн үнэлэмжээс (үнэ цэнээс) анхны хөрөнгө оруулалтыг хасч гаргадаг хөрөнгө төсөвлөлтийн дэвшилтэт арга.

**632. Net present value approach – Цэвэр өнөөгийн үнэлэмжийн (үнэ цэнийн) арга**

Эзэмшигчдийн хөрөнгийг хамгийн их байлгах төслүүдийг сонгохдоо цэвэр өнөөгийн үнэлэмжийг (үнэ цэнийг) ашиглах арга.

**633. Net present value profile – Цэвэр өнөөгийн үнэлэмжийн (үнэ цэнийн) дүрслэл**

Хэд хэдэн хямдруулалтын хувиар тооцсон төслийн цэвэр өнөөгийн үнэлэмжийг (үнэ цэнийг) харуулсан график.

**634. Net proceeds – Цэвэр мөнгөн орлого**

Үнэт цаасыг зарснаар олсон цэвэр мөнгөн хөрөнгө.

**635. Net profit margin – Цэвэр ахуйц ашиг**

Хүү, татварыг оролцуулан бүх өртөг зардлаа төлсний дараа үлдэж байгаа борлуулалтын төгрөг тутмын ашгийн хувь. Татварын дараах цэвэр ашгийг борлуулалтын дүнд хувааж тооцно.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

N

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**636. Net settlement - Цэвэр тооцоо**

Банкнаас тухайн өдөрт хийгдсэн нийт гүйлгээгээ цэвэр дүнгээр нь төв банкинд өндөрлөх үйл ажиллагаа.

**637. Net working capital - Цэвэр эргэлтийн хөрөнгө**

Компанийн эргэлтийн актив ба эргэлтийн пассивын зөрүү. Өөрөөр хэлбэл эргэлтийн активын урт хугацаатай эх үүсвэрээр санхүүжсэн хэсэг. Энэ нь эерэг буюу сөрөг утгатай байж болно.

**638. Netting - Цэвэршүүлэх**

Клирингийн тооцооны системд оролцогсдын харилцан хүлээсэн үүргийг гэрээний дагуу цэвэршүүлэх үйл явц. Энэхүү үйл явц нь оролцогсдын цэвэр өглөг авлагын байдлыг тооцон гаргаж хоёр талын болон олон талын хууль ёсны үүргийг цэвэр дүнгээр илэрхийлэн бууруулахад хүргэдэг.

**639. No par value - Нэрлэсэн үнэгүй хувьцаа**

Нэрлэсэн үнэ тогтоож өгөлгүйгээр гаргасан хувьцаа. Хувьцааг зарагдсан үнээр нь бүртгэх боломжтой.

**640. Nominal (stated) interest rate - Нэрлэсэн (тогтоосон) хүүгийн хувь**

Зээлдүүлэгчээс тогтоож зээлдэгчээс төлөхөөр амласан гэрээний хүүгийн хувь.

**641. Nominal rate of interest - Нэрлэсэн хүү**

Мөнгө хөрөнгийн нийлүүлэгчээс тогтоож хэрэглэгчээс төлдөг жинхэнэ хүү.

**642. Nominee - Томилогдсон этгээд (номинал эзэмшигч)**

Бусад этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулахаар томилогдсон байгууллага болон этгээд. Үнэт цаасны гүйлгээнд үнэт цаасны хууль ёсны өмчлөгч болж бүртгүүлэхэд томилогдсон этгээдийг ашиглах нь бий.

**643. Noncash charges - Мөнгөн бус зардлууд**

Орлогын тайланд хасагдаж тооцогддог боловч бодитоор гараагүй зардлууд.

**644. Nonconventional cash flow pattern – Мөнгөн урсгалын хэвшмэл бус загвар**

Хугацааны эхэнд мөнгөн зарлага нэг мөсөн гараад дараа нь цуваагаар мөнгөн орлого орохгүй байдал.

**645. Noncumulative preferred stock – Ногдол ашиг нь үл хуримтлагдах давуу эрхтэй хувьцаа**

Өмнөх үеийн төлөгдөөгүй ногдол ашгийн авлагыг тооцдоггүй давуу эрхтэй хувьцаа.

**646. Nondiversifiable risk – Тархаах боломжгүй эрсдэл**

Активын эрсдэлийн бүх компанид нийтэд нь үйлчилдэг зах зээлийн хүчин зүйлст хамаатай хэсэг.

**647. Nonnotification basis – Мэдэгдэхийг шаардахгүй нөхцөл**

Авлагаа барьцаалуулсан зээлдэгч нь зээлдүүлэгчид заавал мэдэгдэлгүйгээр авлагаа цуглуулж зээлээ төлөх нөхцөл.

**648. Nonparticipating preferred stock – Нэмэгдэл ашгаас хувь үл хүртдэг давуу эрхтэй хувьцаа**

Эзэмшигчид нь зөвхөн тогтоосон ногдол ашиг авдаг давуу эрхтэй хувьцаа.

**649. Nonrecourse basis – Үл буцаах нөхцөл**

Фактор нь худалдаж авсан дансны авлагынхаа зээлийн эрсдэлийг бүрэн хариуцах нөхцөл.

**650. Non-repudiation – Үл татгалзах**

Дараах зүйлсийн нотолгоог гаргаж өгдөг механизм:

- 1) Төлбөрийн мэдээллийн илгээгчийг таньдаг;
- 2) Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг таньдаг.

**651. Nonvoting common stock – Саналын эрхгүй хувьцаа**

Өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхийн зэрэгцээ саналын эрхээ өгөхгүй байхаар зорьж компаниас гаргасан хувьцаа.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

N

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**652. No-par preferred stock – Нэрлэсэн үнэгүй давуу эрхтэй хувьцаа**

Нэрлэж тогтоосон үнэгүй боловч жилийн ногдол ашгийн мөнгөн дүн нь тогтоогдсон давуу эрхтэй хувьцаа.

**653. Normal probability distribution – Магадлалын хэвийн тархалт**

Тэгш хэмтэй, “хонх” хэлбэртэй муруйгаар илэрхийлэгдсэн магадлалын тархалт.

**654. Normal yield curve – Жилийн хүүгийн хэвийн муруй**

Богино хугацаатай зээлийн хүү урт хугацаатай зээлийн хүүгээс хямд болохыг харуулах жилийн хүүгийн дээшээ хазайсан муруй.

**655. Notification basis – Мэдэгдэхийг шаардах нөхцөл**

Авлагаа барьцаалуулсан зээлдэгч нь дансандаа мөнгө ирж орсон тохиолдолд зээлдүүлэгчид мэдэгдэж зээлээ шууд төлөх нөхцөл.

**656. Notional principal – Хийсвэр үндсэн төлбөр**

Свопын төлбөрийг тооцохын тулд ашигладаг үндсэн өрийн дүн.

**657. Odd lot Tender – Сондгой багцийн санал**

100 ширхэг хувьцааг нэг багц гэж үзвэл 50 ширхэг хувьцаа нь нэг багц болж чадахгүй байгаа учраас түүнийг сондгой багц гэж нэрлэн тодорхой өгсөн үнээр зарах санал.

**658. Odd-lot theory – Зөрсөн тааврын онол**

Жижиг хөрөнгө оруулагчдын цэвэр худалдан авалт нэмэгдэж байвал хувцааны зах зээл унахын шинж гэх онол.

**659. Offline card transaction – Сүлжээнд холбогдоогүй картын гүйлгээ**

Гүйлгээ хийх үедээ карт гаргагчтай холбогдохгүйгээр хийж болох зөвшөөрөлтэй картын гүйлгээ.

**660. Online card transaction – Сүлжээнд холбогдсон картын гүйлгээ**

Гүйлгээ хийх үедээ карт гаргагчийн зөвшөөрлийг заавал авч батлуулдаг картын гүйлгээ.

**661. Operating break-even point – Үйл ажиллагааны хугарлын цэг**

Үйл ажиллагааны зардлаа нөхөх борлуулалтын түвшин буюу татвар ба хүүгийн зардлын өмнөх орлого тэгтэй тэнцүү (EBIT=0) байх борлуулалтын түвшин.

**662. Operating cash inflows – Үйл ажиллагааны мөнгөн урсгал**

Төслийг хэрэгжүүлэх явцад бий болсон татварын дараах нэмэлт мөнгөн орлого.

**663. Operating change restrictions – Үйл ажиллагааны хязгаарлалт**

Зээлийн шугамын нөхцөлийн дагуу банкнаас компанийн санхүүгийн байдалд буюу үйл ажиллагаанд тавьдаг гэрээт хязгаарлалт.

**664. Operating cycle – Үйл ажиллагааны мөчлөг**

Компанийн эргэлтийн хөрөнгө нь мөнгөн хөрөнгөөс, бэлэн бүтээгдэхүүн руу, түүнээс дансны авлага руу, түүнээс эргэж мөнгөн хөрөнгө руу шилжих үйл явц.

**665. Operating cycle – Үйл ажиллагааны мөчлөг**

Түүхий эд материал, хөдөлмөр зэргийг худалдан авч эхэлж буй үеэс эхлэн бэлэн бүтээгдэхүүнээ борлуулж авлагаа цуглуулж дуусах хүртэл хугацаа.

**666. Operating flows – Үйл ажиллагааны мөнгөн урсгал**

Компанийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтанд шууд хамааралтай бэлэн мөнгөний урсгал.

**667. Operating lease – Үйл ажиллагааны түрээс**

Богино (5 хүртэлх жилийн) хугацаатай, түрээсийн нийт төлбөр нь түрээсэлсэн хөрөнгийн өртгөөс бага, цуцлах боломжтой түрээсийн гэрээ.

**668. Operating leverage – Үйл ажиллагааны хөшүүрэг**

Үйл ажиллагааны тогтмол зардлыг ашиглан компанийн борлуулалтын өөрчлөлтийн татвар ба хүүгийн зардлын өмнөх орлогод (EBIT) үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх үйл явц.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

**O**

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**669. Operating profit margin – Үйл ажиллагааны ахуйц ашиг**

Хүү, татварыг оруулахгүйгээр бусад бүх өртөг зардлаа төлсний дараа үлдэж байгаа борлуулалтын төгрөг тутмын ашгийн хувь. Борлуулалтаас хүү, татвараас бусад зардлыг хасч (үйл ажиллагааны ашиг гарна) борлуулалтын дүнд хувааж тооцно.

**670. Operating unit – Үйл ажиллагааны нэгж**

Цех, хэлтэс, үйлдвэрлэлийн шугам зэрэг компанийн бодит үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулдаг бизнесийн хэсэг.

**671. Operational risk – Үйл ажиллагааны эрсдэл**

Мэдээллийн систем, дотоод хяналт, хүний алдаа, удирдлагын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн алдагдлаас үүсэх эрсдэл. Энэ нь гадаад болон дотоод үйл явдалд хамаатай.

**672. Opportunity costs – Алдагдсан боломжийн өртөг**

Санал болгосон төсөлд зарцуулж байгаа хөрөнгөөр өөр илүү сонголт хийж олох байсан мөнгөн орлого.

**673. Optimal capital structure – Капиталын оновчтой бүтэц**

Эх үүсвэрийн жигнэсэн дундаж өртөг хамгийн бага, компанийн үнэлэмж хамгийн их байх капиталын бүтэц .

**674. Optimal risky portfolio – Эрсдэлтэй активын оновчтой багц**

Эрсдэлтэй активуудыг эрсдэлгүй активтай хольж бүтэн багц үүсгэсэн хамгийн сайн хувилбар.

**675. Option – Опцион**

Тодорхой эд хөрөнгийг (активыг) тогтоосон үнээр тогтоосон хугацааны өмнө эсвэл эцэст худалдан авах буюу худалдах эрх.

**676. Option elasticity – Опционы уян чанар**

Гол үнэт цаасны үнэлэмж (үнэ цэнэ) нь 1 хувиар нэмэгдэхэд дагаж нэмэгдэх опционы үнэлэмжийн (үнэ цэнийн) өсөлтийн хувь.

**677. Order costs – Захиалгын зардал**

Бараа материалын захиалгыг өгөх ба хүлээж авахад гардаг бичилт тооцооны тогтмол зардал .

**678. Ordinary annuity - Энгийн үе тутмын төлбөр**

Үе тутмын эцэст хийгдэх төлбөр.

**679. Ordinary income - Ердийн орлого**

Компанийн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтаас бий болсон орлого.

**680. Organized securities exchanges - Зохион байгуулагдсан хөрөнгийн бирж**

Эргэлтэнд байгаа үнэт цааснуудыг дахин арилжаалах буюу хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааг эрхэлдэг биет байгууллага.

**681. Out of the money - Мөнгөний алдагдалтай**

Хэрэгжүүлэхэд ашиггүй опцион.

**682. Outstanding shares - Нийтийн эзэмшлийн хувьцаа**

Компаниас гаргаж нийтийн эзэмшилд байгаа хувьцааны үлдэгдэл тоо хэмжээ.

**683. Overhanging issue - Хүлээгдэж буй үнэт цаас**

Буцааж дуудах чанарыг нь ашиглан хөрвүүлэх боломжгүй үнэт цаас.

**684. Oversubscribed issue - Захиалга нь илүүдсэн үнэт цаас**

Бүрэн зарагдсан үнэт цаасны гаргалт.

**685. Oversubscription privilege - Захиалга нь илүүдсэн хувьцааны нөхцөл**

Эрх нь хэрэгжээгүй хувьцааг захиалгын үнийн түвшинд хувь тэнцүүлэн хуваарилдаг систем.

**686. Over-the-counter (OTC) exchange - Лангууны арын арилжаа**

Хөрөнгийн бирж дээр бүртгэгдээгүй үнэт цаасыг зардаг болон худалдан авдаг биет бус зах зээл.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

O

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**687. P/E effect - Үнэ ашгийн харьцааны нөлөө**

Үнэ ашгийн бага харьцаатай хувьцааны эрсдэлээр жигнэсэн өгөөж нь үнэ ашгийн өндөр харьцаатай хувьцааныхаас илүү байдаг тохиолдол.

**688. Paid-in capital in excess of par - Нэмж төлөгдсөн капитал (өөрийн хөрөнгө)**

Энгийн хувьцааг борлуулсан үнэ анхны нэрлэсэн үнээс нь давсан хэсэг.

**689. Par value - Хувьцааны нэрлэсэн үнэ**

Компанийн дүрмийн дагуу нэгж хувьцаанд тогтоож өгсөн ач холбогдол багатай үнэ.

**690. Par Value Change - Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх**

Хувьцааг хуваахтай төстэй бөгөөд хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт оруулна.

**691. Partial Redemption - Хэсэгчилсэн төлбөр**

Бонд гаргагч бондын тодорхой хэсгийн нэрлэсэн үнэ дээр хүүг нэмэгдүүлсэн дүнг эргэн төлөх хугацаанаас өмнө төлөх.

**692. Participating preferred stock - Нэмэгдэл ашгаас хувь хүртдэг давуу эрхтэй хувьцаа**

Эзэмшигчид нь тогтоосон ногдол ашиг авахаас гадна тодорхойлсон томъёоны дагуу илүүдсэн ногдол ашгийн хуваарилалтад энгийн хувьцаа эзэмшигчдийн адилаар оролцох давуу эрхтэй хувьцаа.

**693. Partnership - Нөхөрлөл**

Хоёр ба түүнээс дээш тооны хүмүүсийн эзэмшилд байдаг ашгийн төлөө бизнес.

**694. Par-value preferred stock - Нэрлэсэн үнэтэй давуу эрхтэй хувьцаа**

Нэрлэсэн үнэтэй, жилийн ногдол ашгаас хүртэх хувь нь тодорхойлогдсон давуу эрхтэй хувьцаа.

**695. Passive management - Идэвхигүй удирдлага**

Үнэ нь буруу тогтоогдсон үнэт цаасыг хайхыг оролдолгүйгээр сайн тархаагдсан үнэт цаасны багцыг худалдан авч эзэмших явдал.

**696. Passive strategy – Идэвхигүй стратеги**

Үнэт цаасны шинжилгээнээс зайлсхийсэн хөрөнгө оруулалтын бодлого.

**697. Pass-through securities – Шилжсэн хөрөнгө оруулалтын үнэт цаас**

Орон сууцны зээл гэх мэт багцалсан зээлийн сангаар баталгаажсан үнэт цаас. Шилжсэн хөрөнгө оруулалтын үнэт цаасыг эзэмшигчид нь зээлдэгчээс төлсөн үндсэн өр ба хүүгийн төлбөрийг авдаг.

**698. Payback period – Эргэн төлөх хугацаа**

Төслийн анхны хөрөнгө оруулалтыг мөнгөн орлогын урсгалаараа нөхөхөд компаниас шаардагдах хугацаа.

**699. Payer – Төлбөр төлөгч**

Төлбөрийн даалгавар бичэн төлбөр хүлээн авагчид эх үүсвэр шилжүүлэхийг зөвшөөрөн төлбөрийн гүйлгээнд оролцогч.

**700. Payment – Төлбөр**

Хатуу утгаараа, төлбөр гэдэг бол төлбөр төлөгчийн үүргийг эх үүсвэр шилжүүлэх замаар төлбөр хүлээн авагчаар дамжуулан чөлөөлөгч. Харин техникийн буюу статистик утгаар төлбөрийг “төлбөрийн даалгавар” хэмээн үздэг.

**701. Payment date – Төлбөрийн өдөр**

Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийн төлбөрийг бодитойгоор шилжүүлдэг өдөр.

**702. Payment instrument – Төлбөрийн хэрэгсэл**

Төлбөр төлөгчөөс хүлээн авагчид эх үүсвэр шилжүүлгийг хийдэг дүрэм журам, арга хэрэгсэл. Төлбөр төлөгч, төлбөр хүлээн авагч нь нэг хүн байж болно.

**703. Payment order – Төлбөрийн даалгавар**

Төлбөрийн гүйлгээ хийхийг төлбөр төлөгчөөс болон төлбөр хүлээн авагчаас төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид өгдөг заавар.

**704. Payment scheme – Төлбөрийн схем**

Төлбөрийн үйлчилгээ хэрэгжихэд шаардлагатай банк хоорондын дүрэм журам, туршлага, стандарт.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

**P**

q

r

s

t

u

v

w

x

y

z

**705. Payment system – Төлбөрийн систем**

Энэ нэр томъёо хоёр утгатай:

- 1) Зарим тохиолдолд энэ нь тухайн улсын мөнгөний эргэлт гүйлгээг дэмжих банк хоорондын эх үүсвэр шилжүүлгийг бий болгогч санхүүгийн хэрэгслүүд, банкны дүрэм журам гэж үздэг;
- 2) Ихэнхи тохиолдолд үүнийг “эх үүсвэр шилжүүлгийн систем”-тэй зүйрлэж үзэх нь бий.

**706. Payment-in-kind (PIK) preferred stock – Өөрөөрөө төлөгдөх давуу эрхтэй хувьцаа**

Ногдол ашиг нь нэмэлт давуу эрхтэй хувьцаагаар төлөгддөг давуу эрхтэй хувьцаа.

**707. Peak – Оргил**

Эдийн засгийн өргөжилтийн эцсээс агшилтын эхлэл хүртэлх шилжилт.

**708. Pecking order – Сонгох дараалал**

Санхүүжилт сонгох дараалал. Хуримтлагдсан ашиг-Зээл-Шинээр хувьцаа гаргах.

**709. Percentage advance – Урьдчилгааны хувь**

Барьцааны бүртгэлийн үнэд ногдуулах олгох барьцаат зээлийн хувь.

**710. Percent-of-sales method – Борлуулалтын хувиар тооцох арга**

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, хүүгийн зардал зэргийг борлуулалтын хувиар тооцож орлогын тайлангийн төсөл боловсруулдаг арга.

**711. Perfectly negatively correlated – Төгс сөрөг хамааралтай**

2 төрлийн хувьсагч хоорондын хамаарлын (корреляцын) зэрэг (-1)-тэй тэнцүү байх тохиолдол.

**712. Perfectly positively correlated – Төгс эерэг хамааралтай**

2 төрлийн хувьсагч хоорондын хамаарлын (корреляцын) зэрэг (+1)-тэй тэнцүү байх тохиолдол.

**713. Performance evaluation – Амжилтын үнэлгээ**

Хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хүрээнд багцын менежерээс хир зэрэг өгөөж олсныг дүгнэсэн үнэлгээ.

**714. Performance plans – Гүйцэтгэлийн төлөвлөгөө**

Удирдлагын нэмэгдэл хөлсийг нэгж хувьцаанд ногдох ашиг (НХНА), НХНА-ийн өсөлт, өгөөжийн бусад харьцаануудтай хамааруулдаг төлөвлөгөө. Гүйцэтгэлийн хувьцаа болон бэлэн мөнгөний шагнал нь дээрхи төлөвлөгөөнд хамаарах урамшуулын хэсэг юм.

**715. Performance shares – Гүйцэтгэлийн хувьцаа**

Гүйцэтгэлээр олгох хувьцаа.

**716. Permanent need – Байнгын хэрэгцээ**

Компанийн үндсэн хөрөнгө болон эргэлтийн активын байнгын хэсгийг санхүүжүүлэх хэрэгцээ. Энэ хэрэгцээ жилийн турш өөрчлөгддөггүй.

**717. Perpetuity – Мөнхийн төлбөр**

Цаг хугацааны хязгаарлалтгүйгээр тасралтгүй орох буюу гарах мөнгөн урсгал.

**718. Personal identification number (PIN) – Хувийн таних дугаар**

Төлбөрийн хэрэгслийг ашиглагч өөрийгөө таниулахын тулд хэрэглэдэг хувийн нууц дугаар. Цахим гүйлгээний үед үүнийг гарын үсэгтэй адилтган авч үздэг.

**719. Personal trust – Хувийн итгэмжлэгдсэн төлөөлөгч**

Өөр хүний нэрийн өмнөөс эд хөрөнгийг эзэмшигч итгэмжлэгдсэн төлөөлөгч.

**720. Pledge – Барьцаанд тавих**

Үүргийн гүйцэтгэлийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нэг талаас (өр төлөгчөөс) нөгөө талд (барьцаалагч) актив хөрөнгө хүргүүлэх үйл ажиллагаа. Барьцаалагч талын хувьд хүргүүлсэн актив нь барьцааны зүйл болдог бол өр төлөгчийн хувьд өмч хэвээр байдаг.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

**p**

q

r

s

t

u

v

w

x

y

z

**721. Pledge of accounts receivable – Авлагаа барьцаалах**

Богино хугацаатай зээл авахын тулд авлагын дансаа барьцаа, баталгаа болгон ашиглах.

**722. Plowback ratio or earnings retention ratio – Хуримтлагдсан ашгийн харьцаа**

Компанийн ашгийн бизнест буцааж хөрөнгө оруулсан хэсэг буюу ногдол ашиг болгож хуваарилаагүй хэсэг.

**723. Point-of-sale (POS) terminal – Худалдааны цэгийн терминал**

Худалдааны биет цэг дээр төлбөрийн картыг хүлээн авч ашиглах боломжтой төхөөрөмж. Төлбөрийн мэдээллийг нэг бол цаасан тасалбар дээр гараар эсвэл цахим хэлбэрээр буулган авдаг.

**724. Poison pill – Хортой эм стратеги**

Гаднаас эзэмших оролдлого гармагц хүчинтэй болох тодорхой эрх бүхий хувьцааг гаргах стратеги. Зорилтот компанийн хувьцааны тэр эрх нь эзэмших компанийн хувьд ашиггүй байдаг.

**725. Political risk – Улс төрийн эрсдэл**

Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа буюу улс төрийн үймээн нь гадаадын хөрөнгө оруулагчдад сөргөөр нөлөөлөхөөс үүсэх эрсдэл.

**726. Political risk – Улс төрийн эрсдэл**

Хөрөнгө хураах, татварын бодлого өөрчлөгдөх, валютын солилцоог хязгаарлах зэрэг улсын бизнесийн орчин өөрчлөгдөх эрсдэл.

**727. Portfolio – Багц**

Бүлэг активууд буюу активуудын цуглуулга.

**728. Portfolio insurance – Багцын даатгал**

Өсөлтийн боломжийг хадгалахын зэрэгцээ хөрөнгө оруулалтын алдагдлыг хязгаарладаг багцын стратеги.

**729. Portfolio turnover – Багцын эргэлт**

Багцын арилжааны үйл ажиллагаатай хэсгийг нийт багцын дүнд харьцуулсан харьцаа.

**730. Position netting – Үлдэгдлийг цэвэршүүлэх**

Тус бүрийн анхны өглөг авлагыг өөрчлөхгүйгээр хоёр буюу түүнээс дээш тооны этгээд хоорондын төлбөрийн даалгаврыг цэвэршүүлэх.

**731. Positively correlated – Эерэг хамаарал (корреляци)**

2 төрлийн хувьсагчуудын утгууд нэг чигт өөрчлөгдөх хамаарал.

**732. Preemptive rights – Хувьцааны урьдчилсан эрх**

Шинээр хувьцаа нэмж гаргахад энгийн хувьцаа эзэмшигчдийн компанийн өмчлөлд эзлэх хувь хадгалагддаг систем.

**733. Preferred stock – Давуу эрхтэй хувьцаа**

Энгийн хувьцааны ногдол ашгийг төлөхөөс өмнө ногдол ашгийг үе тутам, тогтмол хувиар төлдөг эзэмшлийн онцгой хэлбэр.

**734. Premium – Урамшуулал**

Үнэт цаасны зарагдсан үнийн нэрлэсэн үнээс илүүдсэн зөрүү.

**735. Prenotification – Урьдчилан мэдэгдэх**

Шууд хасалт хийх гэрээний тохиолдолд эзэлдүүлэгчээс эзэлдэгчид урьдчилан мэдэгдэх:

- 1) Дараагийн шууд хасалт хийх мөнгөний дүн;
- 2) Хасалт хийх огноо.

**736. Prepayment risk – Урьдчилан барагдуулалтын эрсдэл**

Мөргэйжийн үнэт цаасны хөрөнгө оруулагчдад тулгардаг үндсэн өр, хүүгийн урьдчилан барагдуулалтын тодорхойгүй байдал.

**737. Present value – Өнөөгийн үнэлэмж (үнэ цэнэ)**

Ирээдүйн мөнгөний одоогийн үнэлэмж (үнэ цэнэ) хүү, хугацаа нь тодорхой нөхцөлд, ирээдүйд бий болох мөнгөн дүнтэй тэнцүү хэмжээний мөнгөтэй байхын тулд одоо хөрөнгө оруулах мөнгөний дүн.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

**P**

q

r

s

t

u

v

w

x

y

z

**738. Present value interest factor – Өнөөгийн үнэлэмжийн (үнэ цэнийн) хүүгийн хүчин зүйл**

Хорогдуулалтын хувь тодорхой нөхцөлд, өгөгдсөн хугацааны дараа ирээдүйд олж авах мөнгөн дүнгийн өнөөгийн үнэлэмжийг (үнэ цэнийг) тооцоход ашигладаг үржүүлэгч.

**739. Present value interest factor for an annuity – Үе тутмын төлбөр дэх өнөөгийн үнэлэмжийн (үнэ цэнийн) хүүгийн хүчин зүйл**

Хорогдуулалтын хувь тодорхой нөхцөлд, өгөгдсөн хугацааны эцэст үе тутмын төлбөрийн өнөөгийн үнэлэмжийг (үнэ цэнийг) тооцоход ашигладаг үржүүлэгч.

**740. President or chief executive officer (CEO) – Гүйцэтгэх захирал**

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, захирлуудын зөвлөлөөс батлагдсан бодлогуудыг хэрэгжүүлэх үүрэг бүхий албан тушаалтан.

**741. Price/earnings (P/E) ratio – Үнэ ашгийн харьцаа**

Компанийн ашгийн нэг төгрөг бүрийн төлөө хөрөнгө оруулагчдаас төлөхөд бэлэн байгаа мөнгөний хэмжээ. Үнэ ашгийн харьцаа өндөр байх тусам компанийн ирээдүйд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл өндөр байна.

**742. Price/Earnings multiple approach – Үнэ/Ашгийн харьцааг ашиглан хувьцааг үнэлэх арга**

Компанийн нэгж хувьцаанд ногдох хүлээгдэж буй ашгийг (EPS) салбарын үнэ ашгийн дундаж харьцаагаар (P/E) үржүүлж тооцдог компанийн хувьцааны үнэлгээг тогтоох арга.

**743. Price-weighted average – Үнээр жигнэсэн дундаж**

Нэгж хувьцааны үнийг нэмж хүртвэрт хуваасан дундаж. Доу жонсын индексийг тооцдог дундаж.

**744. Primary EPS – Нэгж хувьцаанд шилжүүлсэн үндсэн ашиг**

Үнэлгээ нь хөрвөлт ба энгийн хувьцааны шинж чанараас хамаардаг тэнцлийн гадуурх бүх төрлийн үнэт цаасыг хөрвүүлэн, хэлцлийг хэрэгжүүлсний эцэст нийтэд нь энгийн хувьцаанд шилжүүлж тооцсон нэгж хувьцааны ашиг.

**745. Primary market – Анхдагч зах зээл**

Анх удаа гаргаж буй үнэт цаасыг арилжаалдаг санхүүгийн зах зээл юм. Үнэт цаас гаргагч нь арилжааны гүйлгээнд шууд оролцдог цорын ганц зах зээл.

**746. Prime rate of interest (prime rate) – Суурь хүү**

Банкнаас найдвартай харилцагчиддаа олгодог зээлийн хамгийн бага хүү.

**747. Principal – Үндсэн төлбөр**

Хүү төлөгддөг санхүүгийн хэрэгслийн үндсэн дүн.

**748. Principal only strips – Үндсэн өрийн стрипс**

Хөрөнгө оруулагчдад зөвхөн үндсэн өрийн төлбөрийн мөнгөн орлогоос төлбөр хийдэг үнэт цаас.

**749. Principal risk – Үндсэн өрийн эрсдэл**

Санхүүгийн активыг (мөнгө, үнэт цаас гэх мэт) зарагч нь активаа хүргүүлчихээд төлбөрөө авахгүй байх эрсдэл, эсвэл худалдан авагч нь төлбөрөө хийчихээд байхад актив нь хүргэгдэж ирэхгүй байх эрсдэл. Ийм тохиолдолд шилжүүлсэн эх үүсвэр болон үнэт цаасны нийт үнэлэмжийг эрсдэлд орлоо гэж үздэг.

**750. Private investment fund – Хувийн хөрөнгө оруулалтын сан**

Тодорхой тооноос хэтрэхгүй хөрөнгө оруулагч бүхий компани. Тэдгээр хөрөнгө оруулагчид бусад газар хөрөнгө оруулсан байх нь элбэг.

**751. Private placement – Хувийн арилжаа**

Шинээр гаргаж буй үнэт цаасыг нэг буюу цөөн тооны хөрөнгө оруулагчдад шууд зарах үйл ажиллагаа.

**752. Privately owned (stock) – Хувийн өмчлөлийн (хувьцаа)**

Компанийн нийт хувьцааг нэг хувь хүн өмчлөх тохиолдол.

**753. Pro forma statements – Санхүүгийн тайлангийн төсөл**

Таамаглаж төлөвлөсөн санхүүгийн тайлан (орлогын тайлан, тэнцэл).

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

**p**

q

r

s

t

u

v

w

x

y

z



**754. Probability - Магадлал**

Өгөгдсөн үр дүн тохиолдох боломж.

**755. Probability distribution - Магадлалын тархалт**

Боломжит үр дүнгүүдийг тохиолдох магадлалаар нь илэрхийлсэн загвар.

**756. Proceeds from sale of old asset - Хуучин хөрөнгө зарсны орлого**

Ашиглагдаж байгаа хөрөнгийг зарснаар орж ирэх задаргаа, цэвэрлэгээний зардлыг хассан цэвэр мөнгөн орлого.

**757. Processing - Боловсруулалт**

Шилжүүлгийг системд оруулахаас эхлэн гаргах хүртэл системийн дүрэм журмын дагуу хийгдэх үйл ажиллагаа. Боловсруулалт нь клиринг хийх, ангилах, цэвэршүүлэх, тохируулга хийх, тооцоо хийх үйл ажиллагаануудаас бүрдэж болно.

**758. Processing float - Замд яваа мөнгийг оруулах**

Төлбөр хүлээн авагч чек хүлээн авснаас хойш өөрийн дансанд оруулах хүртэл хугацаа.

**759. Profit margin or return on sales (ROS) - Ашгийн зөрүү буюу борлуулалтын өгөөж**

Борлуулалтын төгрөг тутам ногдох үйл ажиллагааны ашиг (EBIT борлуулалтын харьцаа).

**760. Profitability - Ашигт ажиллагаа**

Компанийн эргэлтийн ба үндсэн хөрөнгийг бүтээлчээр ашигласны үр дүнд үүсэх орлого зарлагын харьцаа.

**761. Program trade - Хөтөлбөрт арилжаа**

Хөтөлбөрийн дагуу зохицуулагдсан хувьцааны нийт багцыг худалдах буюу худалдан авах арилжаа.

**762. Prospectus - Проспектус, Үнэт цаасны танилцуулга**

Үнэт цаасны арилжааны комисст бүртгүүлдэг компанийн үйл ажиллагаа санхүүгийн байдлыг харуулсан мэдээллийн хэсэг. Энэхүү мэдээллийг сонирхсон этгээдэд үзүүлэхийг шаарддаг.

**763. Protective put – Хамгаалалттай зарах опцион**

Зарах опционы хэрэгжүүлэх үнийг баталгаажуулсан орлого бүхий зарах опцион ба бусад активын хослол.

**764. Provisional settlement – Нөхцөлтэй тооцоо**

Зарим нөхцөлийг хангасны дараа л эх үүсвэр болон үнэт цаасны шилжүүлгээр өрөө барагдуулах төлбөрөө гүйцэтгэж болох болзолтой тооцоо.

**765. Proxy battle – Төлөөллийн тэмцэл**

Удирдлагын бус бүлгээс бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн зөвшөөрлийг цуглуулан авч компанийн удирдлагыг гартаа авах оролдлого.

**766. Proxy statement – Төлөөллийн зөвшөөрөл**

Бусад хувьцаа эзэмшигчдэд саналын эрхээ төлөөлүүлэн эдлүүлэх зөвшөөрөл.

**767. Prudent man law – Шударга эрийн хууль**

Харилцагчийн эрх ашгийг өөрийн хувийн эрх ашгаас дээгүүр тавих мэргэшсэн хөрөнгө оруулагчийн хариуцлага.

**768. Public Company Accounting Oversight Board (PCAOB) – Олон нийтийн компанийн Нягтлан бодох бүртгэлийн хяналтын зөвлөл**

Хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалах, үнэн зөв, тал бүрийн, хараат бус аудитын тайлангуудыг бэлтгэж олон нийтийн эрх ашгийг хамгаалахын зорилгоор 2002 оны Сарбанес-Окслэйн хуулиар үүсгэн байгуулагдсан ашгийн байгууллага.

**769. Public offering – Нийтэд санал болгох**

Хувьцаа буюу бондыг олон нийтэд санал болгон арилжих үйл ажиллагаа.

**770. Publicly owned (stock) – Нийтийн өмчлөлийн (хувьцаа)**

Компанийн хувьцааг өөр хоорондоо хамааралгүй олон тооны хувь хүн, байгууллагын хөрөнгө оруулагч өмчлөх тохиолдол.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

**P**

q

r

s

t

u

v

w

x

y

z

**771. Purchase options - Худалдан авах сонголт**

Үйл ажиллагааны ба санхүүгийн түрээсийн хугацаа дуусмагц, түрээслэгчид олгогддог түрээсэлсэн хөрөнгөө гол төлөв урьдчилан тогтоосон үнээр худалдан авах эрх.

**772. Pure yield pickup swap - Жилийн хүүгийн своп**

Жилийн хүү өндөртэй бонд (илүү урт хугацаатай) руу шилжих үйл явц.

**773. Put option - Худалдах опцион**

Тодорхой эд хөрөнгийг (активыг) тогтоосон үнээр тогтоосон хугацааны өмнө эсвэл эцэст худалдах эрх.

**774. Put option - Зарах опцион**

Активыг тодорхой үнээр, тодорхой хугацаа дуусмагц буюу дуусахаас нь өмнө худалдах эрх.

**775. Put/call ratio - Худалдах ба худалдан авах опционы харьцаа**

Хувьцааны худалдах опционы үлдэгдлийг худалдан авах опционы үлдэгдэл харьцуулсан харьцаа.

**776. Puttable bonds - Буцаах бонд**

Бонд гаргагч компани нь бусадтай нийлсэн, бусдыг нэгтгэсэн эсвэл их хэмжээний нэмэлт бонд гаргасан зэрэг бүтцийн онцгой үйл явдал болсон тохиолдолд бонд эзэмшигч нь бондоо нэрлэсэн үнээр нь буцаах боломжтой бонд.

**777. Put-call parity theorem - Авах зарах опционы тэнцвэрийн теорем**

Авах зарах опционы зохистой харилцааны энцэтгэл.

$C - P = S_0 - X / (1 + r_f)^T$  C опционы авах үнэ

P-опционы зарах үнэ

$S_0$ -хувьцааны үнэ

X-хэрэгжүүлэх үнэ

$r_f$ -эрсдэлгүй активын хүү

T-опционы эцсийн хугацаа

**778. Pyramiding - Пирамиджуулах**

Нэг толгой компани нь нөгөө толгой компанийнхаа хяналтыг авах зэргээр ашиг/алдагдлаа улам ихэсгэдэг толгой компаниудын хэлцэл.

**779. Quarterly compounding - Улирлаар нийлмэл хүү тооцох**

Нэг жилийн дотор 4 үеийн хүүг нийлүүлж тооцох.

**780. Queue management - Дарааллын удирдлага**

Төлбөрийн даалгавруудыг боловсруулах дарааллыг тогтоох журам. Тухайлбал, FIFO буюу, эхэлж ирсэн нь эхэлж гарах дараалал.

**781. Quick (acid-test) ratio - Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа**

Компанийн эргэлтийн хөрөнгөөс бараа материалыг хасч эргэлтийн эх үүсвэрт нь харьцуулж тооцдог хөрвөх чадварын хэмжүүр.

**782. Quotations - Үнэт цаасны үнийн мэдээ**

Бонд, хувьцаа болон бусад үнэт цаасны өнөөгийн ба өнгөрсөн үеийн үнийн статистик мэдээ.

**783. Random walk - Санамсаргүй алхаа**

Хувьцааны үнийн өөрчлөлт нь санамсаргүй бөгөөд урьдчилан таамаглахын аргагүй гэсэн санаа.

**784. Range - Хэлбэлзлийн хүрээ**

Сайн үр дүнгээс муу үр дүнг хасах замаар активын эрсдэлийг олох хэмжүүр.

**779. Quarterly compounding - Улирлаар нийлмэл хүү тооцох**

Нэг жилийн дотор 4 үеийн хүүг нийлүүлж тооцох.

**780. Queue management - Дарааллын удирдлага**

Төлбөрийн даалгавруудыг боловсруулах дарааллыг тогтоох журам. Тухайлбал, FIFO буюу, эхэлж ирсэн нь эхэлж гарах дараалал.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

Q

r

s

t

u

v

w

x

y

z

**781. Quick (acid-test) ratio - Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа**

Компанийн эргэлтийн хөрөнгөөс бараа материалыг хасч эргэлтийн эх үүсвэрт нь харьцуулж тооцдог хөрвөх чадварын хэмжүүр.

**782. Quotations - Үнэт цаасны үнийн мэдээ**

Бонд, хувьцаа болон бусад үнэт цаасны өнөөгийн ба өнгөрсөн үеийн үнийн статистик мэдээ.

**783. Random walk - Санамсаргүй алхаа**

Хувьцааны үнийн өөрчлөлт нь санамсаргүй бөгөөд урьдчилан таамаглахын аргагүй гэсэн санаа.

**784. Range - Хэлбэлзлийн хүрээ**

Сайн үр дүнгээс муу үр дүнг хасах замаар активын эрсдэлийг олох хэмжүүр.

**785. Ranking approach - Эрэмбэлэх арга**

Хөрөнгө зарцуулалтын төслүүдийг өгөөжийн хувь зэрэг урьдчилан тодорхойлсон хэмжүүрээр эрэмбэлэх аргачлал.

**786. Rate anticapition swap - Хүү таамаглалын своп**

Хүүгийн өөрчлөлтийг таамаглах үндсэн дээр нэг бондыг нөгөөгөөр солих үйл явц.

**787. Ratio analisys - Харьцааны шинжилгээ**

Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, статусыг тодорхойлохын тулд хийдэг санхүүгийн харьцааг тооцох, тайлбарлах арга.

**788. Ratio of exchange - Солилцооны ханш**

Эзэмшигч компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнэд ногдох зорилтот компанийн нэгж хувьцаанд төлсөн үнийн харьцаа.

**789. Ratio of exchange in market price - Зах зээлийн солилцооны ханш**

Эзэмшигч компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнэд ногдох зорилтот компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнийн харьцаа.

**790. Raw materials inventory – Түүхий эд материалын нөөц**

Бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийн тулд компанийн худалдаж авсан зүйлс.

**791. Raw return – Түүхий өгөөж**

Эрсдэлээр зохицуулалт хийгээгүй, аливаа нэгэн жишигтэй харьцуулалт хийгээгүй хөрөнгө оруулалтын нийт өгөөжийн хувь.

**792. Real assets – Бодит актив**

Бараа үйлчилгээг бүтээхэд ашигладаг актив.

**793. Real estate investment trust – Үл хөдлөх хөрөнгийн итгэмжлэгдсэн хөрөнгө оруулалт**

Үл хөдлөх хөрөнгө буюу үл хөдлөх хөрөнгөөр барьцаалагдсан зээлд хөрөнгө оруулдаг зуучлагч.

**794. Real rate of interest – Бодит хүү**

Инфляцигүй, зах зээлийн нийлүүлэгч ба хэрэглэгчид нь хөрвөх чадварыг давууд үзэх хандлагагүй, бүх үр дагавар нь тодорхой гэх мэт төгс орчинд, хуримтлалын нийлүүлэлт ба хөрөнгө оруулалтын эрэлтийн хоорондын ерөнхий тэнцвэрээр тогтсон хүү.

**795. Real-time gross settlement (RTGS) system – Бодит цагийн нийт тооцооны систем**

Боловсруулалт болон тооцоо нь гүйлгээ бүрээр бодит цагт хийгддэг төлбөр тооцооны систем.

**796. Rebalancing – Дахин тэнцвэржүүлэх**

Тогтмол орлоготой үнэт цаасны багцын бүрэлдэхүүн дэх активаа шинэчлэх замаар үргэлжлэх хугацааг нь тэнцвэржүүлэх.

**797. Recapitalization – Дахин хөрөнгөжүүлэлт**

Дампуурсан компанийн өрийг хувьцаагаар солих буюу өрийн хугацааг сунгах замаар хийгддэг дахин зохион байгуулалтын арга хэмжээ.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

R

s

t

u

v

w

x

y

z

**798. Recaptured depreciation - Шинэчлэн тогтоосон элэгдэл**

Хөрөнгийн анхны худалдан авсан үнээс доогуур, бүртгэлийн өртгөөс дээгүүр тогтоогдсон хөрөнгийг зарах үнийн хэсэг.

**799. Reconciliation - Тооцоо нийлэлт**

Гүйлгээнд оролцогч хоёр өөр талаас тус бүрийн бүртгэл нийлж байгааг шалгах үйл явц.

**800. Recovery period - Элэгдэл байгуулагдах хугацаа**

MACRS-аргаар тооцогдсон тодорхой хөрөнгийн элэгдэл байгуулах хугацаа.

**801. Red herring - Улаан тодорхойлолт**

Гаргаж байгаа үнэт цаасны урьдчилсан шинж төрхийг товч тодорхойлж проспектуст улаан өнгөөр бичсэн мэдэгдэл.

**802. Red-line method - Улаан шугамын арга**

Агуулахын нөөц багасч “улаан шугам-д ойртмогц нөөцийг захиалгыг өгөх замаар бараа материалын нөөцийг шаардлагатай хэмжээнд барьж байдаг энгийн арга.

**803. Refund - Нөхөн төлөлт**

Шууд хасалтын үед төлбөр төлөгчийн данснаас хасалт хийж авсан хөрөнгийг буцааж хийхийг төлбөр хариуцагчаас шаардах (тодорхой шалтгаантай болон шалтгаан заалгүйгээр).

**804. Refusal - Татгалзалт**

Шууд хасалтын тооцоо хийхийн өмнө төлбөр төлөгч өөрийн банкиндаа шууд хасалт хийж болохгүйг мэдэгдэх заавар.

**805. Registered trader - Бүртгэгдсэн дилер**

Өөрийн нэрийн өмнөөс арилжаанд оролцогч хөрөнгийн биржид бүртгэгдсэн гишүүн дилер.

**806. Registration - Бүртгэл**

Үнэт цаас гаргагч дээр, бүртгэгч дээр, эсвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дээр үнэт цаасны өмчлөх эрхийг баримтжуулах.

**807. Registry (registrar) – Бүртгэгч**

Үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс үнэт цаасны өмчлөлийн бичилт, бүртгэлийг хийдэг байгууллага.

**808. Regular dividend policy – Тогтмол ногдол ашиг олгох бодлого**

Хугацааны эцэс бүрт, тогтоосон хэмжээний мөнгөн дүнгээр ногдол ашиг хуваарилах бодлого.

**809. Regulation – Зохицуулалт**

Шударга ил тод үр ашигтай зах зээлийг бүрдүүлэх хөрөнгө оруулагчийг хамгаалах зорилгоор засгийн газраас явуулдаг үйл ажиллагаа.

**810. Reject – Буцаалт**

Төлбөрийн тооцоо хийгдэхээс өмнө нэг бол төлбөр төлөгчийн эсвэл төлбөр хүлээн авагчийн банкнаас төлбөрийн гүйлгээний хэвийн гүйцэтгэлийг цуцлах тохиолдол.

**811. Relative strength – Харьцангуй хүч**

Тодорхой хувьцаа буюу тодорхой салбарын хувьцааны үнийн зах зээлийн ерөнхий индекстэй харьцуулсан харьцаа.

**812. Relevant cash flows – Хамааралтай мөнгөн урсгалууд**

Нэмэгдэж гарах татварын дараах мөнгөн зарлага (хөрөнгө оруулалт) ба санал болгосон хөрөнгийн зарцуулалтанд хамаарах мөнгөн орлого.

**813. Remote payment – Зайны төлбөр**

Төлбөр төлөгч болон төлбөр хүлээн авагч нар биеэр уулзалгүйгээр зайнаас хийсэн төлбөр.

**814. Renewal options – Сунгуулах сонголт**

Үйл ажиллагааны түрээсийн хугацаа дуусмагц, түрээслэгчид олгогддог түрээсийн гэрээгээ сунгуулах эрх.

**815. Reorder point – Дахин захиалга хийх цэг**

Бараа материалаа дахин захиалах цэг. Захиалга өгөөд бараа материала хүлээн авах хүртэл өдрийн тоо ба өдрийн хэрэглээний үржвэр.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

R

s

t

u

v

w

x

y

z



**816. Replacement cost – Орлуулалтын зардал**

Компанийн активыг сольж орлуулах зардал.

**817. Repurchase agreement – Буцаан худалдаж авах гэрээ (Репо)**

Тодорхой үнэт цаасыг банк буюу дилерээс тогтоосон үнээр буцааж авах нөхцөлтэйгөөр зарах гэрээ.

**818. Required return – Шаардагдах өгөөж**

Хувьцаагаа зарсны үр дүнд учрах зардал. Энэ нь мөнгөн хөрөнгийг нийлүүлэгчийн хүлээж байгаа өгөөжийн түвшин буюу өгөгдсөн эрсдэлийн түвшинтэй харгалзуулан хөрөнгө оруулагчаас үе тутам шаардаж буй тодорхойлогдсон өгөөж.

**819. Required total financing – Нийт санхүүжилтийн хэрэгцээ**

Бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл нь компанид зайлшгүй шаардлагатай нөөц үлдэгдлээс дутсан хэсгийг санхүүжүүлэх эх үүсвэр.

**820. Residual theory of dividends – Ногдол ашгийн үлдэгдлийн онол**

Компаниас боломжтой бүх хөрөнгө оруулалт хийсний дараа үлдэж байгаа хөрөнгө гэдэг утгаар нь ногдол ашгийг үлдэгдэл хөрөнгө гэж үзэх онол.

**821. Resistance level – Эсэргүүцэх түвшин**

Хувьцааны үнэ буюу хувьцааны зах зээлийн индекс нэмж өсөх магадлал багатай түвшин.

**822. Restrictive covenants – Хориглосон заалт**

Зээлдэгчийн үйл ажиллагаа санхүүгийн хувьд тодорхой хориглолт, хязгаарлалт тавьсан зээлийн гэрээний заалтууд.

**823. Retail funds transfer system – Жижиглэнгийн эх үүсвэрийн шилжүүлгийн систем**

Чек, зээлийн карт, төлбөрийн карт гэх мэт харьцангуй бага дүнтэй хэдий ч олон тоогоор хийгддэг эх үүсвэр шилжүүлгийн систем.

**824. Retained earnings – Хуримтлагдсан ашиг**

Ногдол ашиг болгож хуваарилаагүй орлого. Дотоод санхүүжилтийн хэлбэр.

**825. Return – Өгөөж**

Хөрөнгө оруулалтыг эзэмшигчийн нэрийн өмнөөс тодорхой хугацааны туршид олсон нийт ашиг буюу алдагдал. Хугацааны эцэст ба эхэнд тооцсон активын үнэлгээний зөрүүн дээр хугацааны турш олсон бэлэн мөнгөний орлогыг нэмж хугацааны эхэн дэх активын үнэд харьцуулж тооцно.

**826. Return of Capital – Хөрөнгийн буцаалт**

Хувьцааны нэрлэсэн үнэ өөрчлөгдөхөд хөрөнгө оруулагчид төлөгдөх мөнгөн дүн.

**827. Return on equity (ROE) – Өөрийн хөрөнгийн өгөөж**

Энгийн ба давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдээс компанид оруулсан хөрөнгийн өгөөж.

**828. Return on total assets (ROA) – Нийт активын өгөөж**

Өөрийн актив хөрөнгөөрөө ашиг олох чадвар буюу удирдлагын ерөнхий үр ашгийг хэмжинэ. Үүнийг заримдаа хөрөнгө оруулалтын өгөөж гэж нэрлэх нь бий.

**829. Reversal effect – Эргэх нөлөө**

Нэг үед өгөөж муутай буюу өгөөж сайтай байсан хувьцаа дараагийн үедээ эсрэгээр өөрчлөгдөх хандлага.

**830. Reverse stock split – Хувьцааны нийлүүлэлт (эсрэг сплит)**

Тодорхой тооны хувьцааг нэг шинэ хувьцаагаар солих хэлбэрээр компанийн хувьцааны зах зээлийн үнийг өсгөдөг арга.

**831. Revolving credit agreement – Эргэлтийн зээлийн шугам**

Өөрийн эх үүсвэрийн боломжоос үл хамааран тодорхой хугацааны турш банкнаас компанид олгодог баталгаат зээлийн шугам.

**832. Reward-to-variability ratio – Шагнал ба хэлбэлзлийн харьцаа**

Эрсдэлийн урамшуулал ба стандарт хазайлтын харьцаа.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

**R**

s

t

u

v

w

x

y

z

**833. Rights Auction – Үнэ хаялцах эрх**

Одоо байгаа хувьцаа эзэмшигчдийн дунд шинээр гаргах үнэт цаасыг худалдаж авах эрхийг үнэ хаялцуулан, хэн их үнэ өгсөн хувьцаа эзэмшигчид шинээр гаргасан хувьцааг худалдах эрх.

**834. Rights Issue – Эрх олгох**

Суурь үнэт цаасыг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдэд ижилхэн суурь үнэт цаасыг эсвэл хөрвөх бондыг урьдчилан тогтоосон харьцаагаар бодсон тоо хэмжээгээр болон үнээр захиалах эрхийг олгох.

**835. Risk – Эрсдэл**

Санхүүгийн алдагдал хүлээж болзошгүй байдал буюу өгөгдсөн активуудын өгөөж нь хувьсах чанар бодит үр дүн нь таамаглалаасаа зөрөх магадлал (боломж).

**836. Risk (of technical insolvency) – Эрсдэл (техникийн төлбөрийн чадваргүй байдлын)**

Компаниас өр төлбөрөө хугацаанд нь төлж чадахгүй байх магадлал.

**837. Risk tolerance – Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх**

Хүлээгдэж буй өгөөжөө нэмэгдүүлэхийн тулд илүү эрсдэлийг хүлээхэд бэлэн байх хөрөнгө оруулагчийн хандлага.

**838. Risk-adjusted discount rate (RADR) – Эрсдэлээр зохицуулсан хямдруулалтын хувь**

Компанийн хувьцааны үнийг хадгалах буюу өсгөх зэргээр эзэмшигчдэд учрах зардлыг нөхдөг өгөгдсөн төслийн заавал олох ёстой өгөөжийн хувь.

**839. Risk-averse – Эрсдэлээс зайлсхийгч**

Эрсдэлийг нэмэгдүүлэхийн тулд өгөөжийг өсгөхийг шаардах эрсдэлд хандах хандлага.

**840. Risk-free rate – Эрсдэлгүй өгөөжийн хувь**

АНУ-ын Сангийн үнэт цаас авах зэрэг эрсдэлгүй хөрөнгө оруулалт хийхэд олох өгөөжийн хувь.

**841. Risk-indifferent – Эрсдэлийг үл тооцох**

Эрсдэлийг нэмэгдүүлэхийн тулд өгөөжийг өсгөх шаардлагагүй байх эрсдэлд хандах хандлага.

**842. Risk-return tradeoff – Эрсдэл-өгөөжийн хамаарал**

Эрсдэл илүү хүлээсэн хөрөнгө оруулагч илүү өгөөж авах ёстой гэсэн хүлээлт.

**843. Risk-seeking – Эрсдэлд тэмүүлэх**

Өгөөжийг бууруулсан ч гэсэн илүү эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хандлага.

**844. S corporation (S corp) – Эс Корпораци**

100 буюу түүнээс цөөн тооны хувьцаа эзэмшигчидтэй компани нь нөхөрлөлийн хэлбэрээр татвар төлөх сонголттой байдаг. Хувьцаа эзэмшигчид нь корпорацийн зохион байгуулалтын ач тусыг эдэлж нөхөрлөлийн хэлбэрээр татвар төлснөөрөө татварын хожоо хүртдэг. Гэвч тэтгэврийн төлөвлөгөөнөөс хамааран тодорхой хэмжээний татварын хожоог алддаг.

**845. Safekeeping services – Хадгалалтын үйлчилгээ**

Бусад оролцогчийн өмнөөс биет үнэт цаасыг хадгалах үйл ажиллагаа.

**846. Safety motive – Аюулгүй байдлын зориулалт**

Төлөвлөгдөөгүй, гэнэтийн хэрэгцээг хангах зориулалтаар мөнгөн хөрөнгийг байлгах.

**847. Safety of principal – Үндсэн өрийн аюулгүй байдал**

Үнэт цаас анхны үнээрээ амархан борлогдох тохиолдол.

**848. Safety stocks – Аюулгүйн нэмэлт нөөц**

Захиалга өгөөд бараа материалаа хүлээн авах хүртэл өдрийн тоо ба өдрийн хэрэглээ тооцоолсноос илүү гарсан нөхцөлд шаардагдах нэмэлт нөөц.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

S

t

u

v

w

x

y

z

**849. Sale-leaseback arrangement – Зарж эргэн түрээслэх хэлцэл**

Үндсэн хөрөнгийг боломжит түрээслүүлэгчид зарсны дараа тэрхүү хөрөнгөө эргэж түрээслэх үйл ажиллагаа.

**850. Sales forecast – Борлуулалтын таамаглал**

Гадаад болон дотоод эх сурвалжуудад үндэслэсэн компанийн тодорхой хугацааны борлуулалтын таамаглал. Энэ нь богино хугацааны санхүүгийн төлөвлөлтөд ашигладаг гол үзүүлэлт болдог.

**851. Sarbanes-Oxley Act of 2002 (SOX) – 2002 оны Сарбанес-Окслэйн хууль**

Энэ хууль нь компанийн мэдээллийн хаалттай байдал болон ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг арилгахад чиглэсэн. Компанийн мэдээллийн ил тод байдал, компани хоорондын болон компани ба шинжээч, аудитор, хуульч, захирал, ажилтан, хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцааг зохицуулсан заалтуудтай.

**852. Scenario analysis – Хувилбарын шинжилгээ**

Хэд хэдэн хувьсагчийг нэгэн зэрэг өөрчлөхөд тэр нь компанийн өгөөжид хэрхэн нөлөөлөхийг үнэлдэг зан төлөвийн арга

**853. Scheme of Arrangement – Зохион байгуулалтын тогтолцоо**

Толгой компани өөрийн охин компаниа өөртөө нэгтгэн авч хувьцаа эзэмшигчдийг нь авч үлдэх.

**854. Scrip Dividend – Сонголтот ногдол ашиг**

Хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр эсвэл тогтоосон харьцаагаар шинэ үнэт цаас хүлээж авах сонголт олгоно. Өгөгдмөл сонголт нь голдуу мөнгө байдаг.

**855. Scrip Issue – Тасалбар олгох**

Хувьцаа эзэмшигчдэд үнэгүй нэмэлт хувьцаа (хувьцаа, эрх, баталгаа) өгөхийг хэлэх ба хувьцааны нэрлэсэн үнэд өөрчлөлт орохгүй.

**856. Seasonal need – Улирлын хэрэгцээ**

Эргэлтийн активын түр зуурын хэсгийн санхүүжилтийн хэрэгцээ. Энэ нь жилийн турш хэлбэлздэг.

**857. Seasoned mortgages – Улирлын моргэйж**

30 сараас дээш хугацаатай моргэйж

**858. Secondary market – Хоёрдогч зах зээл**

Өмнө нь гаргасан үнэт цаасыг (шинээр эргэлтэнд гаргаагүй) дахин арилжаалдаг санхүүгийн зах зээл.

**859. Secured creditors – Баталгаат зээлдүүлэгчид**

Компанийн зарим эд хөрөнгийг тусгайлан барьцаанд авсан, тэр эд хөрөнгөний борлуулалтын орлогоос авлагаа барагдуулах эрх бүхий зээлдүүлэгчид.

**860. Secured loan – Баталгаат зээл**

Тодорхой эд хөрөнгийг барьцаа болгож тавьсан зээл.

**861. Secured Short-term financing – Богино хугацаатай барьцаат санхүүжилт**

Тодорхой эд хөрөнгийг барьцаанд тавьж авдаг зээл, санхүүжилт.

**862. Securities characteristic line – Үнэт цаасны онцлогийн шугам**

Үнэт цаасны зах зээлийн индексээс илүүдсэн өгөөж ба эрсдэлгүй үнэт цааснаас илүүдсэн өгөөжөөр илэрхийлэгдэх функц.

**863. Securities exchanges – Үнэт цаасны арилжаа**

Компанид шинээр гаргасан үнэт цаасаа зарж эх үүсвэрээ нэмэгдүүлэх, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасаа дахин борлуулах боломжоор хангадаг тогтолцоо.

**864. Securities settlement system (SSS) – Үнэт цаасны тооцооны систем**

Төлбөргүйгээр болон төлбөртэйгээр үнэт цаасны шилжүүлэг хийдэг систем.

**865. Securitization – Үнэт цаасжуулах**

Зээлүүдийг багцлан сан бүрдүүлж, тэр сангаар баталгаажсан арилжааны стандарт үнэт цаас бий болгох үйл явц.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

S

t

u

v

w

x

y

z

**866. Security agreement – Барьцааны гэрээ**

Зээл авахын тулд тавьсан барьцааны талаар байгуулсан зээлдэгч, зээлдүүлэгчийн хоорондын гэрээ.

**867. Security analysis – Үнэт цаасны шинжилгээ**

Үнэт цаасны үнэлэмжийн (үнэ цэнийн) шинжилгээ.

**868. Security market line (SML) – Үнэт цаасны зах зээлийн шугам**

Хөрөнгө активын үнэлгээний загварын график илэрхийлэл буюу тархаах боломжгүй эрсдэлийн (бета) түвшин бүрт харгалзах шаардлагатай өгөөжийн хэмжээ.

**869. Security selection – Үнэт цаасны сонголт**

Активын ангилал тус бүрийн дотор тодорхой үнэт цаасыг сонгох үйл явц.

**870. Segregation – Тусгаарлалт**

Хадгаламжийн байгууллагын хөрөнгөөс (эсвэл бусад харилцагчийн хөрөнгөөс) харилцагчийн хөрөнгийг тусгаарлан хамгаалах арга.

**871. Selling group – Борлуулалтын бүлэг**

Гаргасан үнэт цаасны тодорхой хэсгийг худалдан авахыг зөвшөөрсөн брокерийн пүүсийн бүлэг. Энэ бүлэг нь үнэт цаасыг авах ба зарах үнийн зөрүүгээр ашиг олно.

**872. Semiannual compounding – Хагас жилээр нийлмэл хүү тооцох**

Нэг жилийн дотор 2 үеийн хүүг нийлүүлж тооцох.

**873. Sensitivity analysis – Мэдрэмжийн шинжилгээ**

Өгөгдсөн хувьсагчид боломжит янз бүрийн утга өгөхөд компанийн өгөөж хэрхэн мэдэрч өөрчлөгдөхийг үнэлдэг зан төлөвийн арга.

**874. Sensivity analisys – Мэдрэмжийн шинжилгээ**

Олон тооны боломжит өгөөжийн тооцоог ашиглах замаар өгөөжийн хэлбэлзлийг судалж эрсдэлийг үнэлдэг зан төлөвийн шинжилгээний арга.

### **875. Separation property – Салангид чанар**

Багцын сонголт нь:

- (1) Эрсдэлтэй активын оновчтой багцыг тодорхойлох цэвэр техникийн асуудал;
- (2) Эрсдэлтэй активуудыг эрсдэлгүй активтай хамгийн сайн хольцыг сонгох хувь хүний сонголт гэсэн бие даасан 2 зорилтоос бүрдэх чанар.

### **876. Serial bonds – Цуврал бонд**

Төлбөрийн тодорхой хэсэг нь жил бүр эргэн төлөгдөж байдаг бонд.

### **877. Settlement – Тооцоо**

Оролцогчдын өглөг, авлагыг барагдуулах зорилгоор эх үүсвэр ба үнэт цаасны шилжүүлгийн системээр дамжуулан боловсруулж гүйлгээ хийх үйл ажиллагаа. Тооцоо нь эцсийн болон нөхцөлтэй байж болно.

### **878. Settlement cycle (settlement interval) – Тооцооны мөчлөг**

Үнэт цаасны шилжүүлгийн тохиолдолд арилжаа хийгдсэнээс тооцоо хийгдэх хүртэл хугацаа.

### **879. Settlement risk – Тооцооны эрсдэл**

Шилжүүлгийн системд тооцоо нь хүлээгдэж байсны дагуу явагдахгүй, аль нэг буюу хэд хэдэн тал төлбөрөө хийхгүй байх эрсдэл. Ийм эрсдэлд үйл ажиллагааны эрсдэл, зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл ордог.

### **880. Shark repellents – Аварга загасны жигшүүр**

Нэгдэлтийн үр дүнд удирдлагын хяналтыг шилжүүлэхийг хязгаарласан компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт.

### **881. Sharpe measure – Шарпын хэмжүүр**

Урамшуулал ба хэлбэлзлийн харьцаа. Багцын илүүдэл өгөөжийг стандарт хазайлтад харьцуулсан харьцаа.

### **882. Shelf registration – Тавиурын бүртгэл**

150 сая доллараас илүү дүнтэй хувьцаа бүхий компанид 2 жилийн хугацаатай “бүртгэлийн мастер мэдэгдэл” тавьж мэдэгдэл нь батлагдмагц үнэт цаасыг арилжаалах эрх олгодог. Үнэт цаасны арилжааны комиссын журам.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

S

t

u

v

w

x

y

z



**883. Short interest - Богино заралт**

Зээл авч зах зээл дээр зарсан нийт хувьцааны тоо.

**884. Short position - Богино позиц**

Активыг хүргүүлж өгөх үүрэгтэй ирээдүйн хэлцэлд оролцогч тал.

**885. Short sale - Дутуудалтай заралт**

Хувьцааг брокероос зээлээр худалдан авч зараад буцааж худалдан авч зээлээ төлөх үйл явц буюу хувьцааны үнийн бууралтаас ашиг олох үйл явц.

**886. Short-term (operating) financial plans - Богино хугацааны (үйл ажиллагааны) санхүүгийн төлөвлөгөө**

Богино хугацаанд төлөвлөгдсөн санхүүгийн үйл ажиллагаа ба тэрхүү үйл ажиллагааны санхүүгийн үр дагавар.

**887. Short-Term financial management - Богино хугацаатай санхүүгийн удирдлага**

Эргэлтийн актив, эргэлтийн пассивын удирдлага.

**888. Short-Term, self-liquidating loan - Богино хугацаатай өөрөө төлөгдөх зээл**

Олгосон зориулалтын дагуу авлага, бараа материалын төлбөр орж ирмэгц өөрөө төлөгдөж байдаг барьцаагүй зээл.

**889. SIC codes - Салбарын стандарт ангиллын код**

Компанийг салбарын бүлгээр нь ангилан харуулдаг тоон код.

**890. Signal - Шинж тэмдэг**

Компанийн удирдлагаас санхүүжилтийн хэлбэрээрээ дамжуулан хувьцааны үнэлгээнд нөлөөлөх шинж. Зээллэг бол хувьцааны үнэлгээ нь доогуур тогтоогдсон гэдэг утгаараа эерэг шинж тэмдэг, шинээр хувьцаа гаргах нь хувьцааны үнэлгээ нь дээгүүр тогтоогдсоныг илтгэх сөрөг шинж тэмдэг.

**891. Simulation – Симуляци**

Урьдчилан тогтоосон магадлалын тархаалт, санамсаргүй тоог ашиглан эрсдэлийг мэдрүүлэх зорилго бүхий хөрөнгийн төсөвлөлтийн статистикт суурилсан зан төлөвийн арга.

**892. Single-payment note – Нэг удаагийн төлбөрт зээл**

Хугацааны эцэст төлбөрийг нь нэг мөсөн хийдэг богино хугацаатай зээл.

**893. Sinking-fund requirement – Хорогдуулалтын сангийн шаардлага**

Бондын хугацаа дуусахаас өмнө өрийг системчлэн төлж хорогдуулахыг заасан бонд гаргалтын нөхцөл.

**894. Small (ordinary) stock dividend – Ердийн бага хэмжээний хувьцаагаар олгох ногдол ашиг**

Ногдол ашиг зарлагдмагц нийт ердийн хувьцааны үлдэгдлийн 20-25 хувиас ихгүй хэмжээтэй хувьцаагаар олгогдох ногдол ашиг.

**895. Small-firm effect – Жижиг компанийн нөлөө**

Жижиг компаниудын хувьцаа нь нэгдүгээр сард хэвийн бус өгөөжтэй байх тохиолдол.

**896. Sole proprietorship – Хувийн компани**

Нэг хүний эзэмшилд байдаг бөгөөд тухайн хүн нь ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулдаг бизнесийн нэгж.

**897. Specialist – Үнэт цаасны мэргэжилтэн**

Нэг ба хэд хэдэн компанийн хувьцаагаар мэргэжсэн, өөрийн арилжааны оролцоогоороо зах зээлийн замбараатай байдлыг хадгалах үүрэг бүхий үнэт цаасны худалдаачин.

**898. Specialized sector funds – Салбараар төрөлжсөн сан**

Салбаруудын үнэт цаасанд төрөлжиж хөрөнгө оруулдаг хамтын сангийн хэлбэр.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

S

t

u

v

w

x

y

z

**899. Speculative grade or junk bond – Зэрэглэл муутай буюу жанк бонд**

Стандарт энд Пүүрз ВВ, Мүүдийз Ва ба түүнээс доогуур зэрэглэлтэй бонд.

**900. Speculative motive – Аз туршилтын зориулалт**

Түргэн борлогдох үнэт цаасанд байршуулж орлого олох зориулалтаар мөнгөн хөрөнгийн байлгах.

**901. Spin-off – Компани болж салах**

Үйл ажиллагааны нэгж нь толгой компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд хувь тэнцүүлсэн байдлаар хувьцаа гаргаж бие даасан компани болж салах хэсэгчилсэн худалдааны хэлбэр.

**902. Spontaneous financing – Аяндаа үүсэх санхүүжилт**

Компанийн ердийн үйл ажиллагааны явцад аяндаа үүсэх санхүүжилт. Энэхүү санхүүжилтийн гол эх үүсвэрүүд нь өглөг (дансны өр), хуримтлагдсан өр болно.

**903. Spot-futures parity theorem – Одоогийн ба ирээдүйн үнийн тэнцвэрийн теорем**

Одоогийн ба ирээдүйн үнэ хоорондын тэнцвэрийн талаархи онолын зөв харилцаа. Тэнцвэрт харилцаанаас гажих нь арбитражийн боломжийг бий болгоно.

**904. Spread – Зөрүү**

Үнэт цаасыг ХОБ-наас худалдаж авдаг үнэ зардаг хоорондын зөрүү.

**905. Spread (futures) – Зөрүүтэй ирээдүйн хэлцэл**

Адил барааны ирээдүйн хэлцэл дээр нэг хугацаатай урт позиц, өөр хугацаатай богино позиц авах үйлдэл.

**906. Spread (option) – Зөрүүтэй опцион**

Хэрэгжүүлэх үнэ ба эцсийн хугацаа нь зөрүүтэй адил активын хоёр ба түүнээс дээш тооны авах эсвэл зарах опционы хослол.

**907. Standard debt provisions – Зээлийн стандарт нөхцөл**

Зээлийн гэрээнд тусгадаг зээлдэгчийн бүртгэл, тайлагнал, татвар төлөлт, бизнесийн үйл ажиллагааны талаар тавих шалгуур үзүүлэлт. Тэгэхдээ санхүүгийн хувьд эрүүл бизнест өндөр шаардлага тавьдаггүй.

**908. Standard deviation (SD) – Стандарт хэлбэлзэл**

Хүлээгдэж буй өгөөжийн ойролцоох тархалтыг хэмждэг активын эрсдэлийн хамгийн түгээмэл статистик үзүүлэлт.

**909. Standby arrangement – Стэнд-бай хэлцэл**

Захиалга нь ирээгүй буюу нийтэд зарагдаагүй хувьцаа бүрийг ХОБ-наас худалдаж авахыг амласан баталгаа.

**910. Standing order – Байнгын төлбөрийн даалгавар**

Тодорхой харилцагчийн нэр дээр тогтмол дүнтэй төлбөрийг байнга хийж байхыг банкинд өгсөн харилцагчийн даалгавар.

**911. Statement of cash flows – Мөнгөн урсгалын тайлан**

Компанийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт санхүүжилтийн мөнгөн урсгал, түүнд гарсан тайлант хугацааны мөнгөн хөрөнгө, түргэн борлогдох үнэт цаасны өөрчлөлтийг тусгасан тайлан.

**912. Statement of retained earnings – Хуримтлагдсан ашгийн тайлан**

Хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэл, жилийн дундуурх тохируулга ба эцсийн үлдэгдлийг үзүүлсэн нягтлан бодох бүртгэлийн тайлан.

**913. Statement of stockholders' equity – Хувьцаа эзэмшигчдийн өмчийн тайлан**

Жилийн тайланд хувьцаа эзэмшигчдийн өмчийг бүрэлдэхүүн хэсэг бүрээр нь тайлбарлан харуулдаг тайлан.

**914. Stock dividend – Хувьцаагаар олгох ногдол ашиг**

Хувьцаа хэлбэрээр эзэмшигчдэд хуваарилдаг ногдол ашиг.

**915. Stock exchanges – Хөрөнгийн бирж**

Өмнө нь гаргасан үнэт цаасыг суудалтай гишүүд нь дахин арилжаалдаг зах зээл.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

S

t

u

v

w

x

y

z

**916. Stock options – Хувьцааны сонголт**

Компанийн удирдлагад олгодог, хувьцааг тогтоосон үнээр тогтоосон хугацааны эцэст худалдан авах эрх.

**917. Stock purchase plans – Хувьцаа худалдаж авах төлөвлөгөө**

Компанийн ажилтнуудад олгодог, хувьцааг хөнгөлөлттэй үнээр худалдан авахыг зөвшөөрсөн төлөвлөгөө.

**918. Stock purchase warrant – Хувьцаа авах баталгаат эрх**

Тодорхой хугацааны дараа тогтоосон үнээр тодорхой тооны энгийн хувьцааг худалдаж авах эрх.

**919. Stock purchase warrants – Хувьцаа худалдаж авах баталгаа**

Баталгааг эзэмшигчийн хувьд компанийн хувьцааг тодорхой хугацааны эцэст тодорхой үнээр худалдаж авах эрх.

**920. Stock repurchase – Хувьцааны буцаан худалдан авалт**

Зах зээл дээрээс гаргасан хувьцаагаа буцаан худалдаж авах компанийн үйл ажиллагаа. Зорилго нь хувьцаа эзэмшигчдийн үнэлэмжийг нэмэгдүүлэх буюу дээрэнгүй эзэмшлээс зайлсхийх.

**921. Stock rights – Хувьцааны эрх**

Өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой шууд пропорциональ хамааралтайгаар шинээр нэмэлт хувьцаа худалдаж авах эрх.

**922. Stock selection – Хувьцааны сонголт**

Тухайн улсын хөрөнгийн зах зээл дээрхи тодорхой хувьцааны сонголт.

**923. Stock split – Хувьцааны хуваах (сплит)**

Компанийн хувьцааны зах зээлийн үнийг бууруулж хувьцаа эзэмшигч бүрт ногдох хувьцааны тоог нэмэгдүүлдэг нийтлэг арга.

**924. Stock swap transaction – Хувьцаа солилцох (своп) гүйлгээ**

Урьдчилан тодорхойлсон харьцаагаар эзэмшигч компаниас өөрийнхөө хувьцааг зорилтот компанийн хувьцаагаар солих арилжаа.

**925. Stockholders – Хувьцаа эзэмшигчид**

Энгийн ба давуу эрхтэй хувьцааны эзэмшлээр нотлогдсон компанийн эзэд.

**926. Stockholders' report – Хувьцаа эзэмшигчдийн тайлан**

Нийтийн өмчлөлийн компаниас хувьцаа эзэмшигчиддээ гаргаж өгөх ёстой жилийн тайлан. Энэ тайланд компанийн өнгөрсөн жилийн турш явуулсан санхүүгийн үйл ажиллагааг дүгнэж баримтжуулсан байдаг.

**927. Straddle – Мордох опцион (Страддл)**

Адил хэрэгжүүлэх үнэтэй, адил эцсийн хугацаатай авах ба зарах опционы хослол.

**928. Straight bond – Шулуун бонд**

Хөрвөдөггүй бонд.

**929. Straight bond value – Шулуун бондын үнэ**

Хөрвөх чанар нь ашиглагдахгүйгээр зах зээл дээр зарагдах хөрвөх бондын үнэ.

**930. Straight preferred stock – Шулуун давуу эрхтэй хувьцаа**

Хөрвөдөггүй давуу эрхтэй хувьцаа.

**931. Straight-through processing (STP) – Шууд урсгалтай боловсруулалт**

Баталгаажуулалт, тохируулга, үүсгэлт, клиринг, тооцоо зэрэг төлбөрийн даалгаврын боловсруулалтыг эхнээс нь эцэст хүртэл автоматаар хийх үйл ажиллагаа.

**932. Strategic merger – Стратегийн нэгдэлт**

Өргөжилтийн хэмнэлт гаргах зорилгоор хийгдэх нэгдэлтийн гүйлгээ.

**933. Stress test – Стресс тест**

Эдийн засгийн хямралын үеэр аливаа санхүүгийн байгууллага буюу санхүүгийн хэрэгсэл хэрхэн нөлөөлөгдөх талаар хийгддэг шинжилгээ буюу симуляци.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

S

t

u

v

w

x

y

z

**934. Stretching accounts payable – Тултал нь сунгасан өглөг**

Компанийн зээлийн зэрэглэлд хохирол учруулахгүйгээр өглөгөө аль болохоор хойшлуулж төлөх.

**935. Striking price – Страйк үнэ**

Тогтоосон хугацаанаас өмнө авах буюу зарах үнэ.

**936. Subordinated debentures – Дарааллын бонд**

Түрүүний бондын авлага бүрэн барагдсаны дараа авлагаа барагдуулдаг бонд.

**937. Subordination – Зээлдүүлэгчийн дараалал**

Дараагийн зээлдүүлэгч нар нь эхний зээлдүүлэгчийн авлага бүрэн төлөгдтөл хүлээхийг зөвшөөрсөн урт хугацаатай зээлийн гэрээний заалт.

**938. Subscription Offer – Захиалгын санал**

Одоо байгаа хувьцаа эзэмшигчдэд шинэ хувьцаа эсвэл хөрвөх бондыг санал болгох.

**939. Subscription price – Захиалгын үнэ**

Хувьцааны эрхийг хэрэгжүүлэх тодорхой цаг хугацааны бололцоо өгөхийн тулд зах зээлийн үнээс арай багаар тогтоож өгсөн үнэ.

**940. Subsidiaries – Охин компани**

Толгой компанийн хяналтанд байдаг компани.

**941. Substitution of securities – Үнэт цаасны орлуулалт**

Байгууллагаас тавьсан барьцаагаа буцааж түүнийгээ зах зээлийн үнэлэмж нь адил өөр үнэт цаасаа солих тохиолдол.

**942. Substitution swap – Орлуулах своп**

Нэг бондыг бүтэц нь төстэй боловч илүү ашигтай үнэтэй бондоор солих үйл явц.

**943. Sunk costs – Ууссан зардал**

Урьд нь гарчихсан бөгөөд одоогийн мөнгөн урсгалын шийдвэр гаргалтанд нөлөөлөхгүй болсон мөнгөн зарлага.

**944. Supervoting shares – Супер саналын эрхтэй хувьцаа**

Нэгж хувьцаанд ногдох саналын эрх нь ердийн хувьцаанаас илүү эрхтэй хувьцаа.

**945. Supply shock – Нийлүүлэлтийн цочрол**

Эдийн засаг дахь зардал болон үйлдвэрлэлийн хүчин чадалд нөлөөлөх үйл явдал.

**946. Support level – Дэмжих түвшин**

Хувьцааны үнэ буюу хувьцааны зах зээлийн индекс нэмж буурах магадлал багатай түвшин.

**947. Survivors pay – Аврах төлбөр**

Урьдчилан тогтоосон журмын дагуу нэг оролцогч тооцоогоо хийж чадаагүй нөхцөлд төлбөрийн чадвартай оролцогч түүний алдагдлыг хуваалцах механизм.

**948. Systemic risk – Системийн эрсдэл**

Системийн нэг оролцогч үүргээ хугацаанд нь биелүүлж чадахгүй байдал нь бусад оролцогчийг мөн тийм байдалд хүргэж нийтийг хамарч санхүүгийн системд итгэх итгэлд нөлөөлөх эрсдэл.

**949. Systemically important payment system – Системийн ач холбогдолтой төлбөрийн систем**

Эрсдэлийн хамгаалалтын хангалттай арга хэмжээ авахгүй бол системийн хэмжээний эрсдэлд орж болзошгүй төлбөрийн систем.

**950. Takeover – Эзэмших**

Энэ нь нэг компани нөгөөгөө нэгдүүлэх аргуудын нэг бөгөөд нэг компани нөгөөгөө саналын эрхтэй хувьцааны дийлэнхийг авах замаар нэгдүүлэх.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

T

u

v

w

x

y

z



**951. Takeover defenses – Эзэмшлээс хамгаалалт**

Дээрэнгүй эзэмшлээс хамгаалах стратегиуд.

**952. Target capital structure – Капиталын зорилтот бүтэц**

Компанийн хувьцааны ба өрийн санхүүжилтын зорилтот хольц.

**953. Target company – Зорилтот компани**

Нэгдэлтийн гүйлгээний үед эзэмшигч компанийн өөртөө нэгтгэхээр зорьж буй компани.

**954. Target dividend–payout ratio – Ногдол ашгийн хуваарилалтын зорилтот харьцаа**

Компаниас ногдол ашгийнхаа тодорхой хувиар тооцсон мөнгөн дүнгээр урьдчилж хуваарилаад ашгийн өсөлт нь хангагдмагц ногдол ашгийн зорилтот харьцаанд нийцүүлэн зохицуулалт хийх бодлого.

**955. Target weights – Зорилтот жин**

Капиталын зорилтот бүтцэд тулгуурласан бүртгэлийн буюу зах зээлийн үнэлгээний жин.

**956. Tax loss carryback/carryforward – Татварын алдагдлыг хойшоо/урагшаа шилжүүлэх**

Үйл ажиллагаа нь алдагдалтай байгаа компанид олгодог татварын өрөө 3 жил хүртэлх хугацаагаар хойш нь 15 жил хүртэлх хугацаагаар урагш нь шилжүүлэх эрх.

**957. Tax loss carry-forward – Татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх**

Нэгдэлтийн үед аль нэг компанийн татварын алдагдлыг нэгдсэн компанийн ирээдүйн орлогын тодорхой хязгаарт ногдуулан тооцдог арга.

**958. Tax on sale of old asset – Хуучин хөрөнгийн борлуулалтын татвар**

Хуучин хөрөнгийг зарсан үнэ, анхны худалдаж авсан үнэ, бүртгэлийн өртгийн харьцаанаас хамаарсан татвар.

**959. Tax swap – Татварын своп**

Татварын хөнгөлөлт эдлэх зорилгоор нэг бондыг төстэй бүтэцтэй нөгөө бондоор солих үйл явц.

**960. Technical analysis – Техникийн шинжилгээ**

Хувьцааны үнийн өөрчлөлтийн дахин давтагдах ба урьдчилан таамаглагдах зах төлөв, зах зээлийн авах зарах дарамтын судалгаа.

**961. Technical insolvency – Техникийн хувьд төлбөрийн чадваргүй болох**

Компани өр төлбөрөө хугацаанд төлж чадахгүйгээс үүсэх бизнесийн уналт.

**962. Technically insolvent – Техникийн хувьд төлбөрийн чадваргүй болсон**

Компаниас өр төлбөрөө хугацаанд нь төлж чадахгүй болсон.

**963. Tender offer – Тендер санал**

Компанийн тодорхой тооны хувьцааг тодорхой үнээр худалдаж авах санал.

**964. Term (long-term) loan – Урт хугацаатай зээл**

Санхүүгийн байгууллагуудаас бизнест олгосон 1 жилээс дээш анхны хугацаатай зээл.

**965. Term structure of interest rates – Хүүгийн хугацааны бүтэц**

Хүүгийн хувь буюу өгөөжийн хувийн төлөгдөх эцсийн хугацаатай холбогдох хамаарал.

**966. Terminal cash flow – Эцсийн мөнгөн урсгал**

Төслийн эцсийн жил орж ирэх татварын дараах, үйл ажиллагааны бус (гол төлөв төслийг татан буулгахтай холбогдсон) мөнгөн орлого.

**967. Third market – Гуравдагч зах зээл**

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааг лангууны арын зах дээр арилжих үйл явц

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

T

u

v

w

x

y

z

**968. Time line - Хугацааны шугам**

Хамгийн зүүн талын цэг нь хугацааны 0 агшин буюу өнөөгийн цагийг илэрхийлж, баруун тийш шилжих тутам ирээдүйн үеүдийг харуулах хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалыг дүрслэхэд ашигладаг хэвтээ шугам.

**969. Time value of option - Опционы цаг хугацааны үнэлэмж (үнэ цэнэ)**

Опционы үнэ ба хугацааг нь шууд дуусгасан опционыг хэрэгжүүлсний үнэлэмжийн (үнэ цэнийн) зөрүү.

**970. Times interest earned ratio - Хүү төлөх чадварын харьцаа**

Компаниас хүүгээ хугацаанд нь төлөх чадварын хэмжүүр.

**971. Time-series analysis - Цаг хугацааны харьцуулсан шинжилгээ**

Санхүүгийн харьцааны шинжилгээг ашиглаад компанийн санхүүгийн үйл ажиллагаа хугацааны турш хэрхэн өөрчлөгдөж буйг үнэлдэг арга.

**972. Tobin's q - Тобины кю**

Компанийн зах зээлийн үнэлэмжийг (үнэ цэнийг) орлуулалтын зардалд харьцуулсан харьцаа.

**973. Total asset turnover - Нийт активын эргэлт**

Компани хөрөнгөө хир зэрэг үр дүнтэй ашиглан борлуулалтыг бий болгож байгааг харуулдаг.

**974. Total costs - Нийт зардал**

Бараа материалын захиалгын ба хадгалалтын зардлын нийлбэр.

**975. Total leverage - Нийт хөшүүрэг**

Санхүүгийн ба үйл ажиллагааны тогтмол зардлыг ашиглан компанийн борлуулалтын өөрчлөлтийн нэгж хувьцааны орлогод (EPS) үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх үйл явц.

**976. Total risk - Нийт эрсдэл**

Үнэт цаасны тархаах боломжгүй ба тархаах боломжтой эрсдэлийн хослол.

**977. Trading through – Ханшны арилжаа**

Хэдийгээр харилцагчаас илүү ашигтай үнэ өгсөн ч дилерээс өөрийн тогтоосон авах зарах ханшаараа хийдэг арилжаа.

**978. Transaction reference number (TRN) – Гүйлгээний лавлах дугаар**

Төлбөр тооцоо, үнэт цаасны тооцоонд хэрэглэгддэг гүйлгээний дугаар (SWIFT төлбөрийн мэдээлэл, зээлийн картын зөвшөөрөл).

**979. Transactions motive – Гүйлгээний зориулалт**

Түүхий эд, цалин гэх мэт төлбөр тооцооны зориулалтаар мөнгөн хөрөнгийг байлгах.

**980. Transfer order – Шилжүүлгийн даалгавар**

Өр төлөгчөөс төлбөр хүлээн авагчид актив хөрөнгийг (эх үүсвэр, үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл, бараа гэх мэт) шилжүүлэхийг шаардсан даалгавар буюу мэдээлэл.

**981. Transfer prices – Дотроо шилжүүлэх үнэ**

Үндэстэн дамнасан корпорацийн салбарууд өөр хоорондоо бараа бүтээгдэхүүн нийлүүлэх ба үйлчилгээ үзүүлэхэд тогтоодог үнэ.

**982. Transfer system – Шилжүүлгийн систем**

Мөнгө болон үнэт цаасны шилжүүлгийг бүрдүүлэгч эрх зүй, техник, үйл ажиллагааны тогтолцоо.

**983. Treasurer – Санхүүгийн ерөнхий менежер**

Санхүүгийн төлөвлөлт, эх үүсвэр татах, хөрөнгийн зардлын шийдвэр гаргах, мөнгөн хөрөнгө, зээл, тэтгэврийн сан, гадаад валютын гүйлгээг удирдах үүрэг бүхий компанийн санхүүгийн ерөнхий менежер.

**984. Treasury bills – Сангийн үнэт цаас**

АНУ-ын сангийн яамнаас гаргадаг 1 жил хүртэлх янз бүрийн хугацаатай, эрсдэлгүй үнэт цаас.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

T

u

v

w

x

y

z

**985. Treasury notes and bonds - Сангийн бонд**

АНУ-ын сангийн яамнаас гаргадаг 1-ээс дээш жилийн хугацаатай, хагас жил тутам хүү нь төлөгддөг, эрсдэлгүй үнэт цаас.

**986. Treasury stock - Компанийн мэдлийн (халаасны) хувьцаа**

Гаргасан хувьцаагаа компанийн мэдэлд буцаан худалдаж авсан хувьцааны тоо хэмжээ. Тэнцэл дээр үүнийг хувьцаа эзэмшигчдийн хөрөнгөөс хасч тооцдог.

**987. Treynor measure - Трэйнорын хэмжүүр**

Багцын илүүдэл өгөөжийг бетад харьцуулсан харьцаа.

**988. Treynor-Black model - Трэйноор-Блакийн загвар**

Үр ашигтай зах зээлд ойролцоо утгаар үнэт цаасны шинжилгээг ашигладаг багцын менежерүүдийн оновчтой загвар.

**989. Triple-witching hour - Гурвалсан шуламын цаг**

S&P500 ирээдүйн хэлцлийн хугацаа, S&P100 индексийн опцион хэлцлийн хугацаа ба аливаа нэг хувьцааны опцион хэлцлийн хугацаа нэгэн зэрэг дуусдаг жилд дөрвөн удаа тохиолдох үе.

**990. Trough - Гүдгэр**

Эдийн засгийн уналт ба сэргэлтийн хооронд орших шилжилтийн цэгүүд.

**991. Truncation - Орлуулалт**

Цаасан дээр хийгддэг шилжүүлгийн даалгаврыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь цахим хэлбэрт оруулж цаашид боловсруулах зорилгоор орлуулах хувиргалт.

**992. Trust receipt inventory loan - Бараа материал барьцаалсан зээл**

Зээлдэгчийн харьцангуй өндөр үнэтэй бараа материалыг барьцаалан түүнийг үйлдвэрлэсэн зардлын 80-100 хувьд нь зээл олгож, бараа материал нь зарагдмагц зээлдүүлэгчид үндсэн өрөө, хуримтлагдсан хүүгийн хамт шууд төлнө.

**993. Trustee - Итгэмжлэгдсэн төлөөлөгч**

Бонд гаргагчаас бонд эзэмшигчийн өмнө хүлээх гэрээний үүргийн биелэлтэнд хяналт тавих эрх бүхий бонд гаргалтын нөхцөлийн гуравдагч этгээдийн үйл ажиллагааг хөлсөөр эрхлэгч хувь хүн, компани, эсвэл банкны итгэмжлэлийн газар.

**994. Two-tier offer - Хоёр шатлалт санал**

Хувьцааны арилжааны өмнөх саналаас илүү тааламжтай нөхцөлтэйгөөр гаргасан тендерийн санал.

**995. Uncorrelated - Хамааралгүй (Корреляцигүй)**

Корреляцын зэрэг нь 0 тэй тэнцүү буюу 2 төрлийн хувьсагчийн хооронд аливаа хамааралгүй байх тохиолдол.

**996. Underlying asset - Суурилагдсан актив**

Үүсмэл гэрээ суурилагддаг актив (санхүүгийн хэрэгсэл, үнэт цаас).

**997. Underpriced - Доогуур үнэлэгдэх**

Үнэт цаасыг зах зээлийн үнээс нь доогуур үнэлж гаргах.

**998. Undersubscribed issue - Захиалга нь дутсан үнэт цаас**

Зарим хэсэг нь шууд зарагдаагүй үнэт цаасны гаргалт.

**999. Underwriting - Андеррайтинг**

Компаниас гаргасан үнэт цаасыг хямдруулан авснаар үнэт цаасны арилжааг тодорхой хэмжээгээр баталгаажуулж худалдаж авах үе ба зарах үеийн үнийн зөрүүгээр эрсдэл хүлээдэг хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа.

**1000. Underwriting syndicate - Андеррайтингийн синдикат**

Томоохон хэмжээний үнэт цаасны гаргалтанд хамтарч оролцдог ХОБ-ын бүлэг. Ингэснээр нэг банкинд учрах эрсдэлийг багасгадаг.

**1001. Unemployment rate - Ажилгүйдлийн түвшин**

Ажилгүй гэж ангилагдсан хүмүүсийн тоог нийт ажиллах хүчний тоонд харьцуулсан харьцаа.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

U

v

w

x

y

z

**1002. Unique risk, firm-specific risk, nonsystematic risk, diversifiable risk** – Онцгой эрсдэл, компанийн онцлогтой эрсдэл, системийн бус эрсдэл, тархаагдах эрсдэл

Тархаах замаар алга (арилгаж) болдог эрсдэл.

**1003. Unit investment trust** – Итгэмжилсэн нэгж хөрөнгө оруулалт

Тогтмол орлоготой үнэт цаасаас бүрдсэн багцад, багцын үргэлжлэх хугацаатай тэнцүүлж оруулсан мөнгөн хөрөнгийн сан.

**1004. Unlimited funds** – Хязгаарлалтгүй санхүүжилт

Компаниас боломжийн үр ашиг өгөх бүх бие даасан төслүүдийг хэрэгжүүлж болох санхүүгийн нөхцөл байдал.

**1005. Unlimited liability** – Бүрэн хариуцлага

Зээл олгогчдын эрсдэлийг эзэмшигч нь өөрийн нийт хөрөнгөөр хариуцах нөхцөл.

**1006. Unseasoned mortgages** – Улирлын бус моргэйж

30 сараас доош хугацаатай моргэйж.

**1007. Unsecured loan** – Баталгаагүй зээл

Эд хөрөнгийг барьцаа болгож тавиагүй зээл.

**1008. Unsecured or general creditors** – Баталгаат бус буюу ердийн зээлдүүлэгчид

Компанийн тусгайлан барьцаалснаас бусад нийт эд хөрөнгөнөөс авлагаа барагдуулах ерөнхий эрхтэй зээлдүүлэгчид.

**1009. Unsecured short-term financing** – Барьцаагүй богино хугацаат санхүүжилт

Тодорхой эд хөрөнгө барьцаанд тавилгүйгээр авсан богино хугацаат санхүүжилт.

**1010. Unwind** – Задлах

Оролцогсдын хоорондын тооцоо эцэслэн хийгдэх хүртэл данс хоорондын шилжүүлгийг түр зуурын гэж тооцдог төлбөрийн зарим систем дэх өр авлагыг дахин тооцох үйл явц.

**1011. Valuation – Үнэлгээ**

Өгөөж ба эрсдэлийн хамаарал дээр үндэслэн активын үнэлэмжийг (үнэ цэнийг) тодорхойлох үйл явц.

**1012. Value date – Авсан өдөр**

Хийсэн төлбөрийг хүлээн авагч ашиглаж болох боломжтой хамгийн наад захын огноо. Дансанд тооцох хүүг мөн авсан өдрөөр тооцох нь бий.

**1013. Value-at-risk – Эрсдэлд орсон үнэлэмж (үнэ цэнэ)**

Тодорхой хугацааны турш, тодорхойлсон магадлалын дагуу багцад учрах алдагдлын магадлалаар тооцогдох эрсдэл.

**1014. Variable growth model – Хувьсах өсөлттэй загвар**

Ногдол ашгийн өсөлт нь өөрчлөгдөнө гэж үзэх ногдол ашгийн үнэлгээний загвар.

**1015. Variation margin – Үнэлгээний мааржин**

Худалдаанд оролцогч хоёр талаас клирингийн байгууллагаар дамжуулж төлбөр хийдгээс үүдсэн нээлттэй ирээдүйн болон опцион хэлцлийн өдөр тутмын ашиг алдагдал.

**1016. Vertical merger – Босоо нэгдэлт**

Нийлүүлэгч ба худалдан авагч компаниудын нэгдэлт.

**1017. Voluntary Exchange – Сайн дурын шилжүүлэг**

Нэг хувьцааг нөгөө хувьцаагаар эсвэл мөнгөөр солих санал.

**1018. Voluntary reorganization – Сайн дурын дахин зохион байгуулалт**

Дампуурсан компани өөрийнхөө нэрийн өмнөөс бүтцээ дахин өөрчилж өглөгөө төлөхийг илэрхийлсэн өргөдөл.

**1019. Voluntary settlement – Сайн дурын төлбөр тооцоо**

Хуулийн дагуу хийгдэх дампуурлын үйл ажиллагааны зардлыг тойрохын тулд дампуурсан буюу техникийн хувьд төлбөрийн чадваргүй болсон компаниас зээлдүүлэгчидтэйгээ хийдэг тохиролцоо.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

V

w

x

y

z



**1020. Warehouse receipt loan – Агуулах барьцаалсан зээл**

Зээлдүүлэгчээс барьцаалсан бараа материалдаа агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг зуучлагчаар дамжуулан хяналт тогтоож олгосон зээл.

**1021. Warrant – Баталгаат эрхтэй опцион**

Өөрийн компанийнхаа хувьцааг худалдаж авахаар компаниас гаргасан опцион.

**1022. Warrant premium – Баталгаат эрхийн урамшуулал**

Баталгаат эрхийн бодит зах зээлийн үнэлгээ ба онолын үнэлгээний зөрүү.

**1023. Weak, semistrong, strong forms EMH – Үр ашигтай зах зээлийн сул, хагас-хатуу, хатуу хэлбэрүүд**

Сул хэлбэр: Хувьцааны үнэ нь өмнөх арилжааны түүхтэй холбогдсон; мэдээллийг нэгэнт тусгасан байх шинж

Хагас-хатуу хэлбэр: Хувьцааны үнэ нь нийтэд ил тод болсон бүх мэдээллийг тусгасан байх шинж; Хатуу хэлбэр: Хувьцааны үнэ нь дотоод мэдээллийг оролцуулаад бүх холбогдох мэдээллийг тусгасан байх шинж.

**1024. Weighted average cost of capital (WACC) – Капиталын жигнэсэн дундаж өртөг**

Урт хугацааны туршид компанид шаардлагатай эх үүсвэрийн ирээдүйд хүлээгдэж буй дундаж өртөг. Бүх үнэт цаасны багцын хүлээгдэж буй өгөөж. Эх үүсвэрийн төрөл тус бүрийн өртгийн компанийн капиталын нийт бүтцэд эзлэх хувиар дамжуулан жигнэж тооцдог.

**1025. Weighted marginal cost of capital (WMCC) – Капиталын жигнэсэн ахиуц өртөг**

Компаниас шинээр авах санхүүжилтын дараагийн нэг төгрөг тутам ногдох капиталын жигнэсэн дундаж өртөг.

**1026. Well-diversified portfolio – Сайн тархагдсан багц**

Системийн бус эрсдэл нь тооцогдохгүй шахам болж хангалттай сайн тархагдсан багц.

**1027. White knight - Цагаан морь стратеги**

Зорилтот компани нь дээрэнгүй эзэмшигч компаниас илүү тааламжтай эзэмшигч компанийг олж аваад тэднийг өрсөлдүүлэх замаар өөртөө тааламжтай нөхцөлийг олж авах стратеги.

**1028. Working Capital - Эргэлтийн хөрөнгө (Ажлын капитал)**

Бизнесийн ердийн үйл явцад нэг хэлбэрээс нөгөө хэлбэр шилжиж байдаг эргэлтийн актив.

**1029. Work-in-process inventory - Дуусаагүй үйлдвэрлэл**

Үйлдвэрлэлийн явцад байгаа зүйлс.

**1030. World investable wealth - Хөрөнгө оруулж болох дэлхийн баялаг**

Арилжаанд ордог учраас хөрөнгө оруулж болох дэлхийн баялгийн хэсэг.

**1031. Yield curve - Жилийн хүүгийн муруй**

Хугацааны эцэс хүртэл жилийн хүү (босоо тэнхлэгт) ба хугацааны эцэс хүртэлх цаг хугацааны (хэвтээ тэнхлэгт) хамаарлыг харуулсан хүүгийн хугацааны бүтцийн график.

**1032. Yield to maturity - Хугацааны эцэс хүртэлх жилийн хүү**

Үнэт цаасыг тодорхой өдөр худалдаж аваад эцсийн хугацаа хүртэл эзэмших үеийн жилд шилжүүлсэн хүү.

**1033. Yield to maturity (YTM) - Үлдсэн хугацааны өгөөж**

Хөрөнгө оруулагчаас бондыг тодорхой үнээр аваад төлөгдөх эцсийн хугацаа хүртэл нь эзэмшихэд олох өгөөжийн хувь. Үнэт цаас гаргагч нь хүү, үндсэн өрөө амласан хугацаандаа төлнө гэж үзнэ.

**1034. Zero (or low) coupon bonds - Хүүгүй бонд**

Хүүгүй гаргасан бонд. Нэрлэсэн үнээсээ ихээхэн хэмжээний хямдруулалт хийж зарагдана.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

Y

Z

**1035. Zero growth model – Тэг өсөлттэй загвар**

Ногдол ашиг нь өсөлтгүй, тогтвортой гэж үзэх ногдол ашгийн үнэлгээний загвар.

**1036. Zero investment portfolio – Хөрөнгө оруулалтгүй багц**

Арбитражийн стратегийг хэрэглэн үнэт цаасыг худалдан авч тэр дор нь зарах замаар байгуулах тэгтэй тэнцүү цэвэр үнэлэмж (үнэ цэнэ) бүхий багц.

**1037. Zero-hour rule – Тэг цагийн дүрэм**

Дампуурлыг нь зарласан өдрийн шөнийн 12 цагаас хойш тухайн байгууллагын хийсэн гүйлгээг автоматаар хүчингүй гэж тооцох зарим орны хуулийн заалт.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛД ТҮГЭЭМЭЛ ХЭРЭГЛЭГДДЭГ НЭР ТОМЪЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР

## 1. Abuse - Урвуулан ашиглах

Зориулалтын бус хэлбэрээр ашиглах.

## 2. Accountability - Хариуцах явдал

Хариуцлага хүлээх, үүргээ биелүүлэх эсвэл тайлагнах.

## 3. Accountant's opinion - Хөндлөнгийн хянагч буюу аудиторын дүгнэлт

Байгууллагын нягтлан бодох бүртгэл, албан ёсны бүртгэлийн баримт бичигт хийсэн шалгалтын үр дүнг баталсан, хөндлөнгийн, итгэмжлэгдсэн аудитаар баталгаажуулсан тайлан.

## 4. Accounting - Нягтлан бодох бүртгэл

Компанийн нягтлан бодох бүртгэлийн төрөл бүрийн бүрдэл хэсгээс бүтсэн санхүүгийн нягтлан бодох бүртгэл.

## 5. Acquisition - Нэгдэлт (Худалдан авах)

Нэг компани нөгөө компанийг худалдаж авахыг хэлнэ.

## 6. Administrative authorities - Захиргааны байгууллагууд

Төрийн байгууллагууд.

## 7. Advance - Урьдчилгаа

Үнэт цаас эсвэл барааны урьдчилгаа.

A

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

A

**8. Advisory Board – Зөвлөх хороо**

Хязгаарлагдмал хариуцлагатай компани, гэр бүлийн өмчлөлтэй компани, төрийн бус байгууллага болон их, дээд сургуулиудад байдаг нэгж. Уг нэгж нь төлөөлөн удирдах зөвлөл, компанийн удирдлагад зөвлөгөө өгөх боловч компанийн ажил хэрэгт санал өгөх эрхгүй ба компанийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүр тавих үүрэг хуулиар хүлээдэггүй.

**9. Affiliated company – Холбоотой компани**

Хоёр компани нэг эзэнтэй эсвэл гуравдагч компанийн охин компани бол нэгдмэл сонирхолтой компани гэнэ.

**10. Affiliated person – Холбоотой этгээд**

Аж ахуйн үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээдийн болон/эсвэл хувь хүний явуулж буй үйл ажиллагаанд нөлөөлөхүйц бие хувь хүн юм уу эсвэл хуулийн этгээдийг хэлнэ.

**11. Agenda of Board Meeting – ТУЗ-ийн хурлын хөтөлбөр**

ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалт.

**12. American depository receipt – Америкийн хадгаламжийн бичиг**

АНУ-ын хадгаламжийн үйлчилгээ эрхэлдэг банкнаас гаргадаг тусгай, тохиролцох нөхцөлтэй гэрчилгээ бөгөөд энэ нь гадаадын оронд гаргаж, АНУ-ын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй хувьцааны тодорхой тоог төлөөлдөг.

**13. Annual meeting – Жилийн тайлангийн хурал**

Өмнөх жилийн ажлаа дүгнэх, дараа жилийн ажлын төлөвлөгөө хэлэлцэх, захирлуудыг томилох, хувьцаа эзэмшигчдэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор компанийн удирдлага хувьцаа эзэмшигчидтэйгээ ихэвчлэн санхүүгийн жилийн эцэст зохион байгуулдаг хурал.

**14. Annual Report – Жилийн Тайлан**

Хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчиддээ зориулан гаргадаг жилийн тайлан. Жилийн тайланд урьд жилийн компанийн үйл ажиллагаа, аудитлагдсан санхүүгийн гүйцэтгэл болон цаашид гүйцэтгэх ажлын төлөвлөгөө багтана.

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**15. Anti-crisis management – Хямралын эсрэг удирдлага**

Бизнесийн нэгжийн дампууралтай холбоотой асуудлыг ихэвчлэн энэ ойлголтод хамруулан, санхүүгийн дүн шинжилгээ, урьдчилсан таамаглал, бүтцийн өөрчлөлт, өрөөс чөлөөлөх ба бизнесийн нэгжийг үйлдвэрлэл, технологийн үр ашигтай ажиллагаанд шилжүүлэх, удирдлага, нягтлан бодох бүртгэл, маркетинг бий болгох зэрэг асуудлыг оруулдаг.

**16. Anti-dilution provision – Замхарлын эсрэг заалт**

Компанийн хувьцааг хуваах, шинэ хувьцааг гаргах эсвэл бусад адил арга хэмжээний үед хөрөнгө оруулагчийг бутархай өмчлөлийн хувь буурахаас хамгаалсан хэлэлцээр.

**17. Anti-takeover provision – Нэгдэлтийн эсрэг заалт**

Ихэвчлэн эргүүлэн худалдах өндөр шалгууртай давуу эрхтэй хувьцаа шинээр гаргах замаар худалдан авах үнийг нэмж, дээрэнгүй эзэмшлээс сэргийлэх арга.

**18. Appreciation – Ханш өсөх**

Хөрөнгө, үнэт цаас болон валютын ханш өсөхийг хэлнэ.

**19. Asset management firms – Активыг удирдах компани**

Үйлчлүүлэгчдийнхээ төрөл бүрийн үнэт цаасыг (бонд, үнэт цаас) удирдан зохицуулдаг компани.

**20. Audit – Аудит**

Компанийн санхүү, нягтлан бодох тайлан болон дагалдах баримтыг мэргэжлийн, хараат бус, хөндлөнгийн аудиторoor хянуулж, баталгаажуулах.

**21. Audit committee – Аудитын хороо**

Санхүүгийн тайлан бэлтгэх хараат бус аудиторыг сонгон шалгаруулах үүрэгтэй ихэвчлэн гадны гишүүдээс бүрдсэн компанийн хороо. Хороо нь аудит, компани, ажилтнуудын үйл ажиллагааны, үнэлгээг хэлэлцэнэ.

**23. Auditor – Аудитор**

Аудит гүйцэтгэхийг төрийн түвшинд зөвшөөрөгдсөн хүн.

A

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**24. Authorization – Зөвшөөрөл**

Эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл эсвэл бүрэн эрх.

**25. Authorized stock – Зөвшөөрсөн хувьцаа**

Компанийн дүрмээр гаргахыг зөвшөөрсөн хувьцааны хэмжээ.

**26. Balance Sheet – Тэнцэл**

Санхүүгийн үндсэн тайлан бөгөөд тодорхой хугацаанд компанийн хөрөнгө, өр болон өмчлөлийн талаар мэдээллийг оруулахаас гадна нягтлан бодох бүртгэлийн данс хөтлөлт, тайлбарыг бас багтаасан байдаг. Санхүүгийн нөхцөл байдлын тайлан гэж мөн хэлдэг.

**27. Balanced Score Card – Тэнцвэржүүлсэн Онооны Карт**

Тэнцвэржүүлсэн онооны хүснэгт нь компанийн үйл ажиллагааг дөрвөн хүрээнд авч үздэг. Үүнд: Үйлчлүүлэгч, дотоод үйл ажиллагаа, ажиллагсдын сурах болон мэргэших боломж, болон санхүүгийн амжилт.

**28. Bank Based Systems (Germany, Japan) – Банкинд суурилсан тогтолцоо (Герман, Япон)**

Герман, Японд хувьцаат компаниудын хөрөнгийн эх үүсвэр нь банкны зээл байдаг бөгөөд банкны актив нь ДНБ-ий 100 хувь байдаг.

**29. Bankruptcy – Дампуурал**

Төлбөрийн чадваргүй зээлдэгчийн хөрөнгийг татан буулгаж, зээлдэгчийг цаашдын хариуцлагаас чөлөөлдөг шүүхийн ажиллагаа. Төлбөрийн чадваргүй болсон зээлдэгч ба зээлдүүлэгчид тохиролцоонд хүрэхэд нь туслах зорилгоор дампуурлыг зарладаг.

**30. Basel [1] Corporate Governance 2006 – Базелийн [2] Компанийн Засаглал 2006**

2006 онд Банкны Хяналт Шалгалтын Базелийн Хороо банкуудад компанийн засаглалыг нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор 2006 онд боловсруулсан компанийн засаглалын зааварчилгаа.

**31. Benchmarking – Жишигтэй харьцуулсан шинжилгээ**

Ижил салбарт ажилладаг компаниудтай харьцуулж жиших, стандарт ба зорилго тогтооход компаниас мэдээллийг ашиглах.

### **32. Beneficial owner – Ашиг хүртэгч (Бенефициар өмчлөгч)**

Өмчлөх эрхийг хэн эзэмшиж байгаагаас үл хамааран, үнэт цаас, эд хөрөнгө эсвэл хамтын сангийн эзэмшлээс ашиг хүртдэг этгээд.

### **33. Best practice – Тэргүүн туршлага**

Ажил хэрэгт тохиромжтой гэж үзсэн эсвэл зохицуулалттай буюу тодорхой нөхцөлд хамгийн зохистой арга барил; туршлага ба судалгааны үр дүнд хүссэн эсвэл оновчтой үр дүнд найдвартай хүргэдэг арга эсвэл аргачлал.

### **34. Board Committee – ТУЗ-ийн хороо**

ТУЗ-д харьяалагддаг, тодорхой асуудлыг хариуцсан хороо бөгөөд ТУЗ-ийн зорилгоо биелүүлэх, бие даасан байдлыг хангадаг.

### **35. Board of Directors – Төлөөлөн удирдах зөвлөл**

Хувьцаа эзэмшигчдийг төлөөлж, компанийн гүйцэтгэх удирдлагыг хянах зорилгоор компанийн хувьцаа эзэмшигчдийн сонгосон бүлэг этгээд. Англи-Саксон уламжлалд төлөөлөн удирдах зөвлөл нь төлөөлөн удирдах зөвлөл ба Герман маягийн хяналтын зөвлөл хоёрын эрх үүргийг давхар гүйцэтгэдэг.

### **36. Board of Trustees – Итгэмжлэгдсэн зөвлөл**

Олон нийтийн эсвэл хувийн байгууллагын ажил хэргийг хянах зорилгоор томилогддог эсвэл сонгогддог зөвлөл.

### **37. Business judgement rule – Бизнесийг дүгнэх дүрэм**

Хэрвээ үйлдэл нь компанийн эрх ашгийг тэргүүнд тавьсан, бизнесийн сайн шүүмжийг ашиглан, анхааралтай гүйцэтгэгдсэн бол олон нийтэд арилжаалагддаг компанийн захирлыг хариуцлагад тооцохоос хамгаалах дүрэм. Мөн энэ ойлголт нь компанийн халдашгүй дархан байдалд бас хамааралтай. Компанийн шийдвэр нь сайн санаатай ба зохистой болгоомжлолыг тооцоолсон бол шүүх компанийн үйл хэрэгт оролцох эрхгүй гэсэн үг юм.

### **38. Bylaws of a company – Компанийн дотоод журам**

Хувьцаа эзэмшигчдийн баталсан компанийн дотоод ажиллагаа, засаглалын дүрмийг илтгэсэн баримт бичиг.

a

**B**

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**39. Bylaws of the Board of Directors – Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод журам**

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажиллагааны дүрмийг илтгэсэн баримт бичиг.

**40. Capital Markets Based Systems – Хөрөнгийн зах зээл дээр суурилсан тогтолцоо**

Компаниуд нь санхүүжилтээ хөрөнгийн зах зээлээс босгодог тогтолцоо. АНУ, Их Британи, бусад орнуудад банкны актив нь ДНБ-ийн 60 орчим хувийг эзэлдэг.

**41. Capital surplus – Өөрийн хөрөнгийн илүүдэл**

Эргэлтийн бус хөрөнгийг дахин үнэлгээ болон компанийн хувьцааны нэрлэсэн ба зах зээлийн үнэ хоорондын зөрөг зөрүү.

**42. Chairman of the Board – ТУЗ-ийн дарга**

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хамгийн дээд зэрэглэлийн гишүүн.

**43. Change-of-control arrangements – Хяналт шилжих тохиролцоо**

Өмнөх этгээд шинэ этгээдэд хяналтыг шилжүүлэх үед хамааралтай асуудлыг хувьцаа эзэмшигчид шийдвэрлэдэг гэрээний тохиролцоо юм.

**44. Checks and balances – Хяналт ба тэнцвэр**

Хувийн салбарын компани дахь засаглал, хяналтын дүрэм журам.

**45. Chief executive officer CEO – Гүйцэтгэх захирал**

Компанийн хамгийн дээд гүйцэтгэх албан тушаалтан.

**46. Chief Financial Officer (CFO) – Санхүү хариуцсан захирал**

Компанийн санхүүгийн төлөвлөлт болон санхүүгийн хяналтыг хариуцсан компанийн гүйцэтгэх албан тушаалтан.

**47. Chief information officer, CIO – Мэдээлэл хариуцсан захирал**

Компанийн харилцаа мэдээллийг хариуцсан гүйцэтгэх албан тушаалтан.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**48. Chief operations officer – Үйл ажиллагаа хариуцсан захирал**

Компанийн өдөр тутмын ажиллагааг хариуцсан гүйцэтгэх албан тушаалтан.

**49. Class action lawsuit – Шүүхэд хамтран гомдол гаргах**

Ижил асуудлаар гомдол гаргаж буй бүлэг хүмүүсийг төлөөлөн нэг юм уу нэгээс дээш хүнээс шүүхэд хандаж гаргасан гомдол.

**50. Class of shares – Хувьцааны төрөл**

Нэг компаниас гаргасан, ижил эрхтэй хувьцааг хэлнэ.

**51. Classified board – Ангилэгдсан зөвлөл**

Зөвлөлийн нэг хэсэг нь жил бүр сонгогддог журамтай зөвлөлийн бүтэц.

**52. Code of business conduct – Бизнес эрхлэх дүрэм**

Бизнес харилцаанд шударга зан төлөвийг тодорхойлсон дүрмүүд.

**53. Code of ethics – Ёс зүйн дүрэм**

Тухайн дүрмийг тогтоосон байгууллагын гишүүдийн зан үйлийг удирдах дүрмийн цогцолбор.

**54. Codetermination – Ажиллагсдын төлөөлөл**

Компанийн зөвлөлд ажиллагсдын төлөөллийг (ажилтнууд, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл) тодорхойлсон хэллэг.

**55. Common stock – Энгийн хувьцаа**

Компани дахь өмчлөлийн хувийг илтгэж буй үнэт цаас.

**56. Common-law voting – Хуримтлуулсан санал**

Тодорхой албан тушаалд нэр дэвшигчийн төлөө хувьцаа эзэмшигчид саналаа өгөх боломжтой тогтолцоо.

**57. Compensation committee – Цалин урамшууллын хороо**

Компанийн удирдах албан тушаалтнуудын цалин хөлстэй холбоотой стратегийг (цалин, шагнал, хувьцаа болон ажлын гүйцэтгэлд тулгуурласан нэмэгдэл) боловсруулах үүрэг бүхий ТУЗ-ийн гишүүдээс бүрдсэн дэд хороо.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**58. Compliance – Хянан нийцүүлэлт**

Хууль, журам, гэрээ, дотоод дүрмийг сахин биелүүлэх.

**59. Concentrated ownership – Төвлөрсөн өмчлөл**

Компанийн өмчлөл цөөн тооны хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байхыг хэлнэ.

**60. Confidentiality – Нууцлал**

Өөр хүний нууц буюу зорилгыг итгэмжлэгдэн мэдсэн; нууцыг хадгалах үүрэгтэй.

**61. Conflict of interest – Сонирхлын зөрчил**

Хувийн ашиг сонирхол болон албан тушаалаар итгэмжлэгдэн хүлээсэн ашиг сонирхолтой зөрчилдөх.

**62. Conflicted transaction – Сонирхлын зөрчилтэй хэлцэл**

Хувийн ашиг сонирхол компанийнхтай зөрчилдсөн эсвэл, оролцогчдын (хувьцаа эзэмшигчид, ажилтнууд болон захирлууд) олон ашиг сонирхол хоорондоо зөрчилдсөн хэлцэл.

**63. Conglomerate – Бүлэглэл**

Төрөл бүрийн салбарын бизнесийн нэгжүүдийг худалдан авах замаар үйл ажиллагаагаа өргөжүүлсэн корпораци.

**64. Contingent Liability – Тэнцлийн гадуурхи, гарч болзошгүй өр**

Урьдны үйл ажиллагаа эсвэл холбоотой үйл явдлаас гарч болзошгүй өр.

**65. Control transaction – Хяналт тогтоох хэлцэл**

Хувьцаа эзэмшигчид эсвэл бүлэг хувьцаа эзэмшигчдийг хяналтанд авах зорилготой бизнес хэлцэл.

**66. Corporate charter – Компанийн дүрэм**

Компани харъяалагдах бүртгэлийн албанд бүртгүүлсэн, компанийн зорилго, холбогдох хуулиар олгогдсон эрх, компаниас гаргаж болох зөвшөөрсөн үнэт цаасны ангилал, хувьцаа эзэмшигч, захирлуудын эрх, үүргийг заасан албан ёсны баримт бичиг.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**67. Corporate culture – Компанийн соёл**

Компанид хэвшсэн харилцаа, журам, уламжлал.

**68. Corporate finance – Компанийн санхүү**

Худалдаа, үйлдвэрлэлийн салбар дахь хэд хэдэн төрлийн валют, зээлийн үйл ажиллагаа (санхүүжилт, мөнгөн хөрөнгийн удирдлага, эрсдэлээс хамгаалах төрөл бүрийн арга замууд багтана).

**69. Corporate governance – Компанийн засаглал**

Удирдлага нь компанийн хөрөнгө оруулагчдын (түүнчлэн, зээлдүүлэгчид) ашиг сонирхлыг хамгаалж байгааг баталгаажуулахад чиглэсэн хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, компанийн гүйцэтгэх удирдлага хоорондын харилцаа.

**70. Corporate Governance Committee – Компанийн засаглалын хороо**

Компанийн засаглалын асуудлыг хөгжүүлэх зорилго бүхий ТУЗ-ийн хороо.

**71. Corporate law – Компанийн хууль**

Хуулийн этгээдийг байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах зэрэгтэй холбоотой асуудлыг зохицуулах хууль тогтоомж.

**72. Corporate opportunity – Компанийн боломж**

Компанийн албан тушаалтан, ялангуяа, захирал эсвэл өөр дээд удирдлагын компани дахь албан тушаалынхаа ачаар мэдсэн бизнес боломж. Үндсэндээ, боломж буюу мэдлэг компанид харъяалагддаг ба албан тушаалтан нь тухай боломж буюу мэдлэгийг өөрийн сонирхолд ашиглахгүй байх үүрэгтэй (фидуцийн үүрэгтэй).

**73. Corporate secretary – Компанийн нарийн бичгийн дарга**

Хувийн компани эсвэл хувьцаат компанийн ерөнхий нарийн бичгийн дарга нь хуулийн бичиг баримтыг хариуцсан хүн. Тэдний гол үүрэг нь компанид болон компанийн захирлууд хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, хувьцаа эзэмшигчдийг бүртгүүлж, тэдэнтэй харилцаж, ногдол ашиг түгээгдэж, компанийн данс хөтлөлт мөрдөгдөж байгааг баталгаажуулна.

a

b

C

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**74. Corporate social responsibility – Компанийн нийгмийн хариуцлага**

Компанийн бүх үйл ажиллагаа, явц зөвхөн эдийн засгийн салбараас гадна нийгэм, байгаль орчны хүрээнд тогтвортой хөгжлийг үүсгэх зорилготой ажиллах компанийн бүх оролцогчдын өмнө хүлээсэн үүрэг.

**75. Corporation – Корпораци**

Хязгаарлагдмал хариуцлагыг хүлээсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшсэн компани.

**76. Cross-shareholding – Солбисон хувьцаа эзэмшил**

Хоёр юм уу түүнээс олон, нийтэд арилжаалагддаг компанийн нэг компанид эзэмшиж буй хувьцааны хэмжээ нь нөгөө компанид мөн адил хэмжээний хувьцаа эзэмших эрхийг харилцан олгодог.

**77. Dead-hand poison pill – Амьгүй албатын хорт эм**

Хувьцаа эзэмшигчдийн олонхи нь тухайн компанийг өөр компани худалдан авахыг зөвшөөрч байсан ч уг худалдан авалтаас хамгаалах хэрэгсэл.

**78. Debtor – Зээлдэгч**

Зээлийн үүргийг хүлээсэн этгээд.

**79. Dilution – Хувьцаа уусах**

Нэмж хувьцаа гаргах эсвэл хувирах эрхтэй хувьцааг хөрвүүлснээс үүдэн нэгж хувьцаанаас олох ашиг, эсвэл хувьцааны бүртгэгдсэн үнэд өөрчлөлт гарах.

**80. Dilution of ownership – Өмчлөл уусах**

Энгийн хувьцаа нэмж гаргах, хувирах эрхтэй хувьцааг хөрвүүлснээс үүдэн дүрмийн санд эзлэх хувьцаа эзэмшигчдийн өмчлөл буурах.

**81. Director – ТУЗ-ийн гишүүн**

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлд ажиллахаар сонгогдсон этгээд.

**82. Directors and officers liability insurance – ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх ажилтнуудын хариуцлагын даатгал**

Компани эсвэл ашгийн бус байгууллагын ТУЗ-ийн гишүүн, ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүдэн хувьцаа ба бонд эзэмшигч, зээлдүүлэгч болон бусдад тохиолдож болзошгүй хууль зүйн зардлыг хамруулсан мэргэжлийн хариуцлагын даатгалын нөхөн олговор.

**83. Disclosure – Толилуулга**

Холбогдолтой мэдээллийн нийтлэл; нэн даруй илтгэх, тайлагнах, ил тод болгох.

**84. Dispersed ownership – Тархсан өмчлөл**

Компани нь хувьцааны багахан хувийг эзэмшдэг, олон тооны хувьцаа эзэмшигчидтэй байхыг тархсан өмчлөлтэй гэнэ.

**85. Distribution stock – Хэсэгчлэн гаргах хувьцаа**

Зах зээлд сөргөөр нөлөөлөхгүйн тулд нэг гүйлгээний оронд хэсэгчлэн гаргах хувьцаа.

**86. Divergence cost – Хазайлтын зардал**

Хувьцаа эзэмшигчийн өгөөжийг нэмэгдүүлэх компанийн гол зорилгоос хазайсантай холбогдох зардал.

**87. Dividends – Ногдол ашиг**

Мөнгөн хэлбэрээр, бусад хөрөнгө эсвэл компанийн энгийн хувьцаагаар компанийн эздэд хүртээх ашиг.

**88. Duty – Үүрэг**

Аливаа этгээдийг тодорхой жишгийн дагуу ажиллахыг хуулиар шаардсан эсвэл (гэрээний дагуу) хүлээсэн үүрэг.

**89. Duty of candor – Шударга байх үүрэг**

Сонирхлын зөрчлийг илрүүлж, хувьцаа эзэмшигчид ба бусад оролцогчид руу явуулах компанийн мэдээлэл бүрэн болон зөв байлгах үүрэг хүлээх.

a

b

c

D

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**90. Duty of care – Хянамгай байх үүрэг**

Компанид тулгарсан асуудалд нягт анхаарч, компанийн нэрийн өмнөөс гаргах бүх шийдвэрт болгоомжтой хянамгай байх үүрэг.

**91. Duty of loyalty – Үнэнч байх үүрэг**

Байгууллага, түүний бүх хувьцаа эзэмшигчид, бусад оролцогч талуудын ашгийн төлөө үнэнчээр ажиллах, өөрийн ашгийн төлөө арилжаанд оролцохгүй байх.

**92. Employee benefit plan – Ажиллагсдын тэтгэмжийн хөтөлбөр**

Ажил олгогч байгууллагаас өөрийн ажиллагсад олгох тэтгэмжийн хөтөлбөр.

**93. Employee stock ownership plan – Ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр**

Компаниас өөрийн ажиллагсаддаа тэтгэмжийн нэг хэлбэр болгон хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр.

**94. Earnings per Share (EPS) – Нэгж хувьцааны өгөөж**

Компанийн ашгаас нэгж энгийн хувьцаанд ногдох өгөөж. Нэгж хувьцааны өгөөж нь компанийн үр ашигт байдлын үзүүлэлт болдог.

**95. Equitable Treatment of Shareholders – Хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах**

Жижиг гэлтгүй хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, зөрчил гарсан үед засан залруулах шуурхай арга хэмжээ авах.

**96. Equity – Хувьцаа эзэмшигчийн хөрөнгө**

Компанийн өмч дэх хувьцаа эзэмшигчийн хөрөнгө.

**97. Event study – Үйл явдалтай холбон хийсэн судалгаа**

Тодорхой нэгэн үйл явдал, жишээлбэл компанийн аливаа шийдвэрийг зарлах, өөр компанитай нэгдэх, ногдол ашиг тараахаас өмнө болон дараах хөрөнгийн үнийн талаар хийх тандалт судалгаа.

**98. Ex-Dividend – Ногдол ашгийн хугацаа**

Ногдол ашиг зарлах ба ногдол ашиг хуваарилах хоорондын хугацаа.

**99. Ex-dividend date – Ногдол ашгийн хугацааны огноо**

Ногдол ашгийн хугацаа тоологдож эхэлмэгц хувьцаа зарагдаж эхлэх хугацааг хэлнэ. Энэ үед хувьцааг худалдагч нь ногдол ашгийг хүртэх эрхтэй байхад харин худалдан авагч нь уг эрхийг хараахан аваагүй байна.

**100. Executive director – Гүйцэтгэх захирал**

Ихэвчлэн тодорхой чиг үүргийг хариуцсан даалгавартай, мөн ихэвчлэн гэхдээ заавал биш ч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болсон байгууллагын удирдах албан тушаалтан.

**101. External auditor – Хөндлөнгийн аудитор**

Компанийн санхүүгийн тайланд аудит хийх үүрэгтэй аудитор.

**102. Extraordinary General Shareholders Meeting – Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал**

Хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хурлаас бусад бүх хурлыг хэлнэ.

**103. Fair disclosure – Шударга илчлэлт толилуулга**

Материаллаг, зах зээлд нөлөөлөхүйц бүх мэдээллийг олон нийтэд нэгэн зэрэг нийтлэх.

**104. Fairness – Шударга ёс**

Хуулийн нэр томъёогоор эрх тэгш байх гэсэн утгатай, компанийн засаглалтай холбоотойгоор бүх хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах гэсэн утгатай.

**105. Fiduciary duty – Итгэл даах үүрэг**

Үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн үнэнч шударгаар хандах мэргэжлийн үүрэг.

a

b

c

d

e

F

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z



**106. Fiduciary law – Итгэл даах хууль**

Аливаа этгээдийн хөрөнгийг эрх зүйн чадамжтай ба тухайн этгээдийн нэрийн өмнөөс санхүүгийн асуудлаар шийдвэр гаргах үүрэг хүлээсэн хувь хүн, компани, холбооны хоорондын харилцааг зохицуулсан хууль тогтоомж.

**107. Financial Statements – Санхүүгийн тайлан**

Байгууллагын санхүүгийн нөхцөл байдал, өнгөрсөн хугацааны үйл ажиллагааны үр дүнг харуулах зорилготой санхүүгийн мэдээлэл (тайлан баланс, орлогын тайлан, мөнгөн урсгалын тайлан болон бусад туслах тайлангууд).

**108. Fixing date – Тогтоосон огноо**

Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурлын үеэр санал өгөх юм уу эсвэл ногдол ашиг хүртэх эрхтэй болохын тулд хувь хүмүүс хувьцаа эзэмших ёстой хугацааг компаниас тогтоохыг хэлнэ.

**109. Foreign direct investment – Гадаадын шууд хөрөнгө оруулалт**

Дотоодын компанийн бүтэц, тоног төхөөрөмжид гадаад хөрөнгө нэмж оруулахыг хэлэх ба энэ нь хөрөнгийн зах зээлд оруулсан гадаадын хөрөнгө оруулалтыг оруулдаггүй болно.

**110. Forward looking statement – Ирээдүйг харсан мэдэгдэл**

Ирээдүйн арга хэмжээ, ажиллагаа, ашгийн тухай компанийн төлөөлөгчийн илэрхийлсэн мэдэгдэл.

**111. Fraud – Залилан**

Өөрийн ашиг сонирхлын үүднээс өөр этгээдийг мэхлэх зорилгоор гаргасан аливаа үйлдэл, илэрхийлэл, нуун дарагдуулалт, мэдээллийн дутуу өгөлт.

**112. Friendly takeover – Найрсаг эзэмшил**

Зорилтот компанийн удирдлагын зөвшөөрөн дэмжсэн худалдан авалт.

**113. Generally Accepted Accounting Principles (GAAP) – Нягтлан Бодох**

Бүртгэлийн Нийтээр Хүлээн Зөвшөөрөгдсөн Зарчмууд (ЕЗНББЗ)  
Америкийн нэгдсэн улсын Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн стандартын хорооны боловсруулсан санхүүгийн мэдээг тайлагнах журам.

**114. Global Corporate Governance Forum – Дэлхийн Компанийн Засаглалын Чуулган**

Дэлхийн Компанийн Засаглалын Форум Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Зөвлөх үйлчилгээний дэргэд байдаг олон хандивлагч бүхий сан бөгөөд компанийн засаглалыг хөгжүүлэх санаачлагуудыг дэмждэг байгууллага юм.

**115. Going Concern – Үйл ажиллагаагаа явуулах таамаглал**

Компани нь одоогийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж чадахуйц хугацаанд үйл ажиллагаагаа явуулна гэсэн таамаглал.

**116. Golden bungee – Алтан олс**

Компанийн удирдлагын цалингийн багцыг хэлэх бөгөөд үүнд гэнэт халагдсаны тэтгэмж, бэлэн мөнгө, төрөл бүрийн боломжууд болон компанид тогтвор суурьшилтай ажиллах бусад урамшуулал багтдаг.

**117. Golden handshake – Алтан гар барилт**

Компанийн удирдлагын хөдөлмөрийн гэрээг цуцлах тохиолдолд гэнэт халагдсаны тэтгэмж олгох тухай хөдөлмөрийн гэрээнд багтсан заалт.

**118. Golden hello – Алтан мэндчилгээ**

Компанид ажиллуулахын тулд урамшуулах зорилгоор шинэ гүйцэтгэх ажилтанд төлдөг бэлэн мөнгө эсвэл бусад төлбөр.

**119. Golden parachute – Алтан шүхэр**

Цуцлалтын нөхцөлд гүйцэтгэх албан тушаалтанд ажлаас халагдсаны томоохон багцыг олгодог гэрээний заалт. Тус багцад цалинг үргэлжлүүлэн олгох хугацаа, урамшуулал эсвэл тодорхой тэтгэмж, давуу эрх, мөн хувьцааны опционы түргэвчилсэн гүйцэтгэл багтана.

**120. Governance – Засаглал**

Аливаа зүйлийг удирдах зорилготой байгууллагыг бүрдүүлдэг хүмүүс (эсвэл хороод, хэлтэс).

**121. Governance committee – Засаглалын хороо**

Компанийн засаглалын асуудлуудыг хариуцсан хэсэг ТУЗ-ийн гишүүд. Засаглалын хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа болон цалин хөлсний асуудлыг хариуцдаг.

a

b

c

d

e

f

G

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**122. Greenmailing – Төлбөрийг шаардах**

Дээрэнгүй эзэмшилд өртсөн компанийн хувьцааг авч, тухайн компанийг худалдан авалтыг зогсоохын тулд өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг тулгасан арга барил.

**123. Hedge fund – Хамгаалалтын сан**

Хувьцаа, өрийн бичиг болон бусад бараа бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийдэг хөрөнгө оруулалтын сан юм.

**124. Historical cost – Түүхэн өртөг**

Бүх санхүүгийн тайлангийн зүйлсийг анхдагч өртөгт үндэслэхийг шаардсан нягтлан бодох бүртгэлийн зарчим.

**125. Hostile takeover – Дээрэнгүй эзэмшил**

Аливаа компанийн удирдлага ба төлөөлөн удирдах зөвлөлийн дэмжээгүй бөгөөд зөвшөөрөөгүй худалдан авалт.

**126. Human resources management – Хүний нөөцийн удирдлага**

Хүний нөөцийн бодлого, хүний нөөцийн удирдлагын ерөнхий чиг, аргачлалын талаарх ойлголт, стратегийг боловсруулахад чиглэгдсэн байгууллагын удирдлага, хүний нөөцийн хэлтэс, удирдлага, мэргэжилтнүүдийн авч хэрэгжүүлдэг үйл ажиллагаа.

**127. Incentive cost – Урамшууллын зардал**

Компанийн удирдлагыг хувьцаа эзэшигчдийн ашгийг нэмэгдүүлэхийн төлөө өгч буй урамшууллын өртөг.

**128. Income Statement – Орлогын тайлан**

Тодорхой хугацааны орлого болон зардлын тайлан.

**129. Independence – Хараат бус байдал**

Компанийн ТУЗ-д ажилласан цалингаас гадна зөвлөгөө болон бусад төлбөрийг авдаггүй байх. Компани буюу түүний хараат компанид ажилладаггүй байх.

**130. Independent – Хараат бус**

Өөрөөсөө том нэгжтэй холбоогүй байх.

**131. Independent auditor – Хараат бус аудитор**

Компанийн санхүүгийн бүртгэлд аудитыг гүйцэтгэдэг хөндлөнгийн аудитын аж ахуйн нэгж.

**132. Independent chairman – Хараат бус ТУЗ-ийн дарга**

Компанийн ажилтан/удирдлага биш эсвэл компанитай холбоогүй. Ийм тохиолдолд компани нь ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирлын үүргийг тусгаарласан байна.

**133. Independent director – Хараат бус ТУЗ-ийн гишүүн**

Томоохон хөрөнгө оруулагчтай ямар ч шууд холбоогүй, гүйцэтгэх ажил хийдэггүй гишүүн.

**134. Initial Public Offering (IPO) – Үнэт цаасаа олон нийтэд анхлан гаргах санал болгох.**

Хаалттай компани хувьцаагаа олон нийтэд анх удаа арилжаалах үйл явц. Гол төлөв шинээр байгуулагдсан жижиг компаниуд энэхүү арилжааг хийх боловч хувийн томоохон компаниуд гаргаж бас болно.

**135. Inside director – Дотоодын ТУЗ-ийн гишүүн**

Компанийн ажилтан бөгөөд ТУЗ-ийн гишүүн.

**136. Insider System – Дотоод тогтолцоо**

Илүү төвлөрөлтэй (цөөн эзэдтэй) тогтолцоог дотоод тогтолцоо гэнэ. Европын улсуудад түгээмэл байдаг- Дани/Герман загвар.

**137. Insider trading – Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох**

Компанийн удирдах албан тушаалтан эсвэл ажилтнаас авсан мэдээллийн үндсэн дээр үнэт цаасны арилжаа хийх. Ингэхэд зах зээлийн наймаачид болон компани дотроос мэдээллийг авсан этгээд нарын хооронд мэдээллийн тэнцвэргүй байдал үүснэ.

**138. Insolvency – Төлбөрийн чадваргүй**

Төлбөр гүйцэтгэх чадваргүй болох.

a

b

c

d

e

f

g

h

**l**

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**139. Internal audit – Дотоод аудит**

Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын тогтмол үнэлгээ. Удирдлагаас хараат бус, дэг журамтай, мэргэшсэн компанийн ажилтнууд эсвэл гэрээгээр гадны байгууллагаар дотоод аудитыг хийлгүүлж болно. Дотоод аудит нь удирдлагад баталгаажуулалт ба зөвлөгөөг өгдөг. Дотоод аудит нь хяналтын зөвлөл эсвэл аудитын хороонд тайлагнадаг.

**140. Internal control – Дотоод хяналт**

Бизнес зорилтоо биелүүлж, хүсээгүй үйл явцыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхийг баталгаажуулах зорилготой бодлого, журам, үнэлэмж, арга барил, зохион байгуулалтын бүтэц.

**141. International Financial Reporting Standards – Олон улсын санхүүгийн тайлагналын стандарт**

Олон улсын нягтлан бодох бүртгэлийн хорооны баталсан олон улсын нягтлан болох бүртгэлтэй холбоотой стандарт, тайлбарууд.

**142. Investment bank – Хөрөнгө оруулалтын банк**

Үйлчлүүлэгчиддээ зориулан шинэ үнэт цаасыг гаргахад тусалдаг банк.

**143. Issue – Хувьцаа гаргах**

Компаниас гаргасан үнэт цаасны багц бөгөөд энэ нь уг үнэт цаасыг эзэмшигчдээ эрх тэгш ханддаг.

**144. Issued and Outstanding – Гаргасан хувьцааны үлдэгдэл**

Аливаа компанийн гаргачихаад байгаа нийт хувьцааг хэлэх ба компанийн хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Компани өөрийн гаргасан хувьцаагаа дараа нь эргүүлэн худалдан авсан тохиолдолд уг хувьцааг компанийн сангийн хувьцаа гэнэ.

**145. Joint Stock Company (listed company, stock exchange company, public limited company) – Хувьцаат компани**

Хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалж буй компани.

**146. Leveraged buyout – Хөшүүрэгдсэн худалдан авалт**

Компанийн хувьцааг худалдан авсан үнийн ихэвчлэн 70% юм уу эсвэл түүнээс дээш хувийг зээлийн хөрөнгөөр авахыг хэлнэ.

**147. Liquidation - Татан буулгалт**

Хөрөнгийг зохих талуудад хуваарилан, өр төлбөрийг барагдуулах замаар үйл ажиллагаагаа зогсоох.

**148. Listed - Бүртгэгдсэн компани**

Хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжаалагддаг компани.

**149. Lockup restrictions - Түгжилтийн хязгаарлалт**

Хувьцааг анх арилжаалахад, эсвэл гүйцэтгэх удирдлагад олгох хувьцааны зарах хугацаанд тавьдаг хязгаарлалт.

**150. Management - Удирдлага**

Компанийн удирдлага нь компани, компанийн менежерүүдийн сонирхолд нийцүүлэн, компанийн бүх эх үүсвэрийг үр дүнтэй ашиглах замаар амжилтад хүрэх зорилго, арга замыг тодорхойлохыг хэлнэ.

**151. Management accounting - Удирдлагын нягтлан бодох бүртгэл**

Дотоодын хэрэгцээнд зориулан (удирдлага, хувьцаа эзэмшигч, хяналтын зөвлөлд зориулсан мэдээлэл) санхүүгийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх.

**152. Management decisions - Удирдлагын шийдвэр**

Байгууллагын зорилгыг биелүүлэхийн тулд менежерт олгогдсон эрхийн хүрээнд гаргах шийдвэр.

**153. Management psychology - Удирдлагын сэтгэл зүй**

Удирдлагын үйл ажиллагааг сэтгэл зүйн үүднээс судлах сэтгэл зүйн нэгэн салбар. Удирдлагын сэтгэл зүйн гол зорилго нь удирдлагын тогтолцооны үр дүн, чанарыг сайжруулахын тулд удирдлагын үйл ажиллагааны сэтгэл зүйн нөхцөл, өвөрмөц байдалд дүн шинжилгээ хийхэд оршдог.

**154. Materiality - Материаллаг байдал**

Учир мэдэх хүн тухайн мэдээллийг ашигласнаар дүгнэлт нь өөрчлөгдөж болзошгүй нягтлан бодох бүртгэл, санхүүгийн аливаа мэдээллийн орхигдуулалт эсвэл буруу мэдээлэлт.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

M

n

o

p

q

r

s

t

u

v

w

x

y

z

**155. Merger – Нийлүүлэх**

Нэг компани нь эрх зүйн этгээд байхаа больж, хоёр компанийг эрх зүйн хувьд нэгтгэх. Үлдэж буй компани нь өөрийн нэрээ авч үлдэн, нөгөө компанийн бүх хөрөнгө болон өрийг хүлээн авна.

**156. Minority shareholder – Жижиг хувьцаа эзэмшигч**

Компанийн ажлыг хянах эсвэл нөлөөлөх аливаа эрх мэдлийг олгоход хэтэрхий бага тооны хувьцаа эзэмшигч.

**157. Mongolian corporate governance code 2007 – Монголын компанийн засаглалын кодекс**

Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор компанийн засаглалын кодексийг баталсан. Уг журам нь Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын 2004 оны компанийн засаглалын зарчимд үндэслэсэн.

**158. Monitoring cost – Хяналтын өртөг**

Компанийн үйл ажиллагааг хянахад гарч буй зардал.

**159. Mutual Fund – Хамтын сан**

Олон нийтэд хувьцаагаа санал болгодог хөрөнгө оруулалтын банк бөгөөд хувьцаагаар босгосон хөрөнгөөрөө олон төрлийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг.

**160. Nominating committee – Нэр дэвшүүлэх хороо**

ТУЗ-ийн гишүүнчлэлд хүмүүсийг санал болгох үүрэг бүхий дэд хороо ТУЗ-ийн хараат бус гишүүдийн санал чухал байр суурь эзэлдэг.

**161. Noncurrent asset – Эргэлтийн бус хөрөнгө**

Дүрмийн дагуу хувь нийлүүлсэн хувьцаат компанийн үйл ажиллагааны үеэр бэлэн мөнгөнд хөрвүүлэх, худалдах, эсвэл солих эрхгүй хөрөнгө.

**162. Non-executive director – Гүйцэтгэх бус захирал**

Компанийн гүйцэтгэх удирдлагын өдөр тутмын ажилд оролцоогүй компанийн төлөөлөн удирдах зөвлөлд хувьцаа эзэмшигчдийн саналаар сонгогдсон хүн.

**163. One-tiered board system – Нэг шатлалтай ТУЗ-ийн тогтолцоо**

Гүйцэтгэх болон гүйцэтгэх биш гишүүд нэг төлөөлөн удирдах зөвлөлд байдаг бүтэц.

**164. Organization for Economic Cooperation and Development (OECD) Principles of Corporate Governance 2004 – Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын 2004 оны компанийн засаглалын зарчмууд**

Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын гаргасан зургаан бүлэг бүхий компанийн засаглалын зарчмууд.

**165. Outsider system – Гадаад тогтолцоо**

Компанийн өмчлөл нилээд тархсан (олон эзэдтэй) байх тогтолцоог гадаад тогтолцоо гэдэг. АНУ, Англи улсад түгээмэл байдаг.

**166. Paid-in surplus – Нэмэгдэл өөрийн хөрөнгө**

Хувьцаа эзэмшигчид хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлсөн дүнг хэлнэ.

**167. Partnership – Нөхөрлөл**

Хоёр буюу түүнээс дээр тооны хүмүүс /этгээдүүд/ бичгээр, амаар харилцан тохиролцож, ашгийн төлөө арилжаа эсвэл бизнес хийж, олсон ашгаа хуваах харилцаа. Хувьцаат компанийг бодвол түншүүд нь түншлэлийн өр төлбөрт хувийн хариуцлага үүрдэг.

**168. Pay-for-performance – Гүйцэтгэлд үндэслэсэн цалин**

Ажилтны цалин нь компанийн үйл ажиллагааны үр дүнгээс шууд хамааралтай байхыг хэлнэ.

**169. Pension fund – Тэтгэврийн сан**

Компани, засгийн газрын ба бусад байгууллагын тэтгэвэрт гарсан ажиллагсад зориулан тэтгэвэр тэтгэмж олгох зорилгоор ажил олгогч эсвэл ажиллагсдаас суутгасан мөнгө түүнээс олсон ашгаас бүрдсэн сан.

**170. Pension plan – Тэтгэврийн хөтөлбөр**

Өөрсдийн ажиллагсдад зориулан тэтгэвэр тэтгэмжийг олгох зориулалтаар компани, засгийн газар, үйлдвэрчний эвлэл, бусад байгууллагаас бүрдүүлсэн тэтгэврийн хөтөлбөр.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

О

Р

q

r

s

t

u

v

w

x

y

z



**171. Perks – Нөхөн олговор**

Тухайн ажлыг гүйцэтгэж байгаатай холбоотойгоор өгч буй нөхөн олговор.

**172. Piercing the corporate veil – Компанийн хөшиг дэлгэх**

Хэдийгээр компанийн албан тушаалтан, захирал эсвэл хувьцаа эзэмшигч ердийн тохиолдолд компанийн хариуцах үүргийн шаардлагаас хамгаалагддаг ерөнхий зарчимтай ч эдгээр хүмүүс компанийн өр төлбөрийг хариуцахаар болдог эрх зүйн шийдвэрийг тайлбарласан компанийн хуулийн нэр томъёо.

**173. Poison pill – Хорт эм**

Эзэмшилтийн зардлыг нэмж дээрэнгүй эзэмшлээс сэргийлэхэд чиглэгдсэн арга мэх.

**174. Pooling of interests – Ашиг сонирхлыг нэгтгэх**

Компани нийлэх үеийн нягтлан бодох бүртгэлийн арга, ба энэ үед төлөх татварын хэмжээнд ямар нэгэн өөрчлөлт гаргахгүйгээр нийлж буй хоёр компанийн санхүүгийн тайланг нэгтгэхийг хэлнэ.

**175. Preferred Stock – Давуу эрхтэй хувьцаа**

Компаниас гаргасан үнэт цаас бөгөөд энгийн хувьцааг бодвол ногдол ашиг болон активаас авах давуу эрхтэй хувьцаа. Ногдол ашиг нь тогтсон хэмжээгээр олгогддог.

**176. Price-to-earnings ratio – Үнэ ба ашгийн харьцаа**

Хувьцааны өнөөгийн үнийг хувьцаа тус бүрийн ашигт 12 сарын хугацаанд хуваах замаар компанийн ашиг ба хувьцааны үнийн хоорондын харьцааг тооцох аргачлал.

**177. Principal shareholder – Гол хувьцаа эзэмшигч**

Нийтэд гаргасан компанийн саналын эрхтэй хувьцааны 10% ба түүнээс дээш хувийг эзэмшигч.

**178. Principal-Agent Dilemma – Эзэн-Агентын зөрчил**

А хүн нь Б хүнийг өөрийн ашиг сонирхолд нийцүүлэхийн тулд яаж сэдэлжүүлэхтэй холбогдсон бэрхшээл.

**179. Private equity - Хувийн хөрөнгө оруулалт**

Хувийн эзэмшилд байдаг, нийтэд арилжаалагддаггүй компанид хийсэн хөрөнгө оруулалт.

**180. Privatization - Хувьчлал**

Ажиллагсад эсвэл хөрөнгө оруулагчдаас компанийн хувьцааг бүгдийг эсвэл хэсэгчлэн худалдан авахыг хэлнэ.

**181. Proprietorship - Хувиараа эрхлэх аж ахуй**

Хувьцаат компани эсвэл хязгаарлагдмал хариуцлагатай компанитай харьцуулахад эзэн нь хариуцлагын эрхгүй бизнес.

**182. Proxy - Эчнээ санал**

Хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн хурал дээр санал хураалгах асуудлууд дээр саналаа тусган хувьцаа эзэмшигчдэд явуулсан бичиг.

**183. Proxy card - Эчнээ саналын эрх**

Хувьцаа эзэмшигч өөрийн саналаа эчнээгээр өгөх, итгэмжлэгдсэн төлөөлөгчөө сонгох арга хэрэгсэл.

**184. Proxy contest - Эчнээ саналын төлөөх уралдаан**

Компанийг өөр компани худалдан авах оролдлого гарсан үед хувьцаа эзэмшигчдийн саналыг өөртөө татахыг оролдох, эчнээ саналын төлөөх тэмцэл ч гэж нэрлэдэг.

**185. Proxy statement - Эчнээ саналын тайлан**

Нийт хувьцаа эзэмшигчдийн хурал дээр санал хураах асуудлуудыг тусгасан биржид бүртгэлтэй компаниас хувьцаа эзэмшигчдэдээ илгээдэг баримт бичиг.

**186. Proxy voting - Эчнээ санал**

Өөрөөр заагаагүй бол санал өгөгчид саналын эрхээ тодорхой хүмүүст шилжүүлсэн гэж тооцдог компанийн санал өгөх тогтолцооны хэлбэр.

**187. Prudent man rule - Журмын нөхрийн дүрэм**

Итгэл даах үүрэг хүлээсэн /итгэмжлэгдсэн/ этгээдээс хөрөнгө оруулалт хийж болох үнэт цаас болон тодорхой үнэт цаасны ангиллыг тогтоодог хөрөнгө оруулалтын стандарт.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

**p**

q

r

s

t

u

v

w

x

y

z

**188. Public corporations – Олон нийтийн компани**

Хувьцаа нь олон нийтэд санал болгох журмаар нээлттэй зах зээлд арилжаалагддаг компани.

**189. Quarterly report – Улирлын тайлан**

Улирлын санхүүгийн үр дүнг нийтэлсэн засварлаагүй баримт.

**190. Quorum – Ирц**

Бизнесийн үйл ажиллагаа явуулах эсвэл шийдвэр гаргахын тулд заавал хүрэлцэн ирсэн байх гишүүд эсвэл албан тушаалтнуудын тоо (олонхи).

**191. Ratification – Соёрхон батлах**

Албан ёсны эрх олж авдаг журам.

**192. Rating agency – Үнэлгээний агентлаг**

Үнэт цаасны хөрөнгө оруулагчдад зориулан компаниудын бондод үнэлгээ тогтоодог ангилдаг агентлаг. Үнэлгээ нь хөрөнгө оруулагчдад бондын эрсдэлийн талаарх мэдээлэл өгдөг.

**193. Reasonable assurance – Боломжит баталгаа**

Бүрэн баталгаа биш боловч хяналтын зардлыг хүрэх ач тустай нь харьцуулахад хангалттай гэж үзэх зохистой байдлын түвшин.

**194. Recapitalization plan – Дахин хөрөнгөжүүлэлтийн төлөвлөгөө**

Компаниас өөрийн хөрөнгийн бүтцийг өөрчлөх төлөвлөгөө. Дахин хөрөнгөжүүлэлтийн үр дүнд компанийн нийт хувьцааны тоо өөрчлөгдөхөөс гадна энгийн хувьцаанаас гадна өөр төрлийн хувьцаа гарч болзошгүй. Дахин хөрөнгөжүүлэлтийн төлөвлөгөөг олонхи хувьцаа эзэмшигчид батлах шаардлагатай.

**195. Related party transaction – Холбогдох талын хэлцэл**

Хэлцлээс өмнө тусгай харилцаагаар нэгдсэн хоёр этгээдийн хооронд хийгдэх бизнес хэлцэл буюу тохиролцоо.

**196. Replacement costs – Орлуулалтын зардал**

Активыг зах зээлийн өнөөгийн үнээр нь тооцож нөхөн орлуулах зардлын дүн.

### 197. Responsibility – Үүрэг хариуцлага

Итгэлийг даах хэлбэр; Аливаа зүйлийн төлөө аливаа этгээдийн өмнө үүрэг хүлээх эсвэл аливаа этгээдийн үйлдлийг хариуцах.

### 198. Retail investor – Жижиглэнгийн хөрөнгө оруулагч

Өөрийн хэрэгцээнд зориулан бага хэмжээний үнэт цаасыг өөрийн нэрээр худалдан авагч хувь хүн. Хувийн хөрөнгө оруулагч гэж зарим тохиолдолд нэрлэдэг.

### 199. Return on assets – Активын өгөөж

Компанийн ашиг ажиллагааг хэмжих арга:

“Санхүүгийн жилийн ашгийг нийт активт хувааж хувиар илэрхийлнэ”.

### 200. Return on equity – Өөрийн хөрөнгийн өгөөж

Компанийн хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтын өгөөжийг хэмжих санхүүгийн арга:

“Санхүүгийн жилд ногдох татварын дараах орлогыг (давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хуваарилсны дараа, харин энгийн хувьцааны ногдол ашгийг хуваарилахын өмнө) хувьцааны бүртгэлийн үнэд хувааж, хувиар илэрхийлнэ”.

### 201. Return on investment – Хөрөнгө оруулалтын өгөөж

Хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцох санхүүгийн арга: санхүүгийн жилийн цэвэр орлогыг энгийн, давуу эрхтэй хувьцаа ба урт хугацааны өрийн нийлбэрт хуваана.

### 202. Right to vote – Санал өгөх эрх

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн бодлогын асуудалд санал өгөх эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдэд олгогдсон эрх.

### 203. Rights of appraisal – Давж заалдах эрх

Компанийн тодорхой хэлцэл, үйл ажиллагааг буруутай хэмээн үзэж хувьцааны бодит үнийг тогтоохын тулд хууль хяналтын байгууллагын шалгалтыг шаардах хувьцаа эзэмшигчдийн эрх. Давж заалдах эрх нь өөр компанитай нэгдэх, үндсэндээ компанийн бүх активыг зарах, тэрслүү хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт материаллаг нөлөө үзүүлэхүйц компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн үед хэрэгжих боломжтой.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

R

s

t

u

v

w

x

y

z

**204. Risk aversion – Эрсдэлээс зайлсхийлт**

Хөрөнгө оруулагчдын эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийхээс зайлсхийх хандлага.

**205. Risk Management – Эрсдэлийн удирдлага**

Компанийн үйл ажиллагааны зарчимтай нийцэхүйц эрсдэл/өгөөжийн харьцааг тогтоохын тулд бизнес эрсдлүүдийг таних тодорхойлох, хянах үйл явц.

**206. Sarbanes-Oxley – Сарбейнс- Оксли**

Америкийн Нэгдсэн Улсын 2002 онд батлагдсан хууль. Уг хуулиар гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар компанийн үр дүн болон дотоод хяналтыг баталгаажуулж байх, компани хараат бус аудитын хороотой байх, хөндлөнгийн аудиторын гол аудиторыг өөрчилж байхыг шаардаж гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн гишүүд гүйцэтгэх удирдлагад зээл олгохыг хориглосон.

**207. Securities analyst – Үнэт цаасны шинжээч**

Үнэт цаасны зах зээл дээр ажиллаж буй мэргэжилтэн. Авах талын шинжээчид байгууллагын хөрөнгө оруулагчдын төлөө ажилладаг. Зарах талын шинжээч брокерийн болон хөрөнгө оруулалтын банкны төлөө ажилладаг.

**208. Segregation of duties – Чиг үүргийн тусгаарлалт**

Зөвшөөрөлгүй өөрчлөлт хийх эсвэл мэдээ, үйлчилгээг буруугаар ашиглахыг урьдчилан сэргийлэх, эрсдэлийг багасгахын тулд тодорхой чиг үүрэг эсвэл ажлын удирдлага эсвэл гүйцэтгэлийг нь тусгаарлаж өгөх.

**209. Selective disclosure – Сонгосон толилуулга**

Холбогдолтой, материаллаг, зах зээлд нөлөөлөхүйц мэдээллийг сонгосон хэдэн этгээдэд өгөх.

**210. Self-dealing – Өөрийн ашгийн төлөө арилжаанд оролцох**

Хэтэрхий ойр санхүүгийн арилжаа буюу хяналтыг гартаа авсан этгээд өөрийн ашигт нийцүүлэн тухайн компаниас мөнгө зээлэх эсвэл зээлдүүлэх ажиллагаа.

**211. Separation of ownership and control – Өмчлөл ба хяналтыг тусгаарлах**

Эзэмших эрх гэдэг нь компанийн ашгаас хүртэх эрх, харин хянах эрх гэдэг нь компани нь юу хийх вэ гэдгийг шийдэх эрх юм. Энэхүү аргаар компанийн эзэн болон менежерийн хоорондох ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэдэг. Ингэхийн тулд Компанийн ТУЗ нь компанийн удирдлагыг үр нөлөөтэйгээр хянах хэрэгтэй.

**212. Severance pay – Гэнэт халагдсаны тэтгэмж**

Халагдсан ажилтанд олгодог нөхөн төлбөр.

**213. Share consolidation – Хувьцааг нэгтгэх**

Хувьцааны нэрлэсэн үнийг нэмэгдүүлэх замаар хувьцааны тоог хэмжээг багасгах арга. Жишээ нь: 100 ширхэг хувьцааг 1 ширхэг хувьцаа болгох

**214. Share repurchase plan – Хувьцааг дахин худалдан авах хөтөлбөр**

Компанийн удирдлага тухайн компанийн хувьцааны зах зээлийн үнэ хямд байна гэж үзвэл нээлттэй зах зээлд арилжаалагдаж буй, урьд нь гаргасан хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг хэлнэ.

**215. Shareholder – Хувьцаа эзэмшигч**

Компанийн хувьцааг эзэмшигч хувь хүн эсвэл хуулийн этгээд.

**216. Shareholder activism – Хувьцаа эзэмшигчдийн идэвхи**

Хувьцаа эзэмшигчийнхээ хувьд компанийн зан үйлд нөлөөлөх арга зам, идэвхитэй байдал.

**217. Shareholder proposal – Хувьцаа эзэмшигчийн санал**

Компанийн жилийн хуралд компаниас тодорхой чиглэлийг шаардаж, бусад хувьцаа эзэмшигчдийн саналыг авахаар танилцуулсан хувьцаа эзэмшигчийн санал.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

S

t

u

v

w

x

y

z

**218. Shareholder resolution – Хувьцаа эзэмшигчдийн тогтоол**

Зах зээлийн үнээр 2,000 ам. доллараас багагүй саналын эрхтэй хувьцаа юм уу эсвэл компанийн нийт саналын эрхтэй хувьцааны 1%-тай тэнцүү хувьцаа эзэмшигчдийн гаргасан санал юм уу шаардлага. Уг шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үеэр бусад хувьцаа эзэмшигчдийн саналаа өгсөн ямарваа нэгэн асуудлыг компани ба/эсвэл ТУЗ ажил хэрэг болгон хэрэгжүүлэхийг шаардаж болно.

**219. Socially responsible investing – Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт**

Нийгмийн болон санхүүгийн өгөөж гаргах зорилгоор ёс зүй сайтай компанид хөрөнгө оруулалт хийх стратеги.

**220. Spin-off – Компанийг бие даалгах**

Компанийг задлах замаар, компанийн аль нэг хэсэг дээр үндэслэн бие даасан компани байгуулах.

**221. Split of shares – Хувьцаа хуваалт**

Тодорхой нэг төрөл, ангиллын хувьцааг адил төрөл, ангиллын хоёр болон түүнээс дээш хувьцаа болгон хөрвүүлэхийг хэлнэ.

**222. Staggered board – Ангилэгдсан зөвлөл**

Сөрөг худалдан авалтыг сэргийлэх зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлийн нэг хэсэг нь жил тутам сонгогддог зарчимтай компанийн зөвлөлийн бүтэц.

**223. Stakeholder – Оролцогч тал**

Байгууллагыг амжилттай байх сонирхолтой аливаа хүн, бүлэг эсвэл байгууллага. Оролцогч тал нь гадаад (байгууллагын гадна байгаа) ба дотоод (үүнд байгууллагад ажиллаж буй) гэсэн хоёр төрөл байдаг. Оролцогч талын жишээ нь эзэн, менежер, хувьцаа эзэмшигч, ажилтан, үйлчлүүлэгч, түнш, эсвэл нийлүүлэгч, болон бусад этгээд.

**224. Statement of Cash Flows – Мөнгөн урсгалын тайлан**

Санхүүгийн тайлангуудын үндсэн тайлангуудын нэг. Тухай үеийн нийт зарцуулсан эсвэл олсон мөнгөн хөрөнгийг үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын болон санхүүжилтийн хэмээн ангилан, эхний болон эцсийн мөнгөн хөрөнгийн тулгалт хийдэг.

### **225. Statutory voting – Хууль ёсны санал**

Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-д нэр дэвшигчид санал өгөхдөө нэр дэвшигч тус бүрийн төлөө бүх саналаа өгөх юм уу эсвэл нэр дэвшигч тус бүрийн эсрэг саналаа өгөх арга.

### **226. Stock – Хувьцаа**

Компанийн дүрмийн санд хувь эзэмших эрх бөгөөд энэ эрхийг дагалдан оруулсан хөрөнгө оруулалтынхаа өгөөжийг хүртэх, компанийн хөрөнгө, ашгаас тодорхой хувь хүртэх бусад боломжууд ирдэг.

### **227. Stock Option – Хувьцааны опцион**

Тодорхой үнэт цаас эсвэл хөрөнгийг тодорхой хугацаанаас өмнө нэрлэсэн үнээр худалдаж авах эсвэл зарах эрх.

### **228. Stock purchase plan – Хувьцаа худалдан авах хөтөлбөр**

Компанийн хувьцааг эзэмших эрхийг ажилтанд олгосон ажил олгогчоос ажилтанд олгох тэтгэмжийн багц.

### **229. Stock split – Хувьцаа хуваах**

Хувьцаа эзэмшигчдийн тоог хэвээр хадгалж, харин нэгж хувьцааны зах зээлийн үнийг харьцаатайгаар бууруулж компанийн хувьцааг хуваах замаар компанийн нийт хувьцааны тоог нэмэгдүүлэх.

### **230. Stockholder – Хувьцаа эзэмшигч**

Компанид хувьцаа эзэмшиж буй хувь хүн эсвэл байгууллага.

### **231. Strategy Formulation – Стратеги боловсруулах**

Зорилтуудад хүрэхийн тулд стратегийг боловсруулдаг. Компанийн ТУЗ стратегийг боловсруулах үүрэгтэй.

### **232. Subsidiary – Охин компани**

Хувьцааны олонхийг нь өөр компани эзэмшсэн компани.

### **233. Supermajority – Дийлэнхи олонх**

Компани өөр компанитай нэгдэх зэрэг чухал өөрчлөлтийг батлахын тулд хувьцаа эзэмшигчдийн үнэмлэхүй олонхийг (67-90 хувь хүртэл) шаардсан компанийг дүрмийн нэмэлт өөрчлөлт.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

S

t

u

v

w

x

y

z



**234. Supervisory Board – Хяналтын зөвлөл**

Компанийн засаглалын хоёр шатлалтай тогтолцоонд зөвлөл ба гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хувьцаа эзэмшигч болон ажилтнуудын нэрийн өмнөөс хянах чиг үүрэгтэй байгууллага. Герман тогтолцоонд хяналтын зөвлөл төлөөлөн удирдах зөвлөлөөс тусдаа оршдог бол Англи-Саксон уламжлалд төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн болон хяналтын зөвлөлийн чиг үүргийг нийлүүлэн хэрэгжүүлдэг.

**235. Sustainability – Тогтворжилт**

Эдийн засаг, нийгмийн хөгжил болон байгаль орчны асуудлыг ирээдүйн үеийнхний амьдралын чанарыг ядахдаа өнөөдрийн хэмжээнд тогтоох эрмэлзэлтэй нийлүүлсэн үзэл.

**236. Synergy – Нэгдсэн чармайлт**

Компани А-г компани Б-тэй нэгтгэн компани В байгуулах бол шинээр байгуулагдсан компанийн зах зээлийн үнэ А болон Б компани тусдаа байхаас илүү гэсэн ойлголт.

**237. Systemic risk – Системийн эрсдэл**

Бизнес харилцаа холбоотой холбоотойгоор нийт салбар болон хэсэг компаниудад нөлөөлөх эрсдэл.

**238. Tag-along Rights – Дагах эрх**

Жижиг хувьцаа эзэмшигчдийг хамгаалах гэрээт үүрэг. Томоохон хувьцаа эзэмшигчид хувьцаагаа зарах тохиолдолд жижиг хувьцаа эзэмшигчдэд тухайн үйл ажиллагаанд оролцох эсвэл ижил үнээр хувьцаагаа борлуулах эрх.

**239. Target firm – Зорилтот компани**

Нэгтгэх эсвэл худалдан авах гэж буй компани.

**240. Transparency – Ил тод байдал**

Мэдээллийн харагдмал, нээлттэй байдал, ялангуяа, бизнес арга барилын тухайд.

**241. Treasury stock – Сангийн хувьцаа**

Үнэт цаасны зах зээлд дээр гаргахгүй байх эсвэл олон нийтэд дахиж арилжаалах зорилгоор худалдаж авсан өөрийн компанийн хувьцаа.

**242. Two-tiered board system - Хоёр шатлалтай ТУЗ-ийн тогтолцоо**

Компанийн засаглалыг хоёр төлөөлөн удирдах зөвлөлөөр хэрэгжүүлдэг. Дээд шатлалын ТУЗ нь гүйцэтгэх удирдах зөвлөлийг хянадаг.

**243. Venture capital fund - Эхлэлийн үйл ажиллагааг дэмжих сан**

Анх хувьцаагаа гаргаж буй компаниудыг дэмжиж, хувьцааг нь худалдан авч мөнгөн хөрөнгө олгодог сангууд.

**244. Viligant board - Хянамгай төлөөлөн удирдах зөвлөл**

Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалан, хянадаг ТУЗ.

**245. Whistleblower - “Мэдээлэгч”**

Өөрийн компанийн дотор явагддаг хууль бус үйл ажиллагааны тухай нийтэд зарлан мэдээлэгч.

**246. Whistleblower protection - “Мэдээлэгч”-ийн эрхийг хамгаалах**

Гомдол гаргасан хүний талаарх хувийн мэдээллийг хамгаалах журам дүрмүүд.

a

b

c

d

e

f

g

h

i

j

k

l

m

n

o

p

q

r

s

t

u

v

W

x

y

z



Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх боломжтой түгээмэл нэр томъёоны толийг олны дэмжлэгтэйгээр, мөн хуучин Оксфорд Монсудар Англи Монгол толь, Коллинзийн Англи Монгол толь, Британника нэвтэрхий толийг орчуулагчдын багт орон ажиллаж байсан туршлагадаа дулдуйдан эмхэтгэж гаргалаа.

Энэхүү толины анхны хувилбарыг олон нийтэд таниулахад туслалцаа үзүүлсэн Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, “Ресурс Инвестмент Капитал” компанид талархлаа илэрхийлэхийн ялдамд та бүхэнд өргөн толилуулж байгаа энэхүү толийг бүтээх, ялангуяа нэр томъёоны санг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Саруул, Үнэт цаасны газрын мэргэжлийн оролцогчдын хэлтсийн дарга А.Авир, Үнэт цаасны газрын бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах хянан шалгагч Н.Мөнхцэлмэг, Үнэт цаасны газрын үнэт цаас гаргагчдын хэлтсийн хянан шалгагч Н.Мөнгөнчимэг болон үнэт цаасны мэргэжилтэн Т.Ичинноров, “Рескап” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Энхбаяр, “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх Мон004” төслийн удирдагч Л.Болдбаатар нарт баярласнаа илэрхийлье.

**Ж.Үнэнбат**

*(Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн  
Гүйцэтгэх захирал)*

## **САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

Монгол Улс, Улаанбаатар хот 15160,  
Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3,  
Засгийн Газрын IV байр.  
210644 Улаанбаатар, Монгол улс

Утас: +(976)-266420  
Факс: +(976)-329084, 7011-7047

[www.frc.gov.mn](http://www.frc.gov.mn)

## **ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ**

Улаанбаатар дахь оффис,  
MCS Плаза оффис, 4-р давхар,  
Сөүлийн гудамж,  
210644 Улаанбаатар, Монгол

Утас: +(976)-7007-8286  
Факс: +(976)-7007-8285

[www.ifc.org](http://www.ifc.org)

## **МОН/004 САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТӨСӨЛ**

Монгол Улс, Улаанбаатар хот 15160,  
Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3,  
"Жи-Мобайл" оффис центр 302 тоот  
210644 Улаанбаатар, Монгол улс

Утас: +(976)-70127047  
[www.luxdev.lu](http://www.luxdev.lu)

